



ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙ РҮҮ ХАМТДАА ТҮРҮҮЛЖ АЛХАНА

Юнител группийн
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН 2024





БОНЗ-ЫН ЗАСАГЛАЛ

- 3 Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- 4 Компанийн засаглал
- 5 Тогтвортой байдлын засаглал
- 6 Материаллаг байдлын үнэлээ
- 7 Оролцогч талууд



ТЕХНОЛОГИ

- 10 Сүлжээний чанар, найдвартай байдал
- 13 Мэдээллийн аюулгүй байдал
- 14 Цахим шилжилт
- 16 Үйлчилгээний ил тод байдал



ХҮН

- 19 Цахим хуваагдлыг бууруулах ажлууд
- 23 Нийгэмд тустай ажлууд
- 28 Компанийн соёл
- 32 Олон талт оролцоот, ижил тэгш байдал
- 35 Ажилтнуудын сайн сайхан байдал
- 38 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
- 42 Бизнесийн ёс зүй
- 45 Ханган нийлүүлэгчдийн тогтвортой байдал



БАЙГАЛЬ

- 47 Электрон хог хаягдлын менежмент
- 49 Байгаль хамгаалал
- 54 Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч



ХАВСРАЛТ

- 60 БОНЗ-ын материаллаг асуудлууд ба тэдгээрийн тайлбар
- 61 Тайлагналын олон улсын санаачилга (GRI)-ын индекс
- 64 Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн индекс



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Дижитал технологи, харилцаа холбооны салбарын эрчимтэй хөгжил нь зөвхөн өнөөгийн бидний амьдралыг төдийгүй ирээдүй хойч үеийнхний амьдрах орчин, аж төрөх хэв маягийг цоо шинээр тодорхойлж байна. Ухаалаг холболт, бодит өгөгдөлд суурилсан шийдлүүд, хүний чадавхыг тэлэх хиймэл оюун ухаан, хязгааргүй боломжийг нээх үүлэн технологи нь бидний харилцах арга барилыг хувьсгаж, нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хурдасгах шинэ боломжуудыг бий болгож байна.

Юнител групп энэхүү дижитал эрин зууны тэргүүн эгнээнд алхаж, бүтээж буй бүхий л технологийн дэвшлээ хариуцлагатай, тогтвортой хөгжлийн үнэт зүйлстэй уялдуулан нийгэмдээ хүргэхийг эрхэм зорилгоо болгосоор байна. Манай алсын хараа бол хүн бүрийг дижитал ертөнцөд зөвхөн холбоод зогсохгүй, энэхүү холболтыг бүх нийтэд хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй, ёс зүйн хэм хэмжээг сахисан хөгжлийн үндэс суурь болгох явдал юм.

Бид уламжлалт харилцаа холбооны үйлчилгээнээс давж, технологийн экосистемийг дэмжигч, интеграцчилсан хөгжүүлэгч компани

болон өргөжиж байна. Энэ нь бизнесийн өсөлтийг хангахаас гадна нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих чухал алхам бөгөөд бид дижитал шийдлүүд, инновацийн экосистемийг хөгжүүлснээр бусад бизнес эрхлэгчид, стартапууд, төрийн болон төрийн бус байгууллагуудын өсөлт, нөлөөллийг улам бүр дэмжих зорилготой.

Бид ирээдүйг зөвхөн технологийн ололт амжилтаар бус, тэдгээрийг нийгэм, бизнесийн орчин болон оролцогч талуудын сайн сайхан, тогтвортой байдалд хэрхэн эерэгээр нөлөөлж байгаагаар хэмжих ёстой гэдэгт итгэдэг. Юнител групп тогтвортой ирээдүйг цогцлоох үйлсэд манлайлагч байж, технологийн хүчээр нийгэмд бодит өөрчлөлт, үнэ цэнийг бий болгохын төлөө үргэлж тууштай ажиллах болно. Энэхүү эрхэм зорилгыг биелүүлэхэд бидний хамгийн том хамтрагчид бол хэрэглэгчид, харилцагчид маань билээ. Хэрэглэгчид, харилцагчид маань бидэнтэй хамт байж, тогтвортой хөгжлийн төлөөх бидний нийтлэг хүчин чармайлтыг ахиулж байгаа юм.

Тогтвортой ирээдүй рүү хамтдаа түрүүлж алхъя.

Гүйцэтгэх захирал

Дорждагвын ЖАМЬЯНШАРАВ





Компанийн засаглал

Юнител группийн засаглал нь хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын урт хугацааны өгөөжийг нэмэгдүүлэх, бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангахад чиглэдэг. Мөн манай засаглалын тогтолцоо нь баримтад суурилсан шийдвэр гаргалт, зохицуулалтын нийцэл болон гүйцэтгэлийн хяналтаар дамжуулан хариуцлагатай, тогтвортой, ёс зүйтэй бизнесийн орчныг бүрдүүлдэг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)

Менежментийн үйл ажиллагааг хянаж, Юнител группийн урт хугацааны үнэ цэнийг өсгөхөд чиглэсэн стратегийн зөвлөгөө өгдөг. Мөн группийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээс гадна байгууллагын эрсдэл, мэдээллийн аюулгүй байдал болон БОНЗ-ын асуудлуудын талаар менежментийн баг болон ТУЗ-ийн хорооноос нэмэлт мэдээллүүдийг тогтмол авдаг.

НЭР ДЭВШҮҮЛЭХ БОЛОН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО	АУДИТ БОЛОН ЭРСДЭЛИЙН ХОРОО	САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХОРОО	БОНЗ-ЫН ХОРОО
Удирдах ажилтныг нэр дэвшүүлэх болон тэдний цалин урамшууллын бодлогыг компанийн урт болон богино хугацааны зорилгууд, хүний нөөцийн менежментийн стратегитай уялдаатай байхад хяналт тавих, түүний хэрэгжилтийг хангах үүрэгтэй.	Группийн санхүүгийн тайлан, хөндлөнгийн болон дотоод аудитын чанар, шударга байдлыг хянах, хууль эрх зүй, зохицуулалтын орчны комплаенсийг хангах, эрсдэлийн удирдлага, бодлогын хяналт болон группийн стратегийн эрсдэлийг удирдах үүрэгтэй.	Групп компаниудын богино болон урт хугацааны санхүүгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон санхүүгийн үзүүлэлтүүдийг хянах үүрэгтэй.	Группийн компаниудын үйл ажиллагаа БОНЗ-ын бодлого болон холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг хянах, материаллаг асуудлуудын оновчтой удирдлага, зохицуулалтаар хангах үүрэгтэй.
Жилд хамгийн багадаа дөрвөн удаа хуралдана.	Жилд хамгийн багадаа дөрвөн удаа хуралдана.	Жилд хамгийн багадаа дөрвөн удаа хуралдана.	Жилд хамгийн багадаа дөрвөн удаа хуралдана.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

ТУЗ-ийн олон талт байдал

Оролцогч талуудын ашиг сонирхлыг бүрэн төлөөлж чадах мэдлэг, туршлага бүхий хувь хүмүүсээр ТУЗ-өө бүрдүүлсэн. 2024 онд Юнителийн ТУЗ нь үндсэн таван гишүүнтэй байсан бөгөөд үүнд олон улсын туршлагатай хараат бус нэг гишүүн оролцсон. Мөн нэг орлох гишүүн, саналын эрхгүй нэг ажиглагч гишүүнтэй, нийт долоон хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

20%

Саналын эрхтэй гишүүдийн 20% нь эмэгтэй гишүүд байна.

43%

43% нь 50-иас доош насны залуу захирлууд байна.

2024 онд, ТУЗ болон түүний дэргэдэх хороод:

4 удаа
хуралдсан

3 удаа
зайнаас буюу
видео дуудлага хэлбэрээр

1 удаа
Улаанбаатар хотноо биечлэн

Нийт
46
шийдвэр гаргажээ



Тогтвортой байдлын засаглал

Юнител групп тогтвортой байдлын зарчмуудыг компанийн стратеги болон өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг. БОНЗ-ын хяналт нь компанийн болон хувь эзэмшигчдийн хүрээнд олон түвшинд хэрэгждэг бөгөөд чиглэл хоорондын хамтын ажиллагааг дэмжих, шийдвэр гаргалтад оролцогч талуудын ашиг сонирхлыг тусгахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын хяналт

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь бизнесийн шийдвэр гаргалтад тогтвортой байдлын шийдлүүдийг тусгахдаа БОНЗ-ын материаллаг асуудлуудын үр нөлөө, эрсдэл, боломжуудыг үнэлж, стратегийн хяналт тавьдаг. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь БОНЗ-ын санаачилгуудыг хянах, зохицуулалтын нийцлийг хангах, эрсдэлийг удирдах, тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг санхүүгийн болон стратегийн зорилтуудтай уялдуулах үүрэгтэй.

Юнител групп бизнесийн үйл ажиллагааныхаа чиглэл бүрд байгаль орчин, нийгмийн асуудлуудыг уялдуулан авч үздэг бөгөөд тогтвортой байдлын төлөө хүчин чармайлтаа сайжруулахад бүхий л оролцогч талыг дэмжин, хамтран ажиллаж байна. Энэ ч утгаараа Юнител группийн Маркетинг хариуцсан дэд захирал нь БОНЗ-ын бодлогын төвлөрсөн хэрэгжилт, тайлагналыг удирдан зохицуулдаг бол менежментийн багийн бусад бүх захирал өөрийн хариуцсан газарт тогтвортой байдлын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, хэрэгжилтийг хангадаг. Энэхүү дээрээс чиглэсэн засаглал нь шийдвэр гаргалтын түвшинд БОНЗ-ын асуудалд онцгой анхаарал хандуулахыг дэмжихийн зэрэгцээ тогтвортой байдлын гүйцэтгэлийг удирдах түвшинд хэлэлцэж, байгууллага даяар үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Чиглэл хоорондын БОНЗ-ын хэрэгжилт


Юнител групп бизнесийн тогтвортой үйл ажиллагаанд бүх газар, нэгжүүдийн тэнцүү хувь нэмэр чухал гэж үзэн, компанийн хэмжээнд БОНЗ-ын зарчмуудыг нэвтрүүлж хамтын хариуцлагын соёлыг төлөвшүүлсэн. Тогтвортой байдлын засаглалын бүтцийг оновчтой бүрдүүлж, гүйцэтгэх удирдлага болон газар, нэгжүүдийн уялдаа холбоог хангаснаар, БОНЗ-ын асуудлууд стратегийн өндөр ач холбогдолтой сэдэв болж өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй хэсэг болсон.

Юнител группийн Тогтвортой байдлын баг нь Маркетинг хариуцсан дэд захирлын удирдлага дор ажиллаж, компанийн тогтвортой байдлын гүйцэтгэлийг өдөр тутам хянаж, тайлагналын үйл явцыг удирддаг. Тус баг нь компанийн материаллаг сэдвүүдийг тодорхойлон үнэлж, БОНЗ-ын стратегийн чиглэлүүдийн хэрэгжилтийг зохицуулан, газар нэгжүүдийг шаардлагатай зөвлөмж, удирдамжаар хангах үүрэгтэй. Мөн БОНЗ-ын асуудлуудыг шийдвэр гаргалтад болон компанийн үйл ажиллагаанд оновчтой нэгтгэхийг зорьдог. Компанийн газар нэгжүүд нь өөрсдийн үйл ажиллагаанд хамаарах БОНЗ-ын хэрэгжилт, үр нөлөөг тогтмол тайлагнаж, Тогтвортой байдлын багтай нягт хамтран ажилладаг. Тогтвортой байдлын баг нь тус мэдээллийг нэгтгэж, ТУЗ-ийн дэргэдэх БОНЗ-ын хороонд шаардлагатай мэдээллийг хүргэн ажилладаг.



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

БОНЗ-ын материаллаг асуудлуудыг бизнесийн үйл ажиллагаа, урт хугацааны стратеги төлөвлөлтөд нэгтгэхэд хяналт тавьж, стратегийг тодорхойлж, тэдгээрийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах үүрэгтэй



ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БАГ

Материаллаг байдлын үнэлгээг удирдан чиглүүлж, чиглэл хоорондын уялдаа холбоог зохицуулж, газар нэгжүүдийг зөвлөмж, удирдамжаар ханган, тогтвортой байдлын санаачилгуудад хяналт тавьж, компанийн БОНЗ-ын гүйцэтгэлийг оролцогч талуудад тайлагнах үүрэгтэй

Юнител групп тогтвортой байдлын засаглалын бүтэц оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхойлон тогтоож, мэдээлэл дээр суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих замаар тогтвортой хөгжлийг компанийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болгон бэхжүүлж байна.

Тайлагнах

БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээ

Юнител групп 2023 онд байгаль орчин, нийгэм, засаглалын материаллаг байдлын үнэлгээг анх удаа хийж, компанийнхаа БОНЗ-ын асуудлуудыг нарийн тодорхойлон, үнэлсэн билээ. Ингэснээр байгууллагын тогтвортой байдлын хамрах хүрээ, үнэт зүйлс илүү тодорхой болж, тэдгээрийг сайжруулах, олон нийтэд таниулахад ихээхэн ач холбогдолтой.

Материаллаг асуудал гэдэг нь компанийн үнэ цэнд нөлөөлөх бүхий л асуудлыг хамруулдаг ойлголт юм. Уг ойлголтыг үнэлж эрэмбэлэхийн

тулд бид БОНЗ-ын асуудал тус бүрийн бизнес болоод оролцогч талд үзүүлэх нөлөөг үнэлэх дөрвөн шатлалт процессын арга зүйг ашигласан. Үүнд, БОНЗ-ын стандартуудтай уялдуулсан дүн шинжилгээ, оролцогч талуудтай хийсэн ярилцлага, асуулт хариулт зэрэг багтсан болно.

Компанийн тогтвортой байдалд нөлөөлөх гол асуудлуудыг тодорхойлон үнэлэх нь БОНЗ-ын хамрах хүрээ, тогтолцоог бий болгох, сайжруулахад өндөр ач холбогдолтой байдаг.

Өмнө дурдсанчлан бид уг үнэлгээний үр дүнг компанийн БОНЗ-ын тогтолцоог оновчлох, энэ талаар олон нийтэд мэдээлэл түгээхэд ашиглах юм.

Бид 2025 онд материаллаг байдлын үнэлгээг дахин хийж компанийн ач холбогдол бүхий чиглэлүүдийг шинээр эрэмбэлэхээр төлөвлөж байна. Ингэхдээ байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллөөс гадна санхүүгийн үзүүлэлтүүдийг харгалзаж, цогц үнэлгээ хийх болно.



Үнэлгээний процесс

Нэгдүгээр ахлам:

Гадаад орчныг судалж материаллаг асуудлуудыг тодорхойлох

- Салбарын тайлагналд бенчмаркинг, харьцуулалт хийх
- Тэргүүлэх БОНЗ болон тогтвортой байдлын тайлагналын стандартуудыг судлах (SASB, GRI, TCFD гэх мэт)
- Салбарын үйл ажиллагаанд ач холбогдол бүхий БОНЗ-ын материаллаг асуудлуудыг тодорхойлох (байгаль орчны 5 асуудал, нийгмийн 7 асуудал, ажилтны 4 асуудал, засаглалын 10 асуудал)

Хоёрдугаар алхам:

Оролцогч талуудыг хамруулан үнэлгээний өгөгдлийг цуглуулах

- Менежментийн багийн гишүүдээс ярилцлага болон асуулгын аргаар өгөгдөл цуглуулах
- Компанийн нийт ажилтныг төлөөлөх түүврээс асуулгын аргаар өгөгдөл цуглуулах
- БОНЗ-ын хорооны захирлуудаас ярилцлага болон асуулгын аргаар өгөгдөл цуглуулах

Гуравдугаар алхам:

Материаллаг асуудлуудыг эрэмбэлэх


- Цуглуулсан өгөгдлийг боловсруулах, дүн шинжилгээ хийх
- Материаллаг асуудлуудыг эрэмбэлэх

Дөрөвдүгээр ахлам:

Үр дүнг хэрэгжүүлэх

- БОНЗ-ын тайлагналыг уялдуулж, оролцогч талуудыг хамруулах

2023 оны материаллаг байдлын үнэлгээний үр дүн



Түвшин тус бүрд асуудлуудыг цагаан толгойн дарааллаар эрэмбэлэв.



Оролцогч талууд

Оролцогч талуудтай БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээг хийж, тогтмол уулзалт зохион байгуулахаас гадна и-мэйлээр харилцаж Юнител группийн үйл ажиллагаа, тогтвортой байдлын арга хэмжээнүүдийн тухай мэдээлэл солилцдог.

Оролцогч тал	Харилцдаг сувгууд	БОНЗ-ын хамааралтай асуудлууд
<p>Хэрэглэгчид</p> <p>Бид хэрэглэгчдэдээ найдвартай, аюулгүй, үнэ цэнтэй үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэдэг.</p>	<ul style="list-style-type: none"> Зах зээлийн судалгаа Үйлчилгээний салбар болон ажилтнууд И-мэйл, сошиал сувгууд 	<ul style="list-style-type: none"> Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг ба цахим хаягдлын зохицуулалт Цахим хуваагдал ба үнийн хүртээмжтэй байдал Үйлчилгээний хүртээмжтэй байдал Бүтээгдэхүүн үйлчилгээний аюулгүй байдал болон хариуцлагатай хэрэглээ Сүлжээний чанар, найдвартай байдал Хувийн нууц
<p>Хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчид</p> <p>Үнэн зөв мэдээлэл солилцож, итгэлцэлд суурилсан харилцаа бий болгохыг эрхэмлэдэг.</p>	<ul style="list-style-type: none"> Биечлэн уулзах болон и-мэйл харилцаа холбоо Улирал тутмын тогтмол уулзалт 	<ul style="list-style-type: none"> БОНЗ-ын материаллаг бүх асуудал
<p>Ажилтнууд</p> <p>Бид ажилтнууддаа сэтгэл хангалуун ажиллах боломж бүрдүүлэхийг зорьдог</p>	<ul style="list-style-type: none"> Ажилтнуудыг хамруулсан санал асуулга Сайн дурын хөтөлбөрүүд И-мэйл, товхимол, Teams Удирдах түвшний ажилтнуудын уулзалт Багийн уулзалт, сургалт 	<ul style="list-style-type: none"> Ажилтны олон талт, тэгш байдал, оролцоо Ажилтны эрүүл мэнд, аюулгүй, сайн сайхан байдал Ажил горилогчийг татах, ажилтны оролцоог нэмэгдүүлэх, ажилтныг хадгалж үлдэх Хүний эрх
<p>Нийгмийн бүлгүүд</p> <p>Бид үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд хот суурин болон орон нутаг дахь нийгмийн бүлгүүдтэй хамтран ажилладаг.</p>	<ul style="list-style-type: none"> Ивээн тэтгэлэг, хандив Нийгмийг хамарсан арга хэмжээнүүд Сайн дурын арга хэмжээ, ажлын байрны нээлттэй өдөрлөгүүд Салбар холбоодын уулзалтууд Салбарын болон нийгмийн гишүүнчлэл, уулзалтууд Биечилсэн уулзалтууд 	<ul style="list-style-type: none"> Цахим хуваагдал ба үнийн хүртээмжтэй байдал Олон нийтийн оролцоо ба хандив
<p>Нийлүүлэгчид</p> <p>Нийтлэг үнэт зүйл, тогтвортой байдлын зорилт бүхий нийлүүлэгчидтэй урт хугацаанд харилцан ашигтай хамтран ажилладаг.</p>	<ul style="list-style-type: none"> Нийлүүлэгчдийн бүртгэл Нийлүүлэгчдийн асуулга Ганцаарчилсан уулзалтууд Нийлүүлэгчийн үнэлгээ 	<ul style="list-style-type: none"> Нийлүүлэлтийн гинжин хэлхээн дэх хариуцлага, тогтвортой, олон талт байдал Бизнесийн ёс зүй, соёл Зохицуулалтын орчны нийцэл





“Тогтвортой ирээдүй рүү хамтдаа”

Юнител групп Монгол Улсын нийгэм, эдийн засагт томоохон нөлөө үзүүлэгч компанийн хувьд нийгэм, байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэдэг. Үүний хүрээнд бид бүх төрлийн оролцогч талуудыг мэдээллээр хангах зорилгоор Тогтвортой байдлын тайланг жил бүр олон нийтэд ил тод танилцуулдаг болсон. Ингэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой байдлын тайлагналын стандарт, удирдамжийг баримталж байна.

Юнител групп 2023 оны Тогтвортой байдлын тайланг олон нийтэд нээлттэй танилцуулах, тайланд дурдагдсан төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Тогтвортой ирээдүй рүү хамтдаа” кампанит ажлыг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү кампанит ажил маань дараах үндсэн 3 хэсгээс бүрдсэн:

PHASE 1. Гүйцэтгэх захирлын зурвас:

Юнител группийн Гүйцэтгэх захирал 2023 оны Тогтвортой байдлын тайланг албан ёсоор олон нийтэд танилцуулж, компанийн БОНЗ-ын хүрээнд баримталж буй зарчим, хүрэх зорилтуудыг дурдаж, оролцогч талуудын дундах мэдлэгийг нэмэгдүүлсэн.



PHASE 2. Тайлан руу хөтлөх контент:

Бид 2023 оны Тогтвортой байдлын тайлангаа байршуулах веб хуудас хөгжүүлж, оролцогч талуудыг тэрхүү хуудас руу хөтлөх олон төрлийн мэдээлэл, контентуудыг бэлтгэж, өөрийн болон гаднын мэдээллийн сувгуудаар түгээсэн.

ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙ РҮҮ ХАМТДАА



unitel.mn/sustainability

PHASE 3. Эх дэлхийн өдрийг тохиолдуулсан арга хэмжээ:

Эх дэлхийн өдрийг тохиолдуулан Shangri-La Mall-д 4 хоногийн түрш арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд тус арга хэмжээгээр электрон хог хаягдлын менежмент, Хөв цөөрөм төсөл, Unitel STEAM HUB хөтөлбөр зэрэг 2023 онд тогтвортой байдлын чиглэлд хэрэгжүүлсэн томоохон санаачилгуудаа технологийн дэвшилд суурилан, интерактив байдлаар танилцуулсан.



ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙ РҮҮ ХАМТДАА

4 сарын 22 - 25 | Shangri-La Mall

Энэхүү цогц ажлын хүрээнд бид

1.5 сая хүнд мэдээлэл хүргэсэн

Арга хэмжээ дээр **1,000+** гаруй хүн хүрэлцэн ирсэн





ТЕХНОЛОГИ

1 Сүлжээний чанар, найдвартай байдал

2 Мэдээллийн аюулгүй байдал

3 Цахим шилжилт

4 Үйлчилгээний ил тод байдал



Сүлжээний чанар, найдвартай байдал

Харилцаа холбоо нь холыг ойртуулж, хот хөдөөгийн ялгааг багасгахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөгжлийг хурдасгах чухал үүрэгтэй. Мэдээллийг биетээр дамжуулах хэрэгцээ багасаж буй нь байгалийн нөөцийн зарцуулалтыг бууруулж, хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулж, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулсаар байна. Түүнчлэн онцгой нөхцөл байдлын үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад харилцаа холбоо онцгой ач холбогдолтой хэвээр байна.

Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж буй аливаа компанийн хувьд сүлжээний чанар, найдвартай байдал нь бизнесийн өсөлт, өрсөлдөх чадварт шууд нөлөөлдөг. Хэрэглэгчдэд тасалдалгүй, чанартай, найдвартай үйлчилгээ үзүүлэх зорилгоор сүлжээний дэд бүтэц болон үйл ажиллагаанд технологийн сайжруулалтуудыг хийж, шинэ технологиудыг нэвтрүүлж, тогтмол хяналт шалгалтуудыг хийх нь маш чухал.

Юнител групп нь хэрэглэгчдэдээ хэвийн, найдвартай, тасралтгүй үйлчилгээ үзүүлж, аливаа гэмтэл, саатлаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг шуурхай илрүүлэн шийдвэрлэх бодлогыг баримталдаг. Бид өөрсдийн сүлжээний багтаамжийг тодорхойлж, чанарын үзүүлэлтүүдийг олон улсын стандартад нийцүүлэн ажиллахаар зорьдог билээ.

Сүлжээний найдвартай байдлын зохицуулалт

Юнител групп Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагуудыг хангаж ажилладаг. Мөн үүрэн холбооны сүлжээний багтаамж ашиглалт болон чанарын үзүүлэлтүүдийг Олон улсын цахилгаан холбооны хороо (ITU), Олон улсын GSM-ын холбоо (GSMA), Олон улсын үүрэн холбооны стандартчиллын байгуулга (3GPP), Мэдээлэл Холбооны Технологийн Удирдлагын Төв (ICTA), Европын Харилцаа Холбооны Стандартын Институт (ETSI) зэрэг байгууллагуудын зөвлөмж стандарт дээр үндэслэн тодорхойлж байна.

2021 онд компанийн дотооддоо шинэчлэн баталсан "Гэмтэл, саатлын үед ажиллах журам" нь техник болон программ хангамж, сүлжээний хэвийн ажиллагааг хангах, учирч болзошгүй гэмтэл саатлыг тодорхойлох, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, гомдол мэдээллийг хүлээн авч шуурхай засварлах, доголдол саатлыг хэвийн болгох үйл ажиллагааг зохицуулдаг. Бид үндсэн сүлжээнд гэмтэл гаргахгүй байх, бааз станцууд дээр гарч байгаа доголдлын тоог тогтмол бууруулах зорилтын дагуу олон төрлийн төлөвлөгөөт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

2024 оны байдлаар:

Бааз станцууд дээр гарсан нийт доголдлын бууралтын хувь (2023 онтой харьцуулахад): **23%**





Эрсдэлийн менежмент

Юнител групп болзошгүй гэмтэл саатал, сүлжээний тасалдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр Дата төв болон үүрэн холбооны бааз станц, систем, тоног төхөөрөмжүүд дээр үзлэг шалгалт, эрсдэлийн үнэлгээ хийдэг. Бид эрсдэлийн үнэлгээний үр дүн дээр тулгуурлаж шаардлагатай сайжруулалтуудыг хэрэгжүүлж, сүлжээний доголдлыг бууруулж, найдвартай байдлаа хангадаг. 2024 онд бид Дата төвийн барилга, цахилгаан тэжээл, хөргөлт, хяналтын системүүд болон 700 гаруй үүрэн холбооны бааз станц дээр эрсдэлийн үнэлгээ хийж ажилласан байна.

Түүнчлэн өнгөрсөн жилүүдийн эрсдэлийн үнэлгээ дээр суурилан үндсэн сүлжээний томоохон системүүдийг, станц угсралтын стандарт, дүрэм журмыг шинэчилсэн.

Эрчим хүчний тасралтгүй хангамж

Монгол Улсын өргөн уудам газар нутагт өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэх, хэрэглэгчдийг чанартай, найдвартай сүлжээгээр хангаж ажиллахад олон саад бэрхшээлүүд тулгардгийн нэг нь цахилгаан эрчим хүчний найдвартай хангамж юм. Манай улсын эрчим хүчний системийн багтаамж, хүртээмжтэй байдал, дэд бүтцийн найдвартай байдал нь хязгаарлагдмал. Үүнийгээ дагаад цахилгаан эрчим хүчний тасалдал ихээр гардаг бөгөөд үүнээс шалтгаалж сүлжээний найдвартай байдлыг хангахын тулд нөөц эрчим хүчний эх үүсвэрүүд зайлшгүй байх шаардлага үүсдэг.

Иймд үүрэн холбооны станцуудыг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангах аргуудын нэг нь нөөц цахилгаан систем суурилуулах юм. Бид жил бүр үе шаттайгаар сүлжээний зангилаа, хэрэглэгчийн тоо, ачааллын үзүүлэлтүүдээс хамааран зэрэглэлийн хувьд хамгийн чухалд тооцогдох үүрэн холбооны бааз станцууд дээр нөөц цахилгаан үүсгүүрүүд буюу автомат генераторууд суурилуулж ирсэн. Энэ нь өргөн цар хүрээний тог тасралтын үед гарах гэмтэл саатлын түвшнийг бууруулдгаараа өндөр ач холбогдолтой.

2024 онд

100 Өндөр ач холбогдолтой 100 сайт дээр автомат генератор суурилуулсан

31% Өргөн хүрээнд цахилгаан тасрах тохиолдол 2.2 дахин өссөн ч үүнээс шалтгаалсан бааз станцуудын доголдлыг 31%-иар бууруулсан

Сүлжээний нэгдсэн хяналт

Сүлжээ, систем, тоног төхөөрөмжийн байнгын хяналт нь сүлжээний чанар, найдвартай байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай. Хяналтын системийн зөв шийдлийг тодорхойлж, түүнийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, асуудлыг цаг тухайд нь илрүүлж, богино хугацаанд арга хэмжээ авах боломжийг олгодог. Иймд бид нийт үүрэн холбооны дэд бүтцийн тоног төхөөрөмжүүдийг үе шаттайгаар нэгдсэн хяналтын системд холбох ажлыг хийж байна. 2024 онд бид нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр ажилладаг станцуудыг нэгдсэн хяналтын системд холбосон. Ингэснээр төлөвлөлт сайжирч сэргээгдэх эрчим хүчнээс шалтгаалсан гэмтэл буураад байна.

2024 онд

200 Нарны эх үүсвэрээр ажилладаг 200 сайтыг нэгдсэн хяналтын системд холбосон

50% Сэргээгдэх эрчим хүчнээс шалтгаалсан доголдол 50%-иар буурсан





Бүрэн автоматжуулсан сүлжээний хяналт – AUTIN

2024 онд Юнител групп бүрэн автоматжуулсан сүлжээний хяналтын төв (vNOC)-ийг бий болгох зорилгоор HUAWEI компанийн гаргасан Automation Intelligence System (AUTIN)-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүллээ. Энэхүү ухаалаг системийг 54 улсын 100 гаруй оператор компани ашигладаг бол Юнител групп Төв Азийн улсуудад анх удаа тухайн системийг нэвтрүүлээд байна.

AUTIN систем нь Монгол орныг бүрхсэн сүлжээний станц нэг бүрд гэмтэл саатал гарвал инженер, засварын ажилтан биеэр очих шаардлагагүйгээр автоматаар цаг алдалгүй гэмтлийг илрүүлдэг дэвшилтэт технологи юм. Мөн хол зайнаас гэмтлийг засварлаж, сүлжээний ачааллыг ухаалгаар удирдах боломжтой. Ингээд зогсохгүй ажилтнууд станцуудын хэвийн ажиллагааны мэдээллийг авч, хянах боломжийг олгосноор илүү таатай орчинд, түргэн шуурхай ажиллах боломж бүрдэж байгаа юм.

AUTIN нь eTOM болон ITIL зэрэг бизнесийн процессыг зохион байгуулах олон улсын удирдамж, стандартуудаар загварчлагдсан тул бид ч хэрэглэгчийн туршлагыг сайжруулахын хажуугаар өөрсдийн процессоо дахин инженерчилж чадлаа. Мөн бэлэн системийг шууд авч ашиглах бус манай инженер, техникийн ажилтнууд өөрсдийн өмнөх автоматжуулалтын туршлага болон хэрэгцээ шаардлагууд дээр үндэслэн нэмэлтээр 200 гаруй сайжруулалтыг санал болгож, хэрэгжүүлсэн.

Манай ажилтнууд энэ системд оруулсан нэмэлт сайжруулалтаараа дэлхийн харилцаа холбооны салбарынхан дижитал шилжилтийн стратеги, туршлагаа хуваалцдаг “Digital Transformation Innovation Contest 2024” арга хэмжээний үеэр “AUTIN-Outstanding Network Operations Award” шагналыг хүртсэн юм.



60%

AUTIN системийг нэвтрүүлснээр доголдлыг илрүүлэх, засварлах хугацааг 60%-иар бууруулсан





Мэдээллийн аюулгүй байдал

Дэлхий дахинаа интернэт, олон нийтийн сүлжээний хэрэглээ өсөх тусам цахим халдлагад өртөх эрсдэл жилээс жилд нэмэгдэж буй. Энэ нь компанийн болон хэрэглэгчийн нэн чухал мэдээллийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулаад зогсохгүй хууль эрх зүйн зохицуулалтын эрсдэлийг ч дагуулж байдаг. Иймд Юнител групп мэдээллийн аюулгүй байдлыг удирдах тогтолцоог тогтмол сайжруулж, оролцогч талууддаа аюулгүй дижитал орчныг бүрдүүлэхийг тууштай зорьж байна.


2024 онд Юнител групп мэдээллийн аюулгүй байдалд чиглэсэн хүчин чармайлтуудаа бэхжүүлж, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлүүдийг удирдаж, найдвартай байдлыг сайжруулахад төвлөрсөн билээ. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгын дор бид хувьсан өөрчлөгдөж буй аюул эрсдэлүүдийн эсрэг хамгаалалтаа сайжруулах, нэн чухал өгөгдлүүдийг хамгаалах, ажилтнуудынхаа мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мэдээллийн аюулгүй байдлын засаглал

Мэдээллийн аюулгүй байдлын хамгийн дээд стандартыг сахин биелүүлэх зорилгын хүрээнд бид гурав дахь жилдээ мэдээллийн аюулгүй байдал (МАБ)-ын удирдлагын тогтолцооны (ISMS) "алтан стандарт" гэж хүлээн зөвшөөрөгдсөн ISO 27001 стандартын гэрчилгээг авч, баримтлан ажиллаж байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн энэхүү гэрчилгээ нь мэдээллийн аюулгүй байдлын удирдлагаа сайжруулах хүчин чармайлтын гол илэрхийлэл юм. Уг стандартын дагуу бид олон талт бодлого боловсруулах, эрсдэлийн үнэлгээ тогтмол явуулах, нууц мэдээллийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа билээ.

Мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг түгээх

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлүүд хүний үйлдэлтэй шууд хамааралтай байдаг тул бид ажилтнуудынхаа хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг түгээх сургалт ордог. Уг сургалтад бид ажилтнуудаа 100% хамруулж чадсан. Ингэснээр бид бүх ажилтандаа боломжит аюул эрсдэлийг таних, хариу арга хэмжээ авах мэдлэгээр хангаж аюулаас сэргийлэх сонор сэрэмжтэй зан төлөвийг бий болгон ажиллаж байна.



Аюул эрсдэлийг илрүүлэх, бууруулах

2024 онд бид компани доторх мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалтыг эрс сайжруулж, урьд өмнө байгаагүй олон тооны цахим халдлагыг илрүүлж, сэргийлэх арга хэмжээ авсан:

- Цахим шуудангийн аюулгүй байдал: Фишинг довтолгоо (phishing) болон хууран мэхлэлт (spoofing) зэрэг цахим шуудангаар дамжсан 4.5 сая халдлагыг илрүүлэн эсрэг арга хэмжээ авч, нэн чухал өгөгдөл алдагдах, санхүүгийн залилан гарахаас сэргийлэв.
- Сүлжээ болон веб программын аюулгүй байдал: Жилээс жилд цахим халдлагын аюулын тоо хэмжээ нэмэгдэж байна. 2024 онд бид сүлжээ болон веб программтай холбоотой 12.3 сая халдлагыг илрүүлэн, эсрэг арга хэмжээ авсан. Энэ тоо нь өмнөх онтой харьцуулахад 3-5 дахин өссөн үзүүлэлт бөгөөд манай компанийн мэдээллийн аюулгүй байдлын хяналтын үр нөлөөг тодотгож байна.

Цаашид бид мэдээллийн аюулгүй байдлын удирдлагадаа шинэчлэлийг нэвтрүүлж, тасралтгүй хяналтыг зохион байгуулж, мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, шинэ төрлийн аюул эрсдэлд бэлтгэлтэй байж, тэдгээрээс бизнесийн үйл ажиллагаагаа хамгаалахад анхаарна.

2024 онд



ISO 27001:2022

гэрчилгээг гурав дахь жилдээ авсан




4.5 сая

Цахим шуудангаар дамжсан 4.5 сая халдлагыг илрүүлэн зогсоов



100%

Мэдээллийн аюулгүй байдлын сургалтад бүх ажилтныг хамруулав



12.3 сая

Сүлжээ болон веб программтай холбоотой 12.3 сая халдлагыг илрүүлж зогсоов



Дижитал шилжилт

Бизнесийн байгууллага, хэрэглэгч, хувь хүмүүсийн хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөнгөвчлөх ухаалаг цахим үйлчилгээнүүд бидний амьдралд өргөнөөр нэвтэрч, дижитал хэрэглээ зайлшгүй хэрэгцээ болсон. Энэ ч утгаараа бид уламжлалт бизнесийн үйл явц, үйлчилгээгээ шинэчилж, дижитал шийдлүүдийг нэвтрүүлэх замаар хэрэглэгчдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх боломжийг эрэлхийлдэг. Юнител групп дижитал шилжилтийг тэргүүлж, 100% дижитал харилцаа холбооны компани болох зорилго тавин ажиллаж байна.

Үйлчилгээний дижитал шилжилт

Юнител групп дижитал шилжилт хийснээр хэрэглэгчид хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээгээ илүү хурдан, хялбар авах нөхцөл бүрдсэн. Өмнө нь зөвхөн үйлчилгээний салбарт хандаж авдаг байсан үйлчилгээг дижиталаар шийдэж хэрэглэгчдийнхээ цаг хугацаа, зардлыг хэмнэсэн найдвартай үйлчилгээг санал болгон ажиллаж байна. Мөн алслагдсан бүс нутгийн иргэд, тусгай хэрэгцээт хэрэглэгчид, өндөр настнууд зэрэг цөөнх бүлгийн хэрэглэгчид орон зай, цаг хугацаанаас үл хамааран шаардлагатай мэдээллээ авч, асуудлаа шийдвэрлэх боломжтой болсон юм. Монголын хамгийн өргөн сүлжээтэй үүрэн холбооны

оператор компанийн хувьд энэ нь зөвхөн хэрэглэгчдэд төдийгүй бизнесүүдэд ч шинэ боломжуудыг нээж байна.

Бид хэрэглэгч төвтэй дижитал шилжилтийн зарчмыг баримтлан, аливаа шийдвэр, шинэчлэл бүрийг хэрэглэгчийн өнөөгийн түршлагыг сайжруулахад чиглүүлэн хэрэгжүүлж байна. Энэ нь нэвтрүүлж буй дижитал шийдэл, үйлчилгээ бүр хэрэглэгчийн хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн, бодит үнэ цэнийг бий болгоход төвлөрсөн шийдвэр гаргалтын процесс юм.



Онцлох цахим үйлчилгээ: Authentication

Дижитал шийдлээр дамжуулж үйлчилгээнийхээ хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 онд бид шинэ дугаар авах, сим сэргээх, дугаар хадгалах зэрэг хэрэглэгчдийн хамгийн их асууж, үйлчилгээний салбарт ханддаг 12 үйлчилгээг Unitel апп-т нэвтрүүлсэн нь хэрэглэгчдийнхээ нөөц, цаг завьг хэмнэсэн шийдэл болсон.

Unitel апп дээр үйлчилгээнүүдээ амжилттай цахимжуулахад суурь болсон гол бүрэлдэхүүн нь "Authentication" буюу "Баталгаажуулалт" юм. Монгол Улсын хуулийн дагуу хэрэглэгч шинэ дугаар авах, хуучин дугаараа сэргээх зэрэг үйлчилгээг авахдаа өөрийгөө албан ёсны бичиг баримтаар танин баталгаажуулах ёстой байдаг. Энэхүү процесс нь хэрэглэгчийг хувийн мэдээллээ хөндлөнгийн этгээдэд алдах, хуулийн болон санхүүгийн эрсдэлд орохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой тул уг процессыг цахим хэлбэр лүү шилжүүлэхдээ найдвартай, баталгаатай байдлыг хангахад өндөр анхаарал тавьж ажилласан.

Тиймээс бид Монгол Улсад болон олон улсад ашигладаг танин баталгаажуулалтын шийдлүүдийг судлан, Монгол улсын хууль эрх зүйн орчинд нийцсэн, боломжит эрсдэлүүдээс хамгаалсан, хэрэглэхэд хялбар Баталгаажуулалт /Authentication/-ын шийдлийг боловсруулж, дотооддоо хөгжүүлсэн. Уг шийдлээр хэрэглэгчийн мэдээллийг E-Mongolia платформоор баталгаажуулахаас гадна тухайн хүсэлт илгээж буй дугаарын эзэн өөрөө мөн эсэхийг батлах Liveness технологийг ашиглан, болзошгүй эрсдэлээс сэргийлж байна.

Бүх үйлчилгээг дижиталаар



Unitel app



Дата



ПУК код



Бусад үйлчилгээ



Хэрэглэгчдэд мэдлэг олгох

Дижитал хэрэглээ бидний өдөр тутмын амьдралын салшгүй хэсэг болсноор цахим орчныг зүй зохистой, ухаалгаар ашиглах, залилан болон эрсдэлээс өөрийгөө хамгаалах үр чадвар зайлшгүй хэрэгцээтэй болж байна. Үүний тулд хэрэглэгчид хангалттай мэдлэг, мэдээлэлтэй байх шаардлагатай. Хэрэглэгчдийн дижитал мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлснээр зөвхөн тэдний аюулгүй байдал сайжраад зогсохгүй, манай бизнесийн эрсдэл буурч, илүү шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, урт хугацааны үнэнч хэрэглэгчдийг бий болгох боломж бүрдэнэ.

Дижитал шилжилт хийхийн хэрээр компаниуд мэдээллийн аюулгүй байдлаа өндөр түвшинд хадгалах, ажилтнаас хамаарах эрсдэлийг бууруулж, автоматжуулалт ба хүний оролцооны тэнцвэрийг хангах, шинэ технологийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд хөрөнгө оруулах зэрэг асуудлуудад онцгойлон анхаарах шаардлагатай болдог. Эдгээр асуудал нь дижитал шилжилт хийж буй бүх компанийн зайлшгүй шийдвэрлэх ёстой сорилтууд бөгөөд өнөөдрийн бизнес орчны бодит шаардлага болж байна.

Юнител групп хэрэглэгчдийнхээ дижитал мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийн цахим сувгуудаар тогтмол, системтэй заавар, зөвлөмж хүргэхээс гадна, үйлчилгээний салбаруудаар дамжуулан биет сургалт зохион байгуулах, сэрэмжлүүлэг мэдээлэл түгээх зэрэг ажлуудыг тасралтгүй хэрэгжүүлж байна. 2024 онд бид хэрэглэгчдэд Unitel апп-аас авах үйлчилгээ болон баталгаажуулалт (authentication) хийх үйл явц, хялбар бөгөөд найдвартай гэдгийг таниулахад онцгойлон анхаарлаа. Мөн өөрийгөө баталгаажуулсны дараа цахимаар авах боломжтой үйлчилгээнүүдийн заавар, зөвлөмжийг хүргэх кампанит ажлыг амжилттай хэрэгжүүлсэн юм.

Үйл ажиллагааны дижитал шилжилт


Орон нутгийн харилцагч нартай цахимаар гэрээлэх

Юнител групп 100% дижитал харилцаа холбооны компани болох зорилгынхоо хүрээнд зөвхөн хэрэглэгчдэд санал болгох бүтээгдэхүүн, үйлчилгээгээ цахимжуулахаас гадна компанийн дотоод үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлж байна. Үйл ажиллагааны процессуудыг дижитал шийдлээр автоматжуулах, хялбаршуулах нь зөвхөн компанийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлээд зогсохгүй байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх чухал алхам юм. Юнител групп орон нутгийн хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэхийн тулд олон байгууллагатай хамтран ажилладаг. Өмнө нь эдгээр байгууллагатай хийдэг гэрээ,

албан бичиг, тооцооны баримтууд нь цаасны өндөр хэрэглээ, шуудангийн зардал, ажлын хоногийн алдагдал зэрэг сул талуудыг дагуулдаг байсан бол 2024 онд бид орон нутгийн нийт 26 харилцагч компаниа хийдэг цаасан гэрээгээ цахимжууллаа. Хамтрагч байгууллагуудын удирдлагын гарын үсгийг баталгаат V-Sign платформоор бүртгэж, цахимжуулсан бөгөөд хоёр жил тутам шинэчлэгддэг гэрээ болон сар бүр солилцдог тооцооны бичиг баримтыг цахим платформоор дамжуулан баталгаажуулдаг болсон. Энэ өөрчлөлтийн үр дүнд бид цаасны хэрэглээг бууруулж, шуудангийн зардал, цаг хугацааг ч хэмнэх болсон. Цаашид ч бид дижитал шилжилтээ өргөжүүлж, байгальд ээлтэй, хялбар шийдлүүдийг нэвтрүүлэхэд анхаарсаар байх болно.




2024 онд



82%
Unitel апп ашигладаг хэрэглэгчдийн тоо 82%-иар нэмэгдсэн



400,000
хэрэглэгч сард 1.2 сая удаагийн үйлчилгээг салбарт хандахгүйгээр Unitel апп-аас авч байна



Дижитал үйлчилгээ цаг хэмнэдэг

Өмнө

Хэрэглэгч салбарт ирж үйлчилгээ авах, дараалал хүлээх, явах гээд дунджаар

1 цаг зарцуулдаг

Одоо

Unitel апп дээр

2 минут зарцуулж
хүссэн үйлчилгээгээ авах боломжтой



Үйлчилгээний ил тод байдал

Технологи хөгжихийн хэрээр дижитал шийдлүүд нарийн төвөгтэй болж, хэрэглэгчид худалдан авч буй үйлчилгээнийхээ талаар тодорхой, хүртээмжтэй, үнэн зөв мэдээлэлтэй байх нь улам чухал болж байна.

Юнител групп хэрэглэгчийн туршлагыг нэн тэргүүнд тавьж, илүү ил тод, хэрэглэгч төвтэй харилцааг бий болгоход анхаарч ажилладаг. Үйлчилгээний ил тод байдал нь хэрэглэгчдэд зөв мэдээлэл хүргэхээс гадна итгэлцлийг нэмэгдүүлж, оновчтой шийдвэр гаргахад нь тусалдаг. Бид хэрэглэгчдээ шаардлагатай мэдлэг, мэдээллээр хангаж, үйлчилгээний талаарх ойлгомжгүй байдлыг багасгах ажлуудыг хийхийн зэрэгцээ худалдан авсан үйлчилгээгээ бүрэн, итгэлтэйгээр ашиглах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Юнивишнийн хэрэглэгчдийг мэдлэгжүүлэх

Хэрэглэгч өөрийн авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээний ажиллах зарчим, хэрэглээний функцуудын талаар бүрэн мэдээлэлтэй болсноор цаг хугацаа, зардлаа хэмнэхийн зэрэгцээ худалдан авсан үйлчилгээгээ бүрэн чадамжаар нь, зөв зохистой ашиглах боломжтой. Энэхүү зарчмыг баримтлан Юнивишн хэрэглэгчдээ мэдээллээр хангах зорилгоор “Хамтдаа Ухаалаг” нэртэй цуврал контент бүтээж, олон нийтийн мэдээллийн сувгуудаар түгээсэн. Тус контентоор дамжуулан хэрэглэгчдэд үйлчилгээний төв дээр очилгүй хаанаас ч, хүссэн цагтаа үйлчилгээгээ авах боломжтойг ойлгуулсан бөгөөд асуудлаа бие даан хурдан шийдвэрлэх арга замыг зааж өгсөн.

Бид цуврал контентын агуулга, сэдвийг Юнивишнийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой түгээмэл ирдэг асуултад тулгуурлаж тодорхойлсон. Мөн насны бүлэг тус бүрээс хамгийн их асуусан асууллауд, тэдний түлхүү хэрэглэдэг сошиал платформын онцлогт тохирсон контентын хэлбэр, дүрийн сонголтыг хийж ажилласан юм.

Видео суурьтай сувгууд



15 тайлбар видео | 9 богино мэдээлэлтэй видео
24 асуултад хариулсан

Текст суурьтай сувгууд



10 гаруй сэдвээр нийт 30 зурган контент

Олон нийтийн сувгаар дамжуулан хүргэсэн цуврал контентуудыг нийт 9,120,620 удаа үзсэн байна.

Юнивишнийн хэрэгцээт үйлчилгээг **Unitel** аппаас аваарай

- Түр салгах
- Төлбөр төлөх
- Админ дугаар солих
- Салаалах
- Хаяг шилжүүлэх
- Хэрэглээний дэлгэрэнгүй
- Шинэ хэрэглэгч

Үздэг байсан ТВ суваг маань яагаад алга болжов?

Гэрээний хугацаа дуусгавар болоход ТВ суваг Юнивишнээс буудаг

ТВ СУВГИЙН ГЭРЭЭ
Аливаа телевизийн сувгууд нь хамтарсан гэрээ байгуулж Юнивишнийн ТВ цэсэнд нэмэгддэг. Гэрээнд тухайн сувгийн хэдий хугацаанд байршуулах тухай заалт байдаг ба албан ёсны байрших хугацаа дууссан тохиолдолд тухайн суваг буудаг байна.

Юнивишнийн видео санд хэдэн кино байдаг бол?

Юнивишнийн видео санд нийт 20,000 кино контент байдаг.



Бидний Юнивишн

Ногоон гэр бүлийн гишүүн бүр Юнивишнийн чухал төлөөлөл байдаг. Гэр бүл, найз нөхөд нь тэднээс компанийн үйлчилгээний талаар асуухад бодит, итгэлтэй хариулт өгөх чадвартай байх нь чухал. Гэвч бүтээгдэхүүн хөгжүүлэлт, борлуулалтаас бусад чиглэлийн ажилтнуудад тэдгээр асуултууд нь хариулахад хүндрэлтэй байж болзошгүй тул зөвхөн хэрэглэгчдэд төдийгүй ажилтнуудаа ч мэдлэгжүүлэх хэрэгцээтэй байгааг тодорхойлсон. Тиймээс бид "Бидний Юнивишн" кампанит ажлыг хэрэгжүүлж, нийт ажилтнууддаа компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл өгч, зөв мэдээлэл түгээхэд дэмжлэг болохыг зорьсон юм.

Бид Юнивишнийн бүтээгдэхүүн үйлчилгээний тухай нийт 54 сэдвийг тодорхойлсон ба мэдээлэл хүргэлтийг оновчтой, үр дүнтэй явуулах үүднээс "Системийн өөрчлөлт", "Төлбөр тооцооны системийн сайжруулалт" болон "Хэрэглэгчийн зан төлөвтэй уялдуулан хийж буй сайжруулалтууд" гэх ач холбогдол хамгийн өндөр гурван сэдвээр ажлынхаа цар хүрээг тодорхойлсон. Уг ажлын онцлог нь эцсийн хэрэглэгч бус дотоод ажилтнууд руу чиглэсэн тул тэдний өдөр тутмын мэдээллийн урсгал дундаас ялгарч мэдээллээ илүү үр дүнтэй хүргэх арга замыг эрэлхийлэх байсан. Тиймээс бид Юнивишнийн үйлчилгээтэй холбоотой бодит амьдралын түүхүүд дээр тулгуурласан "Moments of us" комик цуврал бэлтгэж, ажилтнуудын дунд танин мэдэхүйн уралдаан зохион байгуулсан юм. Мөн үүнийгээ дэмжсэн контентуудыг бусад сувгаар түгээсэн.

Бидний UNIVISION

Сарын хугацаанд нийт 1,700 орчим ажилтанд дижитал суваг болон ажлын орчноор дамжуулан мэдээлэл хүргэсэн. Үр дүнд нь ажилтнууд компаниа эергээр харж, эргэн тойрныхондоо болон сошиал орчинд зөв мэдээллийг хүргэх нь нэмэгдсэн юм.



#QuizHint





ХҮН

1 Цахим хуваагдлыг
бууруулах ажлууд

3 Компанийн соёл

5 Ажилтнуудын сайн сайхан байдал

7 Бизнесийн ёс зүй

2 Нийгэмд тустай ажлууд

4 Олон талт оролцоот,
ижил тэгш байдал

6 Хөдөлмөрийн эрүүл мэнд,
аюулгүй ажиллагаа

8 Ханган нийлүүлэгчдийн
тогтвортой байдал



Цахим хуваагдлыг бууруулах ажлууд

Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн хүртээмж, иргэдийн цахим ур чадвар нь улс орны хөгжилд чухал нөлөө үзүүлдэг. Гэвч нийгэм, эдийн засаг болон газар зүйн байршлаас шалтгаалан цахим хуваагдал бий болж МХХТ-ийн хүртээмжийн тэгш бус байдал үүсээд байгаа юм. Улмаар хүмүүс хоорондын хөгжлийн ялгаа нэмэгдэж, нийгмээс тусгаарлагдах, орлогын тэгш бус байдал бий болох, хувь хүн болон нийгмийн хөгжил удаашрах зэрэг сөрөг нөлөөтэй байдаг. Тиймээс иргэдийг цахим технологи, интернэт сүлжээг үр дүнтэй ашиглан шаардлагатай мэдээллээ олж авах, үнэлэх, хуваалцах, нэгтгэх, ашиглах үр чадварт сургах нь тэдний нийгэм, эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Юнител групп Монгол орны өргөн уудам газар нутагт үүрэн холбооны сүлжээгээ тэлж, орон даяар интернэт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна олон нийтэд цахим боловсрол олгох тэдний үр чадварыг дээшлүүлэх ажилд бодит хувь нэмрээ оруулдаг. 2024 онд бид нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт Шинжлэх ухаан, Инженерчлэл, Урлаг, Математик, Технологи (ШИМТ)-ийн боловсролын хүртэмжийг нэмэгдүүлэх, ахмад настай иргэдэд цахим хэрэглээний суурь боловсрол олгох төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Unitel STEAM HUB

Юнител групп Монгол улсад боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, цахим хуваагдал, үр чадварын зөрүүг бууруулах зорилгоор "Unitel STEAM HUB" үндэсний хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь орон нутгийн иргэд, хүүхэд залуусын ШИМТ-ийн боловсролыг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Хөтөлбөрийн цар хүрээ

Юнител групп энэхүү хөтөлбөрийн хүрээнд хөдөө орон нутагт цахим хөгжлийг дэмжих орчныг бүрдүүлэхийг зорин ажиллаж байна. Бид 2022 онд Дархан-Уул аймагт анхны Unitel STEAM HUB төвийг түршилтээр нээж байсан бол 2023 онд 11 аймагт, 2024 онд 8 аймагт нээснээр нийт 20 аймагт амжилттай үйл ажиллагаагаа өргөжүүлээд байна.

Хамтын ажиллагаа

Unitel STEAM HUB хөтөлбөр нь төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгждэг бөгөөд хөтөлбөрийн үрт хугацааны тогтвортой үйл ажиллагаанд НҮБ-ын Хүн амын сан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дэмжлэг үзүүлж, хамтран ажилладаг. Мөн Unitel STEAM HUB төвүүд нь аймгуудын Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газарт байршиж, тус газраас өдөр тутмын үйл ажиллагаанд менежмент, хяналтыг тавьдаг юм. MonSTEAM ХХК нь ШИМТ чиглэлийн сургалтуудыг боловсруулж, сургагч багш нарын менежментийг хийж гүйцэтгэж байна.

Суралцах орчин

Unitel STEAM HUB төв нь олон нийтийн боловсролыг дэмжих зорилготой хувь хүний хөгжлийн орчин юм. Тус төвүүд нь бүгд суурин компьютер, таблет, проектор, VR төхөөрөмж зэрэг цахим хэрэглээнд суралцахад шаардлагатай төхөөрөмжүүдээр жигд тоноглогдсон бөгөөд үйлчлүүлэгчид маань төхөөрөмжүүдийг сургалтын хэрэгцээнд болон бие даан өөрийгөө хөгжүүлэхэд ашиглах боломжтой байдаг.







Хүүхдүүдэд зориулсан ШИМТ-ийн сургалтууд

Unitel STEAM HUB төвийн тогтвортой үйл ажиллагааны гол цөм нь 15 хүртэлх насны хүүхдүүдийн шинжлэх ухаан, инженерчлэл, математик, технологийн сонирхлыг дэмжиж, мэдлэгийг дээшлүүлэх онол, практикт хосолсон сургалтууд юм.

ШИМТ боловсрол нь зөвхөн инженерчлэл, технологийн үр чадвар олгохоос гадна:



Оюун санаа, сэтгэхүйг хөгжүүлдэг



Багаар ажиллах, харилцааны үр чадвар олгодог



Бүтээлч сэтгэлгээг дэмждэг

Бид эдгээр сургалтуудаар дамжуулан хүүхдүүдийг бага наснаас нь шинжлэх ухаан, технологитой ойртуулж ирээдүйн инженерүүдийг чиглүүлэх, төлөвшүүлэх зорилготойгоор ажиллаж байна.



● Онцлох сургалт: RoboKID

2024 онд бид бүх төвдөө робот угсрах, түүн дээрээ код бичих чадварыг олгодог "RoboKID" сургалтыг санал болгосон.

**Нэг элсэлтэд 10-аас дээшгүй хүүхэд хамрагдана*

2024 онд



712 хүүхэд

"RoboKID" сургалтад амжилттай хамрагдаж төгссөн



20 аймагт



7:3

эрэгтэй:эмэгтэй
Төгсөгчдийн хүйсийн харьцаа

● STEAM сургалтуудыг өргөжүүлсэн нь

2024 оны 12-р сард бид MonSTEAM ХХК-тай хамтран сургалтын хөтөлбөрөө шинэчилж, өмнөх сургалтуудаас гадна шинээр дараах 4 сургалтыг нэмсэн бөгөөд тус сургалтуудад хүүхдүүд 3 хүртэлх түвшин ахиж суралцах боломжтой болсон.

Мөн шинэчлэгдсэн хөтөлбөрийн дагуу сургалт авах насны ангилал 8-12 байснаас 6-14 болж өөрчлөгдөн, илүү олон хүүхэд сургалтад хамрагдаж эхэлсэн юм.

Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас Unitel STEAM HUB төвийн 5 төрлийн сургалтыг илүү хямд үнээр авах боломжтой ба сургалтын төлбөрт зөвхөн багшийн цалин болон сургалтын материалын зардал шингэсэн байдаг.*

**Unitel групп Unitel STEAM HUB төвийн үйл ажиллагаанаас ашиг олдоггүй болно.*


Шинэ сургалтууд:



1 төрлийн дан кодчиллын сургалт



2 төрлийн технологи ба код хосолсон сургалт



1 төрлийн цахилгаан хэлхээг кодтой хослуулсан сургалт

● Багшлах ажлын байр

Unitel STEAM HUB төвүүд орон нутагт ШИМТ чиглэлээр багшлах ажлын байр бий болгосноороо өндөр ач холбогдолтой. Одоогоор 20 аймагт нийт 20 сургагч багш үндсэн ажилтнаар ажилладаг бөгөөд багш нар сард 108-аас доошгүй ажлын цаг сургалт орж ажиллаж байна.

MonSTEAM ХХК нь сургагч багш нарын менежментийг хариуцаж, өдөр тутмын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавин ажилладаг. Бид тэдэнтэй хамтран багш нарт зориулсан:

ШИМТ боловсролын гүнзгийрүүлсэн сургалт

Багшлах арга зүйн хөтөлбөр

Хувь хүний хөгжлийн сургалт

зохион байгуулж, багш нарын бүтээмж, сэтгэл ханамжийг дээшлүүлэн, сургалтын тогтвортой байдлыг хангах зорилготойгоор ажиллаж байна.



Багш нарын хүйсийн харьцаа

14:6

эрэгтэй:эмэгтэй



Үр нөлөө болон ирээдүйн төлөвлөгөө

Юнител групп Unitel STEAM HUB хөтөлбөрөөр дамжуулан ШИМТ боловсролыг орон даяар тэгш хүртээмжтэй танилцуулж, ШИМТ боловсролын түүчээлэгч болохыг зорьж байна.

Манай хөтөлбөрийн үр дүн, нөлөөг үнэлэн Монгол дахь Америкийн худалдааны танхим (AmCham)-аас жил бүр зохион байгуулдаг "CSR Award"-ийн "Тогтвортой байдлыг хэрэгжүүлэгч шилдэг байгууллага" номинацид тодруулснаас гадна "Алтан Сарнай 2024" наадмаас "Боловсролын шилдэг төсөл"-өөр тус тус шалгарсан.

Цаашид бид Unitel STEAM HUB хөтөлбөрөө 21 аймагт хэрэгжүүлж, төвүүдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг ханган, ШИМТ сургалтыг илүү олон төрлөөр, нас насны хүүхдүүдэд хүргэхийг зорин ажиллаж байна.



STEAMEXPO 2024

Шинжлэх ухаан, Технологи, Инженерчлэл, Урлаг, Математикийн боловсролыг түгээх, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд багачуудад сонирхолтой практикт суурилсан сургалтыг санал болгох зорилготой "STEAMEXPO 2024" Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан. "Боломжийг хүн бүрд" уриатай Unitel STEAM HUB

хөтөлбөрөөрөө энэхүү арга хэмжээг дэмжин оролцож, Монгол Улсын 21 аймагт STEAM чиглэлээр ажилладаг багш, сурган хүмүүжүүлэгчид болон өдөрлөгт хүрэлцэн ирсэн хүүхэд багачууд, гэр бүлүүдэд хөтөлбөрийнхөө үйл ажиллагааг танилцуулсан. Энэхүү өдөрлөгт оролцогчид шинжлэх ухааныг практик орчинд түршиж, олон улсын шилдэг туршлагаадаас суралцсан үр өгөөжтэй арга хэмжээ болсон.



Олон нийтийн оролцоо

Unitel STEAM HUB зөвхөн хүүхдэд чиглэсэн ШИМТ боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна олон нийтийн цахим үр чадварыг сайжруулах, цахим хуваагдал, хүртээмжийн тэгш бус байдлыг бууруулах зорилготой. Unitel STEAM HUB төвүүд сургалтын бус цагаар бүх насны хүмүүст нээлттэй үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд хүссэн хүн бүр компьютер ашиглан үнэ төлбөргүй цахим хичээлд сууж, үр чадвараа хөгжүүлэх боломжтой.

Түүнчлэн Unitel STEAM HUB төвүүд нь орон нутагт мэдлэг, мэдээллийн тэгш хүртээмжийг хангах, олон нийтийн оролцоот үйл ажиллагаа зохион байгуулахад тохиромжтой орчин юм. 2024 онд Архангай, Өвөрхангай, Баян-Өлгий, Увс, Ховд, Дорноговь, Дорнод зэрэг 7 аймагт байрлах Unitel STEAM HUB төвүүд дээр "Боломжийг хүн бүрд" өдөрлөгийг амжилттай зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгийн хүрээнд дэлхийн шилдэг их сургуулиуд болох Стэнфорд, Дюкийн их сургуулиудад 100 хувийн тэтгэлгээр суралцаж буй оюутнууд тус төвд хүрэлцэн ирж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гадаадын их, дээд сургуульд элсэх, тэтгэлэг авах, өргөдөл, материалаа бүрдүүлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн юм.



М.Золжаргал
Дюкийн их сургуульд 100% тэтгэлэгтэй суралцаж буй оюутан

Ш.Урангоо
Стэнфордын их сургуульд 100% тэтгэлэгтэй суралцаж буй оюутан

Өдөрлөгт **7** аймгийн **524** сурагч, их, дээд сургуульд элсэхийг хүсэгчид оролцсон.



УРИЛГА
Дэлхийн топ их сургуульд суралцах хүсэлтэй ЕБС-ийн сурагчдадаа зориулан Юнител группээс "Боломжийг хүн бүрд" өдөрлөгийг зохион байгуулж байна. Өдөрлөгт Стэнфорд б Дюкийн сургуульд 100 хувийн тэтгэлэгтэй тэнгэр Ш.Уранг М.Золжаргал нар туршлагаа хуваалцаж, хамтадаа Unitel HUB дээр зохиогдох өдөрлөгт хэрхэн өргөдөл, материалгаа бүрдүүлэх практик зөвлөгөөг хүлээн авч үзэхийг хүсье.





DNA Mongolia: Үндэсний цахим элч

Орчин үеийн техник, технологи, дижитал хэрэглээ нийгмийн хөгжлийг хурдасгаж буй энэ үед ахмад настнуудын цахим үр чадварыг нэмэгдүүлэх нь зайлшгүй шаардлага болж байна. Цахим орчинд мэдээлэл авах, харилцах, өдөр тутмын хэрэгцээгээ хангах, аюулгүй байдлаа хамгаалах зэрэг чадварууд нь ахмадуудын амьдралын чанарт шууд нөлөөлөхүйц чухал үр чадварууд юм. Иймд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Дэлхийн банкны хамтран зохион байгуулсан “Үндэсний цахим элч” (Digital National Ambassador - DNA Mongolia) хөтөлбөрийг Юнител групп дэмжин ажилласан юм.

DNA Mongolia хөтөлбөр нь дижитал хуваагдлыг бууруулах, технологийн хөгжлийг илүү хүртээмжтэй болгох зорилготойгоор ахмад настнуудад цахим үр чадварын суурь боловсрол олгох сургалтуудыг зохион байгуулсан. Арга хэмжээний үр дүнд ахмад настнуудад цахим орчныг аюулгүй, хариуцлагатай, үр ашигтай ашиглах үр чадварыг эзэмшүүлж, үүгээр тэдний амьдралын чанарыг дээшлүүлэн, дижитал ертөнцөд өөртөө итгэлтэй хэрэглэгч болох суурь мэдлэгийг олгосон.

Сургалтын баг

107 сайн дурын оюутан залуус

30 сайн дурын ахмад настан

36 удаагийн танхим болон онлайн сургалт орсон

Оролцогчид

1,277 Хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот болон Дархан-Уул, Төв, Дорноговь, Булган, Өвөрхангай аймгуудын нийт 1,277 ахмад настан оролцсон.





Нийгэмд тустай ажлууд

Юнител групп нь Монголын тэргүүлэгч операторын хувьд нийгэмд тулгарч буй аливаа асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж, энэ чиглэлд хийж болох ажлуудыг үргэлж эрэлхийлдэг билээ. Бид дотоод нөөц бололцоондоо тулгуурлан асуудлыг шийдвэрлэх боломжит аргуудыг судлан хэрэгжүүлж, олон нийтийг ч мөн мэдээлэлтэй байхад анхаардаг. Тиймээс зөвхөн компаниар хязгаарлагдалгүй хувийн болон төрийн, төрийн бус байгууллагуудтай хамтран цар хүрээгээ улам өргөжүүлэн ажилладаг билээ. Эдгээр үйл ажиллагаагаараа дамжуулан нийгэмд эерэг нөлөөллөө үзүүлээд зогсохгүй ажилтнуудаа нийгмийн идэвхтэй, хариуцлагатай иргэн болоход нь нөлөө үзүүлж байгаагаараа онцлог юм.



Цусаа хандивлах өдөрлөг

Цус, цусан бүтээгдэхүүний нөөц хангамжийн дутагдал Монгол гэлтгүй дэлхий даяар эрүүл мэндийн салбарт тулгардаг асуудлуудын нэг. Цусны банкны нөөц хомсдолоос болж яаралтай үед хэрэгтэй хүндээ шаардлагатай тусламжийг үзүүлж чадахгүй байх эрсдэлээс сэргийлэхийн тулд бид ажилтнуудаа цусаа хандивлах сайн дурын үйлсэд уриалдаг.

Бид Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран 6 дахь жилдээ "Be a Hero" өдөрлөгийг дотооддоо зохион байгуулж байгаа бөгөөд 2024 онд 45 ажилтан цусаа хандивласан ба энэ нь 1,500 орчим хүнд шаардлагатай үед ашиглах цусны нөөцийг бүрдүүлсэн байна. Цаашдаа ч бид уг өдөрлөгийг жил бүр тогтмол зохион байгуулж, ажилтнуудаа цусаа хандивлаж, бусдын амь нас аврах их үйлсэд хувь нэмэр оруулахыг уриалах болно.

45

ажилтан цусаа хандивласан

1,500

орчим хүнд шаардлагатай үед ашиглах цусны нөөцийг бүрдүүлсэн.

2024.06.21

BE A
HERO

ХАМТДАА АМЬДРАЛ
БЭЛЭГЛЭЕ





“Жаргалтай Гайхалтай” 2024 аян

Юнител группийн ажилтнуудын санаачилсан “Жаргалтай гайхалтай” аянаар бид жил бүр орон нутагт амьдардаг хүүхэд залуусыг баярлуулахаар шинэ жилийн бэлэг илгээдэг уламжлалтай болсон билээ. 2024 оны хувьд Юнител группийн 18 насны ойн баяр тохиосонтой холбогдуулан бид 18 нас хүрч амьдралынхаа шинэ гарааг эхэлж буй хүүхдүүдийг онцолсон юм.

Уг аяныхаа хүрээнд Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймагт суралцдаг 500 гаруй сурагчдад өөрсдийн гараар бэлдсэн шинэ жилийн бэлгийг урам зориг өгөх ил захидлын хамт илгээлээ. Ерөнхий боловсролын сургуулиа амжилттай төгсөж, ажил амьдралын шинэ гараагаа эхлүүлэхэд нь амжилт хүсэж, урам зориг түгээсэн юм.

2024 онд



500 хүүхдэд

бэлэг илгээж “жаргалтай, гайхалтай” дурсамжуудыг бүтээлээ

Сүүлийн 4 жилийн турш манай ажилтнууд

1,300 хүүхдэд

бэлэг бэлдэж илгээсэн

18 Нас

Жаргалтай Гайхалтай



Бэлэгтэй, дурсамжтай зул сарын баяр

Юнител группийн Борлуулалт, үйлчилгээний газрын Теле борлуулалтын хэлтсийн хамт олон зул сарын баяраар асрамжийн газрын хүүхдүүдийг баярлуулахаар 2 дахь жилдээ нэгдэж тэдэнд бэлэг бэлдэж, хамтдаа нэгэн өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлээ. Зорилтот бүлгийн хүүхдүүдээ илүү сайн судалж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг нь ойлгохын тулд хамтрах байгууллагынхаа төлөөлөгчидтэй уулзаж мэдээлэл цуглуулсан юм. Ингээд 12-р сарын 25-нд Нархан Асрамж Халамжийн төвийн* 54 хүүхэдтэй Зул сарын баярыг хамт өнгөрүүлж, баяр баясал дурсамжаар дүүрэн нэг өдрийг хамтдаа өнгөрүүлжээ.

Үүний үр дүнд Теле борлуулалтын хэлтсийн ажилтнуудын аливаад хандах хандлага илүү эерэг болж, өөрөөрөө болон хамт олноороо бахархах, цаашид илүү их зүйлийг хийж бүтээх урам зориг авсан гэдгээ тэд онцолсон юм. Түүгээр ч зогсохгүй хамт олны дотоод уур амьсгал сайжирч, байгууллагын соёлыг дэлгэрүүлэх эерэг нөлөөтэй байгаа тул тэд энэхүү арга хэмжээг өргөжүүлэн газар дотроо, цаашлаад байгууллагын хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөөтэй байгаагаа илэрхийлсэн юм.

Анх 2023 онд Вербист хүүхэд хамгааллын төвийн* 48 хүүхдийг баярлуулж байжээ.

Хүүхдийн төлөө хийж буй сайн үйлс бүхэн ирээдүйдээ оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт юм.

*Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг асрамжийн төвүүд нь төрөөс ямар нэгэн санхүүжилт авдаггүй, 100% сайн дурын хандив, тусламжаар үйл ажиллагаагаа явуулдаг.





**Дэлхийн аварга болсон
Монголын анхны тамирчин**

Д.Дэмбэрэл /1938-1991/



**Зохиолч, найруулагч, эрдэмтэн,
орчуулагч**

Э.Оюун /1918-2001/

Март 8: Эмэгтэйчүүдийн ололт амжилтыг тэмдэглэх өдөр

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан бид монгол эмэгтэйчүүдийн түүхэнд оруулсан хувь нэмрийг шинэ үеийнхэндээ таниулж, тэдний ололт амжилтыг онцлон тэмдэглэсэн. Ингэхдээ бид түүхчидтэй хамтран эх орныхоо бүтээн байгуулалтад томоохон хувь нэмэр оруулсан 8 эмэгтэйг төлөөлөгчөөр сонгож тэдний алдар нэр, хийсэн бүтээснийг олон нийтэд таниулсан юм. Үүнийхээ хүрээнд анхны эмэгтэй хүний нэртэй гудамжтай болох санаачилгыг гаргасан бөгөөд бидний санаачилга амжилттай үр дүнг авчирсан.

Учир нь Улаанбаатар хотын хэмжээнд албан ёсоор нэрлэгдсэн 175 гудамж байдгаас 62 нь түүхэнд гавьяа байгуулсан хүний нэртэй бөгөөд тэдгээр дунд монгол эмэгтэйн нэрээр нэрлэгдсэн гудамж байдаггүй. Тиймээс нийгэмд томоохон хувь нэмэр оруулсан түүхэн монгол эмэгтэйчүүдийн нэрээр гудамжаа нэрлэж, тэдний алдар нэр үеийн үед дурсагдахыг хүссэн юм.

Бид энэхүү ажлыг бодит үр дүнд хүргэхийн тулд **together.unitel.mn** сайтаар дамжуулан тэдний түүхийг хуваалцаж, эдгээр эмэгтэйчүүдийн нэртэй нэрэмжит гудамжтай болох саналд олон нийтийг дэмжихийг уриалсан. Энэхүү кампанит ажил нь олон нийтийн дэмжлэгийг авч, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах нэр хүндтэй байгууллагууд болох Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ, Women in Tech, Монголын эмэгтэйчүүдийн холбоо зэрэг байгууллагатай хамтарч ажилласан билээ. Бидний зорьсон хэрэг амжилттай бүтэж, Нийслэлийн Засаг даргын захирамжаар дараагийн шинээр байгуулагдах гудамжийг монгол эмэгтэйн нэрээр нэрлэгдэх боломжийг бүтээсэн билээ.

Энэхүү санаачилгаар бид эмэгтэйчүүдийн бүтээсэн түүхэн гавьяа, ололт амжилт, улс орны бүтээн байгуулалтад оруулсан хувь нэмрийг нь олон нийтэд таниулж, алдар нэрийг нь цуурайтуулж, шинэ үедээ урам зориг өгөхийг зорилоо.



**Монголын анхны
Ардын багш**

Г.Батсүх /1911-1990/



**Монголын анхны
мэс засалч**

В.Ичинхорлоо /1914-1987/



**Монголын анхны эмэгтэй
нисгэгч**

Б.Надя /1915-1960/



**Монголын анхны
одон оронч**

С.Нинжбадгар /1924-2008/



**Дипломатч, олон улсын хүний
эрхийн зүтгэлтэн**

Л.Идэр /1937-/



**Монголын анхны
эмэгтэйчүүдийн байгууллагын
тэргүүн, Улсын бага хурлын
гишүүн**

Д.Пагмадулам /1906-1938/

#АнхныЭмэгтэйГудамж



Хамтын ажиллагаа

"Байгалиа хамгаалъя" аян

Экологийн Цагдаагийн албанаас хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, олон нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэхээр "байгалиа хамгаалъя" аяныг жил бүр зохион байгуулдаг билээ. Уг аянд Юнител групп нэгдэж, Хүннү Шоппинг Моллд байгаль орчныг хамгаалах чиглэлээр өөрсдийн хэрэгжүүлж буй ажлуудаа танилцуулж, байгаль хамгаалал, электрон хог хаягдлын хор уршгийн талаар олон нийтэд мэдээлэл түгээн хамтран ажилласан юм.



MOMADE гэр бүлийн өдөрлөг

"Momade" ээжүүдийн агентлагаас гэр бүл, эцэг эх, хүүхдүүдэд хамтдаа цагийг дурсамжтай өнгөрүүлэх боломжийг бүрдүүлж, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор "MOMADE" гэр бүлийн өдөрлөгийг зохион байгуулсан билээ. Уг арга хэмжээг Юнивишн компани дэмжин ажилласан ба уг өдөрлөгт нийт 1,000 гаруй гэр бүл оролцож хамтдаа жаргалтай дурсамжийг бүтээж нэгэн өдрийг гайхалтай өнгөрүүлсэн юм. Энэхүү өдөрлөг нь гэр бүлийн гишүүд цагийг хамтдаа өнгөрүүлэхийн ач холбогдлыг олон нийтэд таниулахаас гадна эцэг эхчүүдэд хүүхдийн боловсрол, хүмүүжлийн талаар мэргэжлийн хүмүүсийн сургалт, зөвлөгөө өгч шинэ мэдлэг, түршлага хуваалцсан үр өгөөжтэй өдөрлөг болсон.





Азийн дуу хоолой пянзыг Чингис хаан Үндэсний музейд хандивлав

Монголын хөгжмийн өв соёлыг судалж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Юнител групп Арт аяллын багтай хамтран “Азийн дуу хоолой” цоморлогийг эх орондоо авчирлаа. 1940 онд Япон улсын Колумбиа лэйблээс “Азийн дуу хоолой” пянзыг эрхлэн гаргасан бөгөөд уг пянзанд Азийн олон орны дуу багтсаны 3 нь монгол дуу. Үүний нэг нь их эзэн Чингис хааны тайлга тахилга, зан үйлд дуулагддаг хүндэтгэлийн “Магтуу дуу” байсан юм. Иймд энэхүү соёлын ховор үнэт өвийг эх орондоо авчран, Чингис хаан Үндэсний музейд хүлээлгэн өгч, хүүхэд залуус, хөгжим сонирхогчид сонсох, эрдэмтэн судлаачид судалж, сурталчлах боломжийг олголоо.





Компанийн соёл

Ажилтнуудын тогтвортой байдал, идэвх оролцоо нь хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийн суурь хүчин зүйл төдийгүй байгууллагуудын урт хугацааны тогтвортой байдлыг хангах гол хөшүүрэг юм. Компанидаа сэтгэл хангалуун, ажил амьдрал нь тэнцвэртэй ажилтны хөдөлмөрийн бүтээмж, инновацад оруулах хувь нэмэр нь компанийн өсөлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг. Монголчуудын дунд хилийн чандад ажиллах боломжуудыг эрэлхийлэх хандлага өсөж буй өнөө цагт үндэсний компаниуд иргэдийн хэрэгцээнд нийцсэн, динамик ажлын байруудыг бий болгож, эерэг, үян хатан, хамтын өсөлт хөгжилд чиглэсэн соёлыг төлөвшүүлэх нь чухал болж байна. Зөв соёлыг төлөвшүүлэх нь одоогийн ажилтнуудаа хадгалж үлдэхээс гадна шинэ, чадвартай ажилтнуудыг татах чухал хүчин зүйл юм.

Feedback 360° үнэлгээ

Ажилтан зөв хандлагатай, тасралтгүй сурч хөгжих хүсэл тэмүүлэлтэй, мэдлэг туршлагаа бусдадаа харамгүй хуваалцдаг, аливаад мэдрэг, багийн тоглогч байх нь бидний хамгийн том соёл. 2024 онд бид ажилтнуудынхаа компанид оруулсан хувь нэмрийг үнэн зөв үнэлж, тэдний тасралтгүй сайжирч хөгжих эрмэлзлийг нь дэмжих зорилгоор үнэлгээний шинэ систем нэвтрүүллээ.

Feedback 360° үнэлгээний аргачлал нь зөвхөн ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлээд зогсохгүй тухайн ажилтан байгууллагын соёлд нийцэх хандлага, зан үйл гаргадаг эсэхийг олон талыг хамруулан тодорхой хугацааны давтамжтай үнэлдэг. Өөрөөр хэлбэл ажилтан өөрийгөө, шууд удирдлагаа, удирдлагад ажиллаж буй ажилтнуудаа, зэрэгцээ түвшинд ажилладаг хамтрагчдаа давтамжит хугацаанд үнэлэх юм.

Ингэснээр Feedback 360° үнэлгээний үр дүнд ажилтан өөрийгөө олон талаас тольдон хараад зогсохгүй өөрийнхөө хараахан нээж илрүүлээгүй давуу чанарууд болон нэмж хөгжүүлэх хэрэгтэй талбаруудаа мэдэж авах боломжтой болсон. Түүнчлэн бие биедээ бүтээлч үнэлгээ, дүгнэлт өгч бусдыгаа улам илүү сайжрахад тусалж байгаа ба энэ нь цаашлаад компанийн соёл, ажиллах арга барилын нэг хэсэг болж байна.



Ногоон гэр бүлийн дүр төрх

Team play

Learning & Sharing

Adaptable

Effortful

Agile

Right attitude



Ажилтнуудын сургалт, хөгжил

Юнител групп нь бүх ажилтныхаа харилцаа хандлага, үр чадвар, мэргэжлийн өсөлтөд нь онцгой анхаардаг. Техник технологи хурдацтай өөрчлөгдөж буй энэ үед өөрсдийгөө тасралтгүй хөгжүүлэн, шинэ үр чадварт суралцах нь манай ажилтнуудын сэтгэлгээ, хандлагад бүрэн шингэсэн зан үйл юм.

Бид мэргэшиж гүнзгийрсэн үр чадвартай байхын зэрэгцээ өөрийнхөө ажилтай хамаарал бүхий, бусад олон төрлийн үр чадварын зах зухаас мэддэг, суралцдаг байхыг эрмэлздэг. Үүний хүрээнд бид сургалт хөгжлийн хэрэгцээгээ багаараа хамтдаа тодорхойлон, мэдсэн сурсан зүйлсээ бусдадаа хуваалцан хамтдаа тасралтгүй хөгжиж байна. Ингэснээр зөвхөн өөрийн ажлыг сайн мэддэг, нэг чиглэлээр гүнзгийрэх бус багийн бусад гишүүдийн үр чадварын зах зухаас мэддэг, түүнийгээ хөгжүүлдэг, нэг нэгнээ орлох боломжтой баг байх юм.

Бид ажилтнуудаа олон төрлийн хөгжүүлэх хөтөлбөр, сургалтад тасралтгүй хамруулдаг бөгөөд ажилтнууд өөрийн суралцах арга барилдаа тохирсон олон төрлийн суралцах боломжуудыг ашиглан хөгжиж байна. Ажлын байран дээрээ өдөр тутам хийж буй инновацлаг ажлуудаасаа болон хамтран ажиллагчдаасаа суралцах нь хамгийн үр дүнтэй хэлбэр гэж үздэг ба MCS Академи болон дотоодын бусад сургалтуудад мөн идэвхтэй хамрагддаг. Үүнээс гадна Udemy, Coursera гэсэн 2 төрлийн онлайн платформыг сонгож, англи хэлээр сургалтад суун, чөлөөт цагаараа өөрийгөө хөгжүүлж байна.



2024 онд

	Нийт сургалтад хамрагдсан цаг:	25,415	90% ↑
	Нэг ажилтанд ногдох сургалтын цаг:	14.6	89.3% ↑
	Нийт сургалтад хамрагдсан ажилтны тоо:	5,638	146% ↑

*Тайлбар: (↑) 2023 онтой харьцуулсан өсөлт

Сурч хөгжих боломжууд:

MCS Академи

247 удаагийн сургалтад ↑

2,683 ажилтан хамрагдаж ↑

10,413 цагийг сурч хөгжихөд зарцуулсан ↑

Гадаад болон дотоодын бусад сургалтын байгууллага

64 удаагийн сургалтад ↑

714 ажилтан хамрагдаж ↑

6,178 цагийг сурч хөгжихөд зарцуулсан ↑

Бие биедээ мэдлэгээ хуваалцах

2,003 ажилтан хамрагдаж ↑

6,891 цагийг бусдадаа мэдлэгээ хуваалцахад зарцуулсан ↑

Онлайн сургалт

1,933 цагийг онлайнаар сурч хөгжихөд зарцуулсан ↑

75 төрлийн сургалт





Ажилтнуудад зориулсан арга хэмжээ


Манай компани жил бүр компанийн соёлыг бэхжүүлж, хамт олны уур амьсгал, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн олон төрлийн арга хэмжээнүүдийг санаачлан зохион байгуулдаг. 2024 оны онцлог нь ажилтнуудад чиглэсэн бүх үйл ажиллагааг компанийн үндсэн болон өргөтгөсөн менежментийн багийн гишүүд хамтран зохион байгуулсан явдал байлаа. Ингэснээр ажилтны туршлагыг сайжруулах, компанийн соёлыг түгээхэд дунд шатны менежерүүдийн оролцоог улам нэмэгдүүлж хөгжилтэй, халуун

дулаан уур амьсгалтай ажлын орчныг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан юм. Бид эдгээр үйл ажиллагааг бүх ажилтанд хүртээмжтэй байлгах үүднээс ажлын өдрүүдэд зохион байгуулдаг жишигтэй болсон бөгөөд энэ нь нөгөөтээгүүр ажилтнууддаа амралтын цагаа гэр бүлдээ зориулах боломжийг олгох зорилготой юм. Түүнчлэн арга хэмжээ бүрд Toki апп дээр тухайн арга хэмжээний мэдээлэл бүхий мини-апп-ийг хөгжүүлэн сонирхолтой даалгавар, хөтөлбөр зэргийг явуулж байсан

нь ажилтнууд тухайн арга хэмжээний мэдээллийг бүрэн авах боломжийг бүрдүүлж, идэвхтэй оролцоог нь дэмжсэн ба ажилтны дижитал туршлагыг улам сайжруулсан билээ. Арга хэмжээнүүдийн үр дүнд ажилтнууд сэтгэл ханамжтай, үргэлж түрүүлж алхдаг технологийн компанид ажилладгаараа бахархах сэтгэгдэл дүүрэн үлддэг.

2024 онд зохион байгуулагдсан үйл ажиллагаа:

Open mic: Хамтдаа дуулж, үдшийг хөгжилтэй өнгөрүүлсэн арга хэмжээг намар болон хаврын улирлуудад, жилдээ 2 удаа тэмдэглэн өнгөрүүлжээ.



Спортын наадам: "Together we play" спортын наадам маань сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар, дартсын тэмцээнүүдээр зохион байгуулагдаж, ажилтнууд маань хоорондоо өрсөлдсөн.



Юнител группийн 18 жилийн ойн баяр: 6 дугаар сард Юнител группийн ойн баярын өдөр тохиож бид "Хамтдаа түрүүлж алхсан 18 жил"-ийн баяраа тэмдэглэсэн.



E-sport-ийн тэмцээн: "Together we play E-sports" тэмцээн 5 хоног online болон Offline хэлбэрээр үргэлжилж, эрэгтэй эмэгтэй тамирчдаас бүрдсэн нийт 12 баг хоорондоо өрсөлдсөн ба тоглолтуудыг YouTube платформ дээрх өөрсдийн ESN сувгаар шууд дамжууллаа.



Холбоочдын баяр: "Hello 18" сэдвийн хүрээнд бид салбарынхаа хамгийн том баяраа Хайрхан хөгжлийн төвд 1,450-уулаа цугларан тэмдэглэж 18 жилийн түүхийн нэгээхэн хэсэг болгон Digital art-ыг бүтээсэн. Мөн салбарын шилдэг 24 ажилтнаа шагнаж урамшуулсан.



Шинэ жил: Уламжлалт шинэ жилийн арга хэмжээнээс өөр цоо шинэ өнгө аястайгаар "Adios 18" нэрийн дор тэмдэглэн өнгөрүүлсэн.





Тав тухтай, уян хатан ажлын орчин

Юнител групп нь ажилтнуудынхаа тав тухтай байдал, ажил амьдралын тэнцвэрийг хангаж, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг зорьдог. 2024 онд бид орон нутаг дахь салбар төлөөлөгчийн газар болон үйлчилгээний салбаруудыг Улаанбаатар хотын оффис, салбаруудтай нэг ижил стандарт, концепцийн хүрээнд шинэчлэн сайжруулж, эрүүл, аюулгүй, хүртээмжтэй ажлын орчныг бүрдүүлэхэд онцгой анхаарлаа хандуулсан.

2024 онд

Орхон, Архангай, Ховд, Баян-Өлгий, Увс, Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Дундговь зэрэг **10 аймгийн оффисуудад** засвар хийж тохижуулсан.

Ирэх жил бусад аймгуудын салбаруудад засвар тохижилтыг хийснээр бүх ажилтнууд нэг стандартын, тав тухтай, аюулгүй орчинд ажиллах боломжтой болно.

Мөн COVID-19 цар тахлын дараах ажиллах хэв маягийн өөрчлөлтийг харгалзан, 2022 оноос эхлэн ажилтнууддаа Улаанбаатар хотын дөрвөн бүсэд байрлах дундын оффисуудаас сонгон ажиллах боломжийг олгож, замын түгжрэл, цаг хугацааны алдагдлыг бууруулах, гэр бүл болон хувийн хөгжилд зарцуулах цагийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн. Үүнтэй зэрэгцэн уян хатан цагийн хуваарийг нэвтрүүлж, ажилтнууд өөрийн амьдралын хэв маягт нийцүүлэн ажил эхлэх, тарах цагаа сонгох боломжтой болсон нь илүү тэнцвэртэй, аз жаргалтай ажлын орчныг бий болгож байна.



Дарханы салбар төлөөлөгчийн газрын оффис



Үрд бүсийн Distributed Office



Зүүн бүсийн Distributed Office

Фронтлайн ажилтнуудад чиглэсэн арга хэмжээ

Юнител групп нь Ногоон гэр бүлийн гишүүн бүрийн ажлын онцлогоос нь хамааран сэтгэл ханамжийг нь дээшлүүлэх үүднээс олон төрлийн арга хэмжээ зохион байгуулдаг билээ. Үүний хүрээнд тусламж үйлчилгээний, салбарын болон өрхийн борлуулалт, үйлчилгээний зэрэг хэрэглэгчидтэй шууд харилцдаг 500 гаруй ажилтны өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчлөх, амьдралын тэнцвэрийг олж, эрүүл амьдралын хэв маягийг хадгалахад чиглэсэн ажлуудыг санаачлан цогцоор нь хэрэгжүүлсэн байна.

Фронтлайн нэгж бүрийн шууд удирдлагууд улирал бүр "Cultural experience"-ийг сайжруулах ажлын төлөвлөгөө боловсруулж, хамт олноороо өглөөний цай уух, team building арга хэмжээнүүдийг хийдэг. Хэрэглэгчийн тусламж үйлчилгээний алба буюу лавлах төв нь албан ёсны нэгдсэн workshop зохион байгуулахаас гадна, ажилтнуудын ажлыг сонирхолтой байлгаж, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор өдөр тутмын ажилд нь хөгжөөнт тоглоомын элементүүдийг шингээсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулсан байна. Өрхийн борлуулалт үйлчилгээний албаны хувьд сүүлийн 3 жил ажилтнуудынхаа дунд Бэсрэг наадам зохион байгуулжээ.

2024 онд, өмнөх онтой харьцуулахад:

50% Хэрэглэгчийн тусламж үйлчилгээний албаны ажилтнуудын эргэц 50%-иар буурсан

45% Өрхийн борлуулалт үйлчилгээний албаны ажилтнуудын эргэц 45%-иар буурсан

Түүнчлэн, цахим хэрэглээг хялбаршуулах үүднээс ажилтнуудын өдөр тутамдаа ашигладаг төхөөрөмж, хэрэгсэл болон таблетыг шаардлагатай үед шинэчилдэг. Мөн ажилтнуудын ашигладаг программ хангамжийг ажиллахад хамгийн хялбар, тухтай, бүтээмжийг нь өсгөхүйцээр дотооддоо хөгжүүлэн нэвтрүүлж, сайжруулсаар байна.

Фронтлайн ажилтнуудад чиглэсэн цогц үйл ажиллагааны үр дүнд ажилтнуудын сэтгэл ханамж нэмэгдэж, гүйцэтгэл сайжирсан. Өмнөх жилүүдтэй харьцуулахад хэрэглэгчид үйлчилгээ үзүүлдэг ажилтнуудын эргэц буурсан. Энэ нь ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхийн хэрээр компанийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад чиглэсэн амжилттай алхам болсон гэж үзэж байна.





Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал

Бидний өдөр тутмын амьдралд технологи өргөн хүрээнд нэвтэрч дижитал шилжилтүүд ихээр хийгдэж буй энэ үед харилцаа холбооны компаниуд цаг үеэсээ түрүүлж алхан, хэрэглэгчдийнхээ олон талт байдлыг мэдрэн бүтээгдэхүүн, үйлчилгээндээ тусгах зайлшгүй шаардлага үүсээд буй. Бүтээгдэхүүн, үйлчилгээндээ энэ байдлыг тусгахын тулд ажилтнуудынхаа олон талт байдал, ижил тэгш оролцоог чухалчлан авч үзэх хэрэгтэй. Бие биеэсээ ялгаатай гарал үүсэл, туршлага, үзэл


бодол бүхий хүмүүс хамтран ажиллах нь илүү шинэлэг шийдлүүд гаргах нөхцөлийг бүрдүүлдэг гэж бид итгэдэг. Энэ нь харилцаа холбоо шиг хурдан дасан зохицох, хэрэглэгч төвтэй шийдлүүдийг гаргах шаардлагатай салбарт бүтээлч байдал, инновацыг идэвхжүүлэх хүчин зүйлсийн нэг болдог билээ. Юнител групп олон талт онцлог байдал, ижил тэгш оролцоог байгууллагын засаглал, хүний нөөцийн бодлого, бизнесийн үйл ажиллагаанд бүрэн шингээж, хуулийн хүрээнд хэрэгжүүлэхийг зорьж

ажилладаг. Бид хамт олны дунд эвсэг, нөхөрсөг соёлыг төлөвшүүлж, хүний нас, хүйс, арьсны өнгө, соёлын онцлог, тусгай хэрэгцээт байдал, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, гарал үүсэл, үндэс угсаа, гэрлэлтийн болон гэр бүлийн байдал, амьдралын туршлага, нийгэм-эдийн засгийн байдал, хандлага зэрэг бүх хэлбэрийн ялгаатай байдлыг үл харгалзан хувь хүн тус бүрийн үнэ цэнийг эрхэмлэж, хүн бүрд бусадтайгаа эн тэнцүү хувь нэмрээ оруулах, өсөж хөгжих боломжоор тэгш хангаж ажиллахыг зорьдог.*




*Эх үүсвэр: Юнител группийн "Олон талт онцлог байдал болон ижил тэгш оролцоот байдлыг дэмжих журам"

2024 оны Юнител группийн ажилтнуудын хүн ам зүйн задаргаа



Хүйсийн тэгш харьцаа

Бид удирдах түвшний албан тушаалд хүн бүр хүйсээс үл хамааран ижил тэгш өсөж, дэвших боломжийг энэ тэнцүү олгодог. Мөн ажиллах хүчний эмэгтэйчүүдийн оролцоог зорилтод хувиас дээш байлгахыг эрмэлздэг билээ.



*Тайлбар: (↑) 2023 оноос өссөн



Эмэгтэй ажилтнуудын онцгой хэрэгцээг харгалзах нь

Юнител групп нь ажилтнуудынхаа сайн сайхан байдал, эрх тэгш боломжийг хангахыг эрхэмлэн, ажил, амьдралын тэнцвэрийг хадгалахад таатай орчин бүрдүүлэхийг зорьдог. Хамт олныг бүрдүүлж буй хүмүүс өөр өөр хэрэгцээ, өөрийн гэсэн онцлогтой байж болох ч бид тэднийг ижил тэгш боломжоор хангаж ажиллахыг чухалчилдаг. Тиймээс ажилтнууддаа зориулан олон төрлийн дэмжлэг, уян хатан нөхцөлийг санал болгож, өсөж дэвших боломжоор ханган ажиллаж байна.

2024 онд бид эмэгтэй ажилтнуудынхаа онцгой хэрэгцээг хангах зорилгоор ажлын орчныг тохижуулж тэдний сэтгэл ханамж, бүтээмжийг өндөр байлгах дээр төвлөрч ажиллалаа.

Mama's Corner

Хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа эргэн орж байгаа ажилтан ээжүүд ажил үүргээ гүйцэтгэхээс гадна хүүхдээ асрахтай холбоотой бие, сэтгэл зүйн тодорхой хэмжээний ачааллыг үүрч байдаг.

2024 онд бид Централ Тауэр дахь төв оффис болон бүсийн 3 оффис дээр хүүхэд асрах чөлөөнөөс ажилдаа эргэн орж байгаа ажилтан ээжүүд хэрэглэх боломжтой "Mama's corner"-ийг тохижууллаа. Энэхүү буланд ээжүүд маань оффис дээр хүүхдийнхээ живхийг солих, хөхөөр хооллох, хуурайлах гэх мэт сувилахуйн асаргааг саадгүй хийх орон зайтай болсон юм.

Ингэснээр хүүхэд асрах чөлөөнөөсөө ажилдаа эргээд орсон ч хүүхдээ эхийн сүүгээр хооллох, ажлаа тав тухтай, тайван хийх орчин нөхцөлийг бүрдүүлж эх хүүхэд аль аль нь сэтгэл санаа өөдрөг, тав тухыг мэдэрч, ажил амьдралын тэнцвэртэй байдлаа хадгалж байна.



Caring Box

Бид Анунгоо ХХК-тай хамтран Улаанбаатар болон орон нутгийн 22 оффисын эмэгтэй ариун цэврийн өрөөнд "Caring box" нэртэй ариун цэврийн хэрэглэлтэй хайрцаг байршуулсан. Сарын тэмдэг ирсэн болон ирэх үед ариун цэврийн хэрэглэл бэлэн байхгүй яаралтай тохиолдолд энэхүү хайрцагаас асуудлаа шийдэх боломжтой.

Эмэгтэй ажилтнуудыг гэнэтийн хүнд нөхцөлд оруулдаг асуудлуудын нэг нь ийнхүү бүгдэд хүртээмжтэй, таатай байдлаар шийдэгдсэн юм.





Тусгай хэрэгцээтэй иргэдэд зориулсан ажлын байр

Бид тусгай хэрэгцээт иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор тэдэнд ажиллахад тохиромжтой ажлын байруудыг нээлттэй байлгахыг эрмэлздэг. Бид компанийнхаа дотоод үндсэн ажлын байруудаас тусгай хэрэгцээтэй иргэдэд тохиромжтойг нь тодорхойлж, тэдгээрийн ажиллах орчныг оновчтой бүрдүүлэх ажлуудыг идэвхтэй хэрэгжүүлж байна.

2024 онд "Ability Expo 2024" арга хэмжээнд оролцож, тус арга хэмжээний үеэр тусгай хэрэгцээт хүмүүсийн ажиллах боломжтой ажлын байруудыг зорилтот ажил горилочдод танилцуулсан.

8

Тусгай хэрэгцээт үндсэн ажилтнуудын тоо

66

Хугацаатай хөдөлмөрийн гэрээтэй тусгай хэрэгцээт ажилтнуудын тоо


Бид тусгай хэрэгцээт иргэдийг ажлын байраар хангах үүднээс "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо" ТББ-тай хамтран ажилладаг. Тус Холбооны гишүүдтэй хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, тэдгээр хүмүүсээс ажилтнууддаа бариа засал болон катеринг үйлчилгээ авч ажиллаж байна.



MySpace платформ: Мэдээллийн тэгш хүртээмж

Бид бүх ажилтан шаардлагатай мэдээллээ ижил тэгш зарчмаар, саадгүй авах боломжтой байх ёстой гэж үздэг. Үүний хүрээнд бид ажилтнуудаа мэдээлэл авах, оролцох, санал бодлоо хуваалцах боломжтой байлгахыг зорьж тэдний дуу хоолойг сонсох талбарыг бий болголоо. Компанийн олон тус тусдаа сувгаас авдаг мэдээллүүдийг нэг дор нэгтгэн, интерактив функцүүдтэй, ажилтнууд өөрсдөө мэдээллээ хуваалцах

боломжтой дотоод мэдээллийн платформыг хөгжүүлсэн. Компаниас хэрэгжүүлж буй зохицуулалтууд, олон нийтийг хамарсан арга хэмжээ зэрэг ажилтнууд мэдэх шаардлагатай бүхий л мэдээллээ нэг дороос тогтмол авах боломжтой болсноос гадна шаардлагатай журам, заавар, процесс зэрэг мэдээллийг олон сурвалжаас хайж цаг алдахгүй, өөрт хэрэгцээтэй бүхнээ нэг дороос авдаг болоод байна.





Ажилтнуудын сайн сайхан байдал

Ажилтнууд маань компанийн хамгийн үнэт хөрөнгө болохын хувьд тэдний ажиллах орчин, сэтгэл ханамж, эрүүл мэндэд анхаарч, амьдралын чанарыг нь сайжруулах боломжуудыг үргэлж эрэлхийлдэг. Бид ажиллах хамгийн таатай орчныг бүхий л талаас нь бүрдүүлэхийг зорьдог бөгөөд энэ нь ажилтнуудын сэтгэл ханамжид сайнаар нөлөөлөхөөс гадна шинэ чадварлаг мэргэжилтнүүдийг татахад ч чухал ач холбогдолтой юм.

Компанийн бодлогын хүрээнд ажилтанд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөхдөө нийгмийн нөхцөл байдал, хэрэгцээ болон сонирхлыг нь харгалзан үздэг. Ажилтнуудын ажил амьдралын тэнцвэр, хөдөлмөрийн уян хатан байдал, сэтгэл зүйн эрүүл мэнд зэрэгт анхаарал тавих нь нэмэгдэж байгаа энэ үед бид ч мөн эдгээр чухал хэрэгцээ, хүлээлтэд нийцүүлэн шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлтүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлж байна

Хөдөлмөрийн зах зээлд эрүүл, идэвхтэй, санхүүгийн хувьд тогтвортой иргэдийг бий болгох нь зөвхөн хувь хүн төдийгүй улс орны эдийн засагт ч чухал нөлөөтэй. Бид ажилтнуудынхаа сайн сайхан байдлыг бүх талаар дэмжиж, тэдний санал хүсэлт, оролцоог чухалчилж, хамтдаа шийдвэр гаргадаг ардчилсан зарчмыг түүштай баримталдаг.



Бие болон сэтгэл зүйн эрүүл мэнд

Юнител групп ажилтнуудынхаа олон талт онцлог байдал, ажлын байрны онцлогуудад тохируулан хүн төвтэй оффисын тав тухай орчныг бүрдүүлэхийг зорьдог.

Energy Booster

2024 онд бид ажилтныхаа ажлын байрны онцлогт тохирсон түр амрах “Energy Booster” хэсгүүдийг бий болгосон. Тухайлбал, Централ Тауэр дахь төв оффист компьютерын ард олон цагийг өнгөрүүлдэг ажилтнуудынхаа ажлын онцлогт тохируулан амралтын өрөө гарган тохижуулсан. Ажилтан бие болон сэтгэл зүйн хувьд түр амрах шаардлагатай үедээ үг өрөөнд орон богино хугацаанд чанартай амрах, тайвшрах, өөрийгөө

цэнэглэн бүтээмжээ нэмэгдүүлэх боломжтой болох юм. Энэхүү өрөөг IoT технологийн шийдлийг шингээн тохижуулсан бөгөөд ашиглах үед автоматаар хөшиг хаагдаж, өрөө түгжигдэн, алжаал тайлах дүү эгшиглэн 15 минутын дараа автоматаар зогсдог. Мөн Улаанбаатар хотын 4 бүсийн оффист түр амарч амсхийх буйдан, боксын мишок болон бусад техник хэрэгслээр хангаж, тоноглон тохижуулсан юм.





Санхүүгийн сайн сайхан байдал

Бид цалин урамшууллын шударга тогтолцоотой бөгөөд цалингийн хэмжээ нь нас, хүйс, гэр бүлийн байдал, хөдөлмөрийн чадвар алдалт, бие давхар эсэх зэрэг хувийн шинж чанаруудаас үл хамаардаг. Бид эдийн засгийн нөхцөл байдалд нийцсэн өрсөлдөхүйц цалин урамшууллыг санал болгодог бөгөөд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасан тогтоомжийг чандлан сахидаг.

 Юнител группийн шинэ ажилтны цалин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний **190%-тай** тэнцэж байна.



Ажилтанд зориулсан хөнгөлөлт, хангамж

Бид ажилтнуудынхаа ажлын байран дахь оролцоо болон байгууллагад тогтвор суурьшилтай ажиллах түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор ажилтнууд болон тэдний гэр бүлд чиглэсэн олон төрлийн хөнгөлөлт, хангамжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн. Эдгээр хөнгөлөлт хангамжийг олгох журмууд нь дотоод мэдээлэл солилцооны MySpace платформ дээр нээлттэй байршсан байдаг.

2024 оны хөнгөлөлт, хангамжийн онцлох хөтөлбөрүүд:

- **MCS Benefits хөтөлбөрийг өргөтгөв:** М-Си-Эс группийн компаниудын төрөл бүрийн бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжтой MCS Benefits-ийн мөнгөн дүнг нэмэгдүүлсэн. Мөн хүүхэд асрах чөлөөтэй ажилтнууд маань хүүхдээ 1 нас хүртэл MCS Benefits-ийн хангамжийг хүртэх боломжтой болсон.
- **Амьдралын баярт мөчүүдийн бэлэг нэмэгдэв:** Шинэ хүүхдээ өлгийдөн авсан ажилтанд олгодог эрхийн бичгийн дүнг нэмэгдүүлж, гэр бүл болсон ажилтнуудад олгодог бэлгийг хурим хийснээс үл хамааран, албан ёсоор гэрлэлтээ батлуулсан тохиолдолд олгодог боллоо.
- **Лизингийн нөхцөл сайжрав:** Ажилтны нөхцөлөөр гар утас, дагалдах хэрэгсэл лизингээр авах үнийн дүнг нэмж, хүүгүй лизинг авах боломжтой боллоо.

- **Шинэ ажилтны дасан зохицолтыг хурдасгав:** Шинэ ажилтнуудаа ажилдаа илүү хурдан дасан зохицох, халамжлагч ажилтантайгаа илүү ойр дотно болох боломжийг бүрдүүлэн тэдэнд хамтдаа кофе үүх эрхийн бичиг олгож эхэллээ.
- **Төрсөн өдрийн чөлөө илүү уян хатан болов:** 2023 оноос эхлэн хэрэгжиж буй "төрсөн өдрийн цалинтай чөлөө" -г 2024 онд илүү уян хатан болгож, төрсөн өдрөөс хойш 14 хоногийн дотор эрхээ ашиглах боломжтой болголоо.
- **Хүүхдүүдэд зориулсан баярт мөчийг бүтээв:** Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэнд хүүхэд багачууддаа зориулсан баярын өдөрлөгийг эхний өдөр нь ажилтнуудынхаа хүрээнд, хоёр дахь өдөр нь олон нийтэд нээлттэй хэлбэрээр амжилттай зохион байгууллаа.
- **Шинэ жилийн баярыг гэр бүлдээ зориулав:** 2024 оны шинэ жилийн баяраар ажилтнууддаа баярын өдрүүдийг гэр бүл, хайртай хүмүүстэйгээ хамт өнгөрүүлэх боломжийг олгон 12-р сарын 30-31-ний ажлын өдрүүдийг "Цалинтай амралтын өдөр" болгон бэлэглэсэн.

Мөн бид 2022 оноос хойш ажилтнуудын санхүүгийн сайн сайхан байдлыг дэмжих зорилгоор гэнэтийн санхүүгийн хэрэгцээ гарсан үедээ ашиглах, эхний хоёр сар хүүгүй, хэрэглээний зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэн билээ. Ингэснээр ажилтнууд маань хэрэгцээ шаардлага гарсан үедээ цаг хугацаа, орон зайнаас үл хамааран Toki апп-аар зээлийн үйлчилгээ авах боломжтой болсон.





Амттай булан: Yum Yum Bar

Бид ажлын орчныг илүү тав тухтай байлгах зорилгынхоо хүрээнд оффистоо "Yum Yum Bar"-ийг хоёр газар туршилтаар байршуулсан. Тодруулбал, ажилтнууд ажлынхаа дундуур богино хугацаанд завсарлаж, эрч хүчээ цэнэглэхэд зориулсан эрүүл амттан, цай, кофе, цэвэр үс зэрэг бүтээгдэхүүнүүдийг өөрсдийн оффисоосоо авах боломжийг бүрдүүлсэн юм. Ингэхдээ бүтээгдэхүүнүүдээ нээлттэй, хяналтгүй орчинд байршуулж, ажилтан, компани хоорондын итгэлцэлд суурилан төлбөрөө QR код ашиглан төлөхөөр зохицуулсан билээ.



Yum Yum Bar-д байршуулсан бүтээгдэхүүнүүдийг хөнгөлөлттэй үнээр санал болгодог тул энэ нь цаг хугацаа төдийгүй санхүүд ч хэмнэлттэй байдаг. Иймд ажилтнууд маань сэтгэл ханамжтай байгаа бөгөөд үргэлжлүүлэн ашиглах хүсэлтээ илэрхийлсээр байна.

Нийгмийн оролцоо

2024 онд бид ажилтнуудаа сонирхлоороо нэгдэн клуб байгуулж, хоорондоо нэтворкинг хийх, нэгнээсээ суралцах боломжийг бүрдүүлсэн юм. Эдгээр сонирхлын клубүүдийг ажилтнуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэхийн тулд үндсэн чиглэлүүдийн талаар нээлттэй санал асуулга явуулсан ба хамгийн их санал авсан 3 клубийг байгуулсан. Уг санал асуулгад өөрийн элсэхийг хүсэж буй сонирхлын клубийн чиглэлээ илэрхийлэхээс гадна тухайн клубээ удирдах хүсэлтэй бол түүнийгээ ч илэрхийлэх боломжийг олгосноороо онцлог. Ажилтнуудын хүсэлтээр "Uniwalkers" ууланд алхалтын клуб, "Uni-Corner" англи хэлний ярианы клуб болон "CineMates" кино сонирхогчдын клубуудыг тус тус байгуулсан ба клуб тус бүр 90-120 гишүүний бүрэлдэхүүнтэй тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна.



Ирээдүйн төлөвлөгөө

Ирэх онуудад бид 2024 оны сайн туршлагуудыг хэвээр хадгалж, тэдгээрийн хүртээмж, ашиглалтыг үнэлэн шаардлагатай сайжруулалтуудыг хийж үргэлжлүүлэн гүйцэтгэх болно. Мөн ажилтнуудын сэтгэл зүйн эрүүл мэнд болон санхүүгийн боловсролыг дэмжих нэмэлт үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.





Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа

Монгол Улсын Үндсэн хуульд “Иргэн бүр хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангуулах эрхтэй” гэж заасан байдаг бөгөөд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу ажилтны эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхлэлтийг зохицуулдаг.

Юнител групп Монгол Улсын ХАБЭА-н тухай хууль, Олон улсын ISO45001:2018 стандарт болон бусад холбогдох журмуудыг бизнесийн үйл ажиллагаандаа нийцүүлэн нийт ажилтан, туслан гүйцэтгэгч компани, хамтран ажиллагч байгууллагын ажилтнуудын аюулгүй хөдөлмөрлөх ХЭМАА-ны тогтолцоог бий болгож ажилладаг бөгөөд дараах ХЭМАА-ны талаар бодлогыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- 1 ХЭМАА-ны нийцлийн үүргийг хэрэгжүүлэх замаар сонирхогч талуудын хэрэгцээ хүлээлтийг хангаж, тогтмол сайжруулах
- 2 ХЭМАА-ны эрсдэлийг үнэлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх
- 3 ХЭМАА-ны менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд нийт ажилтны оролцоог бий болгох
- 4 Удирдах ажилтнуудын ХЭМАА-ны үүрэг хариуцлага, манлайллыг нэмэгдүүлэх
- 5 Осол, осол дөхсөн тохиолдол бүрийг бүртгэж, суурь шалтгааныг нь олж, залруулан ажиллах

Ажилтныг мэдээллээр хангах

Компанийн хэмжээнд ХЭМАА-тай холбоотой журам, зааварчилгаа, цаг үеийн мэдээллийг дотоод MySpace платформ дээр байршуулж, ажилтан хаанаас ч шууд танилцах боломжийг бүрдүүлсэн.

ХАБЭА-н зөвлөл, ижил өртөлтийн бүлгийг байгуулан ХЭМАА-тай холбоотой асуудлаар жилд 2 удаа хуралдаж сайжруулах ажил төлөвлөн ажилладаг.

Аюул, эрсдэлийг мэдээлэх хуудсыг автоматжуулснаар ажилтан ажиглаж илрүүлсэн аюулаа QR кодоор шуурхай мэдээлэх ба хэрхэн хариу арга хэмжээ авсан талаар ажилтанд буцаан хариу өгдөг болсон. Ингэснээр ажилтан бүр аюулыг мэдээлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх оролцоог хүртээмжтэй болгосон. Мэдээлэх QR кодыг компанийн бүх объект болон ажилтанд зориулсан цахим хуудас дээр байршуулж аюулыг шуурхай мэдээлэх боломжийг бүрдүүллээ.

Аюул, эрсдэлийн менежмент

Бид аливаа ажлыг хийж гүйцэтгэхийн өмнө эрсдэлийг үнэлж, эрсдэлтэй цэгүүдийг хянаж, ослоос урьдчилан сэргийлэх бодлого баримталдаг бөгөөд аюултай тохиолдолд ажлаа зогсоож, аюулгүй болсны дараагаар ажил үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэдэг.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Объектуудад гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж, үр дүнд нь тулгуурлан объект бүрд эрсдэлээс урьдчилан сэргийлж, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах 108 ажилтныг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвд сургаж дадлагажууллаа. Бүх объектод газар хөдлөлтийн дадлага сургуулилтыг зохион байгуулж 1,234 ажилтан хамрагдсан.
-----------------------------------	--

Процесст шинжилгээ хийх замаар аюулыг илрүүлж, эрсдэлийг үнэлэх	Бид бизнесийн үйл ажиллагааны процессуудад ХЭМАА-ны эрсдэлийн үнэлгээг удирдах ажилтнуудын оролцоотой хамтран хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэн ажилладаг. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлаж ажилтнуудаа аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгаанд тогтмол хамруулж, хамгаалах хувцас хэрэглэлээр хангах зэрэг компанийн зүгээс шаардлагатай арга хэмжээг бүхий л түвшинд авч хэрэгжүүлж байна.
--	---

Ажлын байруудыг эрсдэлийн зэргээр ангилах	Компанийн хэмжээнд бүх ажлын байруудад ХЭМАА-ны эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн түвшнээр ангилсан ба түвшин бүрд тохирсон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, сургалт, ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл, эрүүл мэндийн үзлэг, гэнэтийн ослын даатгалд хамруулдаг.
--	--



Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны сургалт, зааварчилгаа

Бид өөрсдийн бизнесийн үйл ажиллагаа болон эрсдэлийн үнэлгээндээ тулгуурлан холбогдох ХЭМАА-ны сургалт явуулах дүрэм, стандарт, журамд нийцүүлэн жил бүр сургалтын хэрэгцээгээ тодорхойлж, нийт ажилтны болон эрсдэлтэй ажлын байрны сургалтуудыг зохион байгуулдаг.

Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Ажилтан бүр ХЭМАА-тай холбоотой шаардлагатай баримт бичгүүдээ MySpace платформд нээлттэй байршуулсан бөгөөд цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой 32 удаагийн зааварчилгаа мэдээллийг нийт ажилтнууддаа илгээж аливаа осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийллээ.

Танхимын сургалтууд

Мөн дотооддоо цахилгаан болон өндрийн аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, гамшгийн дадлага сургуулилт, анхны тусламж, ослыг судлан бүртгэх, даатгалын зохицуулалт зэрэг 28 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж 1,653 ажилтныг хамруулсан байна.

Эрсдэлтэй ажлын байрны сургалт

Эрсдэлтэй ажлын байрны 8-16 цагийн онол, дадлага хосолсон дараах сургалтуудыг зохион байгуулсан ба ажилтнууд дараах байдлаар хамрагдсан.



Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл

Бид ажлын байрны онцлогоос хамаарч ажлыг аюулгүй хийж гүйцэтгэхэд шаардлагатай ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангаж, шат шатандаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

2024 оны онцлох хамгаалах хэрэгслийн шинэчлэлтүүд:

- 1 Өндөрт гарч ажилладаг ажилтнуудынхаа хамгаалах хэрэгслийг шинэчилж Германы Skylotec брэндийн өндрийн иж бүрдэл, аврах иж бүрдэл хэрэгслээр хангаж, ашиглалтын сургалтад хамрууллаа.
- 2 Хязгаарлагдмал орчинд ажилладаг ажилтнуудаа хамгаалахын тулд агаарын чанарын найрлагыг хэмждэг боллоо.
- 3 Үзелийн өрөөнд ажилладаг ажилтнууддаа зориулан гэмтэл саатлын үед хэрэглэх өндөр даралтат халуун устай орчинд өмсөж хэрэглэх иж бүрэн хувцас, хамгаалах хэрэгслээр хангаж аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүллээ.
- 4 Цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийг хариуцан ажилладаг ажилтнууддаа ажил үүргээ гүйцэтгэхдээ өмсөж хэрэглэх CATIII, Arc Flash хамгаалах хэрэгсэл, ослын үед ашиглах тусгай хэрэгслүүдийг олголоо.





Туслан гүйцэтгэгч нарын ХЭМАА-ны хяналт

ХЭМАА-ны хэлтсээс туслан гүйцэтгэгчийг ажиллуулах үеийн аюулгүй ажиллагааг зохицуулах журам гаргаж, түүнийгээ туслан гүйцэтгэгч авч ажиллуулдаг нэгж, ажилтнууддаа хэрхэн хэрэгжүүлэх талаар сургалт, зааварчилгааг өгсөн. Үүнээс хойш компанийн хэмжээнд туслан гүйцэтгэгчийг авч ажиллуулах үедээ сонгон шалгаруулалтаас эхлэн ажлын гүйцэтгэлийг үнэлэх хүртэлх бүх үе шатанд ХЭМАА-ны хяналтыг тавьж, чиглэл өгч хамтран ажиллаж байна. 2024 онд туслан гүйцэтгэгч компанийн үйл ажиллагаанд ХЭМАА-ны хяналт тавьж, тэдний ажилтнуудад ХАБЭА-н тухай хууль болон компанийн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны журам, өндөр болон цахилгааны аюулгүй ажиллагааны сургалтад хамруулав.


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзүүлэлтүүд*

0.44

Нийт мэдээлсэн ослын хувь (TRIR):



Нэг хуанлийн жилд бүтэн цагаар ажилладаг 100 ажилтанд ногдох бүртгэгдсэн осол болон өвчлөлийн тоо



0.32

Ажлаас чөлөөлөгдсөн, хязгаарласан эсвэл шилжүүлсэн өдрүүд (DART):



Нэг хуанлийн жилд бүтэн цагаар ажилладаг 100 ажилтанд ногдох ажлаас чөлөөлөх, ажлыг хязгаарлах эсвэл шилжүүлэх шаардлагатай болсон ослын тоо

4.73

Алдагдсан цагийн хувь (LTC):



Нэг хуанлийн жилд бүтэн цагаар ажилладаг 100 ажилтанд ногдох ажлын цаг алдсан тохиолдлын тоо (ажилтан бүтэн ээлжээр ажиллах боломжгүй болсон, аливаа ажлаас үүдэлтэй гэмтэл, өвчин)

* Ажлын байрны нөхцөл, үйл ажиллагаанаас шалтгаалсан нас баралт, гэмтэл, өвчлөл зэргийг оруулсан болно

** 2023 онтой харьцуулахад TRIR буурсан. 2023 оны TRIR: 0.67

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс нь тохиолдол бүрийг судлан дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг бөгөөд бид тус комисст 2024 онд ХЭМАА-ны нэгж, хүний нөөц, хуулийн багуудаас төлөөлөл оруулан бүтцийн өөрчлөлт хийсэн. Комисст багтсан гишүүд осол, гэмтлийн тохиолдлуудыг бүртгэх, судлах сургалтад хамрагдан хамтран ажиллаж байна.





“Эрүүл ажилтан” хөтөлбөр

Бид ажилтнуудынхаа эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжих зорилгоор 2022 оноос эхлэн “Эрүүл ажилтан” хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүрээнд бид 2024 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- 1 Аливаа халдварт болон халдварт бус өвчлөл, ажлын байрны осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэхээр 692 ажилтныг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамрууллаа.
- 2 Бид томуунаас урьдчилан сэргийлэхийн тулд ажилтнуудаа сайн дурын вакцинжуулалтад жил бүр үнэ төлбөргүй хамруулдаг бөгөөд 2024 онд нийт 649 ажилтан хамрагдлаа.
- 3 10 фитнес төвтэй хөнгөлөлттэй үнийн дүнгээр гэрээ хийн ажилтнууддаа өөрийн гэр, ажилтай ойр байрлах фитнес төвөө сонгон 5-30% хөнгөлөлттэй үнээр хичээллэн, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх боломжийг олголоо.
- 4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажилладаг “Best massage” хараагүйчүүдийн бариа заслын төвд 4 удаа бүтэн биеийн бариа хийлгэх эрхийг ажилтан бүрд олголоо.
- 5 Ажилтныхаа амь нас, эрүүл мэндийг хамгаалж учирч болох санхүүгийн эрсдэлээс нь сэргийлж дараах даатгалуудад хамруулдаг.
 - Компанид анх удаа нийт ажилтан, тэдний гэр бүлд зориулан эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хөтөлбөрийг санал болгон хэрэгжүүлсэн бөгөөд 275 ажилтан гэр бүлээрээ эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрт хамрагдлаа.
 - Ажил үүрийн онцлогоос хамаарч 326 ажилтныг амь нас, эрүүл мэндийн даатгалд хамрууллаа.
 - Мөн албан ажил үүрэг гүйцэтгэхээр гадаад болон дотоодод ажиллаж байгаа ажилтнуудаа албан томилолтын даатгалд, компанийг төлөөлж тэмцээн уралдаанд оролцдог ажилтнуудаа амь нас, эрүүл мэндийн даатгалд тус тус хамрууллаа.


2024 онд

 **692**

ажилтан эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамрагдсан

 **649**

ажилтан томуунаас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамрагдсан





Бизнесийн ёс зүй

Бизнесийн байгууллагууд богино хугацааны ашигт ажиллагаанаас илүүтэйгээр урт хугацааны тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлага, засаглалын ил тод байдал, ёс зүйг эрхэмлэн ажиллах болсон. Бизнесийн ёс зүй нь хууль тогтоомж болон олон улсын стандартыг мөрдөн, компанийн үнэт зүйлс, зарчимд тулгуурласан, нийгэм, байгаль орчин, оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн, хариуцлагатай шийдвэр гаргалтад чиглүүлдэг. Үр дүнд нь байгууллага харилцагчид болон хэрэглэгчидтэйгээ тогтвортой харилцааг бий болгож, итгэлцэл, хариуцлага, шударга ёсыг эрхэмлэсэн, эерэг ажлын байрны соёлыг бүрдүүлж бий болгодог.

Юнител групп нь салбартаа тасралтгүй шинэчлэл хийхийн зэрэгцээ шударга өрсөлдөөн, ёс зүйтэй бизнесийн зарчмыг эрхэмлэн, оролцогч талуудтайгаа хариуцлагатайгаар хамтран ажилласаар ирсэн. Бид бүхий л үйл ажиллагаандаа “зөв” арга замыг баримталж, хамтрагч талууддаа ч ёс зүйн өндөр шаардлага тавьж ажилладаг.



Бид GRC* менежмент, эрсдэлд суурилсан комплаенсийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар бизнесийн ёс зүйг байгууллагатаа төлөвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд бизнесийн чиглэл бүрд хууль эрх зүйн, үйл ажиллагааны, комплаенсийн эрсдэлээ үнэлж, болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэн, үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж байна. Комплаенсийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар ТУЗ-ийн Аудит, эрсдэлийн хороо улирал бүр тогтмол мэдээлэл авч, хяналт тавьдаг.

**Governance, Risk, and Compliance буюу Засаглал, Эрсдэл, Комплаенс*



Ёс зүйтэй соёлыг бэхжүүлэх

Ажилтнуудыг мэдлэг мэдээллээр хангах

Шударга, ёс зүйтэй соёлыг компанидаа бэхжүүлэх зорилгоор бид дотоод комплаенсийн хөтөлбөрийн хүрээнд ажилтнууддаа Ёс зүйн дүрэм, Авлига болон ашиг сонирхлын зөрчил, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зэрэг болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх хүрээнд жил бүр төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулж байна. Мөн ажилтны ажлын чиг үүргээс хамааран шаардлагатай газар, нэгжүүдэд зориулан тусгай сургалтуудыг зохион байгуулж, цаг үеийн мэдээ мэдээллээр хангадаг.

Бид комплаенсийн сургалтуудыг илүү үр дүнтэй, хүртээмжтэй байлгах үүднээс бүх сургалтыг онлайн хэлбэрт шилжүүлснээр ажилтнууд өөрийн хүссэн газартаа, тохиромжтой үедээ суралцах боломжийг бүрдүүлсэн. Цаашид бид ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд комплаенстай холбоотой дэмжлэгийг илүү хялбар, ойлгомжтой, хурдан шуурхай хүргэхэд чиглэн ажиллаж байна.

2024 онд

Үндсэн ажилтнуудын **76%** авлигын эрсдэлээс сэргийлэх сургалтад хамрагдсан. (2023 онтой харьцуулбал 37%-иар өссөн)

Чиг үүрэг бүхий ажилтнуудын **77%** мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэх ерөнхий болон тусгай сургалтад хамрагдсан. (2023 онтой харьцуулбал 8%-иар өссөн)


Шүгэл үлээх

Юнител группийн ажилтнууд, харилцагчид болон гэрээлэгчид бизнесийн харилцааны явцад үүссэн ёс зүйгүй үйлдэл, авлига, ашиг сонирхлын зөрчил, ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалт, санхүүгийн зөрчил зэрэг аливаа хууль бус, ёс зүйгүй үйлдлийг найдвартай, аюулгүй "SpeakOut" сувгаар мэдээлэх боломжтой.

Тус сувгийн онцлог нь:

- **Нууцлалыг чандлан хамгаална:** Мэдээлэгчийн хувийн нууцыг чанд хадгалж, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хамгаална.
- **Нэрээ нууцлах боломжтой:** Мэдээлэгч нэрээ ил болгохгүй мэдээлэх сонголттой.
- **Шуурхай хяналт, арга хэмжээ:** Ирсэн мэдээллийг холбогдох баг хянан шалгаж, зохих арга хэмжээг шуурхай авна.
- **Зөрчил давтагдахаас сэргийлнэ:** Илэрсэн зөрчлийг засах, дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- **Мэдээлэгчийг хамгаална:** Шүгэл үлээгчийг хамгаалах ба түүний эсрэг аливаа сөрөг арга хэмжээ авахыг хориглодог


SpeakOut
hotline

 976-88882027

 <http://speakout.mcs.mn>

 speakout@mcs.mn



Ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэлээс сэргийлэх

Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, хянах, шийдвэрлэх

Юнител группийн ашиг сонирхлын зөрчлийн журмын дагуу

- ТУЗ-ийн бүрэлдэхүүн,
- 6 ба түүнээс дээш зэрэгтэй ажилтан,
- Худалдан авалт болон компанийг төлөөж гэрээ хийх эрх бүхий бүх ажилтнууд

жил бүр өөрийн бодит болон болзошгүй зөрчлийг мэдүүлэх үүрэгтэй байдаг. Комплаенсийн нэгж нь ажилтнуудын мэдүүлсэн бодит болон болзошгүй зөрчлийн мэдүүлэг бүрд тохирох зөвлөмжийг бэлтгэн хүргүүлж, зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг авч ажилладаг.

2024 онд

Ашиг сонирхлын болзошгүй зөрчил **99%** мэдүүлгээ мэдүүлэх үүрэгтэй ажилтнуудын илгээсэн.

(2023 онтой харьцуулбал 13%-иар өссөн)

Нийт **43** болзошгүй зөрчлийг хянаж тухайн ажилтан болон шууд удирдлагад зөвлөмж хүргэсэн.

Бэлэг, бизнес уулзалт, хандив

Юнител групп ямагт авлигын бүх хэлбэрээс ангид байх, үл хүлээн зөвшөөрөх зарчмыг баримталдаг. Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого, журмын дагуу бүх түвшний албан тушаалтнуудын өгсөн болон авсан бэлэг, бизнес уулзалт, улс төр болон сайн үйлсийн хандив зэргийг 'StarCompliance' системд мэдүүлж бүртгэдэг. Тус мэдүүлгийг комплаенсийн нэгж тогтмол хянаж, шаардлагатай дүгнэлт, зөвлөмжөөр ханган ажилладаг.

2024 онд

 **3,618** бэлэг

 **10** бизнес уулзалт

 **1** сайн үйлсийн хандивын

мэдүүлгийг хүлээн авч, шаардлагатай дүгнэлт, зөвлөмжийг хүргэн ажилласан.

Олон улсын хориг арга хэмжээнээс сэргийлэх

Манай байгууллагын үйл ажиллагаа болон Монгол улсын эдийн засгийн орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй хориг арга хэмжээ, мөнгө угаах гэмт үйлдэл болон терроризмын санхүүжилтийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг бууруулах арга хэмжээг бид тасралтгүй хэрэгжүүлдэг.

Бид НҮБ, АНУ, Их Британи, Европын холбооны хориг жагсаалтыг дагаж мөрдөн, харилцагч, гэрээлэгчийг таньж мэдэх ажиллагааг гэрээ байгуулахаас өмнөх болон гэрээ байгуулсны дараах үе шатуудад хэрэгжүүлж, олон улсын комплаенсийн мэдээллийн сангаас харилцагч, гэрээлэгчийг бодит цагийн горимоор шүүн, хориг арга хэмжээний эрсдэлийг тогтмол үнэлдэг. Шаардлагатай тохиолдолд нарийвчилсан магадлан шинжилгээ, комплаенсийн эрсдэлийн дүгнэлт хийж, холбогдох нэгжүүдэд мэдээлэл хүргэн компанийг эрсдэлээс сэргийлж ажилладаг бөгөөд ингэснээрээ компанийн үйл ажиллагаанд төдийгүй Монгол улсын эдийн засгийн эрүүл хөгжилд хувь нэмрээ оруулж байна.

2024 онд

Нийт **3,691** харилцагч, гэрээлэгчийг хориг жагсаалттай тулгаж, шалгасан бөгөөд тэдний 215-ыг нарийвчлан шалгасан.

Группийн хэмжээнд **7.1** сая гүйлгээнд комплаенсийн хяналт хэрэгжүүлсэн байна.



Нийлүүлэгчийн тогтвортой байдал

Юнител группийн бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө нь зөвхөн компанийн үйл ажиллагаанаас бус бидний хамтран ажилладаг нийлүүлэгчдийн тогтвортой байдлаас ч тодорхой хэмжээнд шалтгаалдаг. Тиймээс бид нийгэмд авчрах эерэг өөрчлөлтөө нэмэгдүүлэхийн тулд байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ёс зүйтэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран ажиллахыг зорьж байна.

Нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм

2022 онд компанийн үнэт зүйлс, хэм хэмжээг стандартжуулан дагаж мөрдөх "Нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм"-ийг боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн. Бид тогтвортой, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг эрхэмлэж, ханган нийлүүлэгчдээсээ ил тод, ёс зүйтэй бизнесийн зарчмыг баримтлахыг шаарддаг.

Нийлүүлэгчийн ёс зүйн дүрэмтэй supplier.mcs.mn/policy холбоосоор танилцана үү.

Нийлүүлэгчийн портал

2023 онд М-Си-Эс Групп олон улсын жишигт нийцсэн худалдан авалтын цогц системийг нэвтрүүлсэн нь дотоодын байгууллага, хувь хүмүүст нийлүүлэгчээр бүртгүүлж, худалдан авалтад оролцох боломжийг бий болгосон. Үр дүнд нь харилцагч байгууллагууд тендерт бүртгүүлэх, үнийн санал илгээх, шалгаруулалтын үйл явцтай танилцаж, тодруулга авах зэргээр худалдан авалтын мэдээллийг нэг дороос харж, бүх үе шатыг хянах боломжтой болсон.

Мөн тендерийн бүх явцыг нэгдсэн цахим платформ дээр төвлөрүүлсэн нь манай компани болон харилцагч байгууллагуудын хувьд цаасны хэрэглээг бууруулахад өндөр ач холбогдол үзүүлсэн юм.

2024 онд Юнител групп нийлүүлэгчийн порталын тухай мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор кампанит ажил зохион байгуулсан. Кампанит ажлын хүрээнд боломжит нийлүүлэгчдийг порталд бүртгүүлэхийг уриалж, өрсөлдөхүйц өндөр чадамжтай, олон талт нийлүүлэгчдийг татан оролцуулахыг зорьсон.

Нийлүүлэгчийн портал supplier.mcs.mn

Нийлүүлэгчийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөө


2024 онд Юнител групп худалдан авалтын сонгон шалгаруулалтын явцад боломжит ханган нийлүүлэгчдийн нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх шалгууруудыг боловсруулсан. Үнэлгээнд дотоод болон гаднын бүх нийлүүлэгч хамрагдах бөгөөд үр дүн нь сонгон шалгаруулалтад тодорхой хувиар нөлөөлдөг.

Энэхүү үнэлгээ нь байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд давуу тал олгохын зэрэгцээ, хамтын ажиллагааны боломжийг ч нэмэгдүүлж байдаг. Мөн боломжит нийлүүлэгч нарт тогтвортой байдлын ач холбогдлыг ойлгуулж түүнийг урамшуулахад хувь нэмэр оруулж буй үйл ажиллагаа юм.

2024 онд зарлагдсан 13 ширхэг тендерийн явцад цугларах байсан



1,131 хуудас цаасыг хэмнэсэн



2024 оны эерэг нөлөөтэй санаачилгууд:

- 1 Юнивишний IPTV үйлчилгээнд ашиглагдах Set-top box төхөөрөмжийн худалдан авалтын гэрээг шинэчилж, **65,000 ширхэг** дахин боловсруулсан сав баглаа боодолтой төхөөрөмжийг 2024 онд байгальд ээлтэйгээр худалдан авсан.
- 2 Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй партнерууд болон туслан гүйцэтгэгч компаниудын бараа материалын нөөцийг хянах тогтолцоог нэвтрүүлж, шаардлагагүй их хэмжээний бараа материал татахаас сэргийлэн, хог хаягдал болон нөөцийн үр ашиггүй хэрэглээг бууруулахад анхаарч ажиллаж байна.



БАЙГАЛЬ

1 Электрон хог хаягдлын менежмент

2 Байгаль хамгаалал

3 Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч



Электрон хог хаягдлын менежмент

Орчин үед компаниуд дижитал шилжилт хийж, технологийн хувьслыг илүү хурдасгасаар байна. Илүү өндөр хүчин чадалтай дижитал хэрэгслүүдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр шинэ загварууд өдөр бүр шинэчлэгдэн гарч байгаа нь хуучин төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацааг үлэмж хэмжээгээр богиносгосоор байгаа юм. Ийнхүү электрон хог хаягдал дэлхийн хэмжээнд ихээр хуримтлагдаж, байгаль орчин болоод нийгэмд ноцтой эрсдэл учруулах боллоо. Монгол улсын хувьд электрон хог хаягдлыг аюултай ангилалд оруулдаг хэдий ч зохицуулалтын дэд бүтэц дутмаг, олон нийтийн мэдлэг бага тул электрон хог хаягдлын менежмент хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүд эдгээр бэрхшээлүүдтэй нүүр тулж байна.

Дижитал, технологийн үйлчилгээ үзүүлэгч компанийн хувьд Юнител групп өөрийн сүлжээний дэд бүтэц болон хэрэглэгчдэд үйлчилгээ хүргэх шийдлүүддээ электрон төхөөрөмжүүд ашигладаг. Бид электрон хог хаягдлын хүрээлэн буй орчинд үзүүлэх хор нөлөөг багасгах үүднээс өөрсдийн үйл ажиллагаанаас гарах электрон хаягдлыг зөв зохистой, байгальд ээлтэй байдлаар зохицуулахыг зорьж байна. Ингэхдээ бид “тойрог эдийн засгийн” зарчим дээр тулгуурласан электрон хог хаягдлын менежментийн тогтолцоог бий болгохоор ажиллаж байгаа юм. Цаашлаад электрон хог хаягдлын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх замаар тогтвортой ирээдүй рүү хамтдаа зорихыг эрмэлздэг билээ.



2024 онд

Буцаан цуглуулсан:
11,859 = 2,700 кг
төхөөрөмж электрон хаягдал

Дахин боловсруулсан:
25,650 = 5,900 кг
төхөөрөмж электрон хаягдал*

*2023 онд цуглуулсан төхөөрөмжүүд орно

Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент


Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент нь бүтээгдэхүүн хөгжүүлэлтээс эхлээд үйлдвэрлэл, хэрэглээ, устгал хүртэлх ашиглалтын бүх үе шатыг хянах стратегийн арга юм. Манай компанийн хүрээнд бүтээгдэхүүний амьдралын мөчлөг гэх ойлголт нь Юнивишний гурвалсан үйлчилгээний бүхий л төхөөрөмжүүдэд хамааралтай. Төхөөрөмжүүдийн амьдралын мөчлөг нь нийлүүлэгчээс худалдан авалт хийхээс эхлээд ашиглалтын хугацаа дуусах хүртэл үргэлжилнэ. Юнивишний төхөөрөмжүүд ашиглалтаас гарахад тэдгээр нь хэрэглэгчдийн гарт электрон хаягдал болж үлддэг. Тухайн төхөөрөмж борлуулагдаж хэрэглэгчийн гар дээр очсоны дараа ч манай компанийн хариуцлага гэж бид үздэг учир ашиглалтаас гарсан хаягдал төхөөрөмжүүдийг хэрэглэгчдээсэ сайн дурын үндсэнд буцаан цуглуулж, зөв зохистой аргаар дахин боловсруулж байна.

Юнивишний гурвалсан үйлчилгээ зах зээлд нэвтэрснээс хойш ашиглагдаж байсан Linux-д суурилсан IPTV төхөөрөмж (STB) маань хуучирч, одоогийн IPTV системийг дэмжих боломжгүй болсон тул бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн

2023-2024 онуудад, доорх төхөөрөмжүүдийг хэрэглэгчдээс буцаан цуглуулаад байна:

2023 **15,415**  2024 **10,573**
Set-top Box (STB)

1,965  1,286
Home Gateway (HW)

Нийт **29,239**  **6,700 кг**
төхөөрөмж электрон хаягдал

менежментийг оновчтой шийдэх хэрэгцээ үүссэн билээ. Бид 2023 онд IPTV-ийн бүх хар төхөөрөмжүүдийг сольж, Android-д суурилсан загварт шилжүүлэх иж бүрэн төлөвлөгөөг боловсруулж, үйлчилгээний шинэчлэлийг нэвтрүүлэхийн зэрэгцээ ашиглалтаас гарсан төхөөрөмжүүдийг хариуцлагатай цуглуулж, зөв зохистой устгалд оруулах арга хэмжээг авч эхэлсэн юм.

Түүнчлэн Юнивишний дэд бүтцийг FTTB-ээс FTTH технологи руу шилжүүлэх, IPTV үйлдлийн системд шинэчлэлт оруулах зэрэг үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг оновчлох зорилготой сайжруулалтууд маань хар, цагаан бүх төхөөрөмжийг шинэ, илүү үр ашигтай загваруудаар солих хэрэгцээ үүсгэж байна.

Ашиглалтаас гарсан төхөөрөмжүүд нь Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн дагуу аюултай электрон хог хаягдлын ангилалд багтдаг бөгөөд тэдгээрийг зохицуулах тусгай зөвшөөрөлтэй компаниудад хүлээлгэж өгөх шаардлагатай. Юнител групп нь 2024 онд хаягдал төхөөрөмжүүдийг зохих журмын

дагуу устгаж дахин боловсруулах зорилгоор электрон хог хаягдлыг дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй Нью Метод ХХК-тай хамтран ажиллаж эхлээд байна. Юнител групп хэрэглэгчдээсээ цуглуулсан хуучин төхөөрөмжүүдийг Нью Метод ХХК-д дахин боловсруулалтад хүлээлгэн өгч байна.

Үйлчилгээний чанарыг нэмэгдүүлж, технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн алхахын тулд хэрэглэгчийн төхөөрөмжийг үе үе шинэчилж, солих, сайжруулах хэрэгцээ нэмэгдэж байна. Хэрэглэгчдийн төхөөрөмжийг нийтээр нь солих ажлын туршлагаас харахад төхөөрөмжийн амьдралын мөчлөгийн үе шат болгонд тохиромжтой шийдвэр, алхмуудыг хэрэгжүүлэхийн тулд урьдчилан тодорхойлсон төлөвлөгөөтэй байх нь өндөр ач холбогдолтой. Тиймээс Юнител групп үйл ажиллагааны дотоод процессуудыг нарийн төлөвлөж, бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх нөлөөнд зохицуулалт хийх зорилгоор бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн цогц удирдамжийг боловсруулж байна. Энэхүү удирдамж нь худалдан авахаас эхлээд ашиглалтын хугацаа дуусах хүртэлх

бүх үе шатанд төхөөрөмжийг оновчтойгоор удирдах зорилготой ба төхөөрөмж худалдан авах, ашиглах, засвар үйлчилгээ хийх, сэргээн засварлах, хариуцлагатай устгах арга хэмжээнүүдийг урьдчилан төлөвлөх зэргийг тусгаж өгөөд байна.

Тодорхой протоколуудыг нэвтрүүлснээр үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, ажилтнууд төхөөрөмжийн амьдралын мөчлөгийн үе шатад тохирсон шийдвэрийг шуурхай гаргаж, цаг алдалгүй арга хэмжээ авах боломжтой болно. Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежментийн тогтолцоог зөв тодорхойлсноор солих шаардлагатай төхөөрөмжүүдийг урьдчилан таамаглаж, эртнээс солих төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээ, сэтгэл ханамжид нийцсэн үйлчилгээ үзүүлэх ач холбогдолтой юм.

Түүнчлэн, төхөөрөмжүүдийн ашиглалтаас гарах зайлшгүй хугацааг урьдчилан тодорхойлсноор төхөөрөмжийг устгах, дахин боловсруулах ажлыг төлөвлөж, электрон хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах боломж бий болно.



“No E-Waste” кампанит ажил

Амьдралын мөчлөгийн төгсгөлдөө хүрсэн төхөөрөмжүүдийг хэрэглэгчдээс буцаан цуглуулахад тулгардаг хамгийн том саад бэрхшээл нь олон нийтийн дунд электрон хаягдлын тухай мэдлэг болон мэдээллийн хомс байдал юм. Тиймээс бид 2024 онд хоёр дахь жилдээ 'No E-Waste' нөлөөллийн кампанит ажлыг хэрэгжүүлээ. Уг ажлын хүрээнд бид хэрэглэгчдэд электрон хог хаягдал, түүний байгаль орчинд үзүүлэх хор нөлөөний тухай мэдээллийг өгч, олон нийтийг байгальд хайртай, хариуцлагатай иргэд байхыг уриалж, Юнивишн хаягдал төхөөрөмжүүдийг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай хамтран байгальд ээлтэй байдлаар зохицуулдаг тухай сурталчлахыг зорьсон билээ.



Үйл ажиллгааны электрон хог хаягдлыг бууруулах

Олон нийтэд харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэхэд цахилгаан эрчим хүчний тасалдалгүй, найдвартай ажиллагаа чухал ач холбогдолтой байдаг. Тиймээс бид Дата төв болон үүрэн холбооны сайтууд дээр цахилгаан эрчим хүч хуримтлуулах UPS (тог баригч) системүүдийг ажиллуулдаг бөгөөд, эдгээр системдээ төрөл бүрийн хэмжээтэй батарейнуудыг ихээр ашигладаг. Ингэхдээ бид батарейн хүчин чадал, шаардагдах хөрөнгө оруулалт зэргээс гадна найдвартай байдал, насжилт, байгальд ээлтэй байдал зэрэгт мөн анхаарал хандуулж байна. Бид нийтлэг ашиглаж ирсэн хар тугалганы батарейг ашиглалтаас гармагц литий-ионы батарейгаар үе шаттайгаар сольж байна.

Хар тугалга, хүхрийн хүчил зэрэг байгаль орчин, хүний эрүүл мэндэд хортой химийн нэгдлүүдийг агуулдаг хар тугалганы батарейтай харьцуулахад литий-ионы батарей нь байгаль орчин илүү ээлтэй сонголт юм. Мөн хар тугалганы батарей ашиглалтын хугацаа богинотой ба ашиглалтын нөхцөлөөс хамааран 2-8 жилийн давтамжтай шинээр солих шаардлага үүсдэг. Харин үүнийг ашиглалтын хугацаа урт, овор хэмжээний хувьд илүү жижиг литий-ионы

батарейгаар сольсноор батарей солих давтамж холдож, үйл ажиллагаанаас гарах хортой хог хаягдлын хэмжээг, цаашлаад үйл ажиллагааны зардлыг ч бууруулах боломжтой болж байна. Мөн сервер болон үүрэн станцуудын найдвартай ажиллагаа нэмэгдэж сүлжээний найдвартай байдал сайжрах давуу талтай.

Уламжлалт хар тугалганы батарейтай харьцуулахад литий-ионы батарейн өртөг 2-3 дахин өндөр байдаг хэдий ч энэ нь урт хугацаандаа үр ашигтай хөрөнгө оруулалт гэж бид харж байна. Мөн литий-ионы батарей орчны тогтвортой байдлыг шаарддаг, буруу ашиглалтаас галын эрсдэл үүсэж болзошгүй байдаг. Тиймээс бид литий-ионы батарейг суурилуулах орчинд хяналтын системүүдийг сайжруулах ажлуудыг гүйцэтгээд байна.

Харин батарей солих ажлаас үүсэх хог хаягдлын хувьд, хар тугалганы батарейг дахин боловсруулах бүрэн боломжтой байдаг тул Юнител групп үйл ажиллагаанаасаа үүссэн хаягдал батарейнуудыг дахин боловсруулдаг, тусгай зөвшөөрөлтэй байгууллагад хүлээлгэж өгөхөөр бэлдэж байна.

Дата төв:

2024 онд



Хар тугалганы батарей

80 ш

Насжилт: 8-10 жил болсон
Нийт жин: 2,000кг



Литий-ионы батарей

32 ш

Насжилт: 10+ жил ашиглах боломжтой
Нийт жин: 1,600кг

Үүрэн холбооны сайтууд*:



Хар тугалганы батарей

1,640 ш

Насжилт: 2-5 жил болсон
Нийт жин: 73,800кг



Литий-ионы батарей

410 ш

Насжилт: 5-8 жил ашиглах боломжтой
Нийт жин: 30,750кг

* Монгол орны эрс тэс уур амьсгалаас шалтгаалан үүрэн холбооны сайтууд дээрх батарей ашиглалтын хугацаа бага байдаг

Электрон хог хаягдлыг таниулах

Бид олон нийтийн дунд электрон хаягдлын тухай ойлголт, төсөөллийг нэмэгдүүлэх үүднээс олон жилийн өмнө өргөн хэрэглэгддэг байсан ч одоо хэрэглээнээс гарсан электрон төхөөрөмжүүдийг гол дүр болгон, тэдгээрийн тухай цуврал контентуудыг бүтээж өөрсдийн мэдээллийн сувгуудаар түгээсэн. Мөн эдгээр контентоор бид Зайсан Хиллд 'No E-Waste' гэрэл зургийн үзэсгэлэнг гаргасан юм. Үзэсгэлэнгээр 7 хоногийн туршид нийт 1,500 гаруй хүн зочилж танилцсан байна.



'Clean Up 2024' төсөл

'No E-Waste' кампанит ажлын хүрээнд "CleanUp 2024" төслийг дэмжин оролцсон бөгөөд уг төслөөр дамжуулж оюутан залуучуудын дунд хуванцар болон электрон хог хаягдлын хөр хөнөөлийг таниулах нөлөөллийн аяныг хэрэгжүүлсэн билээ.





Байгаль хамгаалал Ногоон Байгаасай

Хурдацтай хөгжлийн нөлөөгөөр байгальд учрах хор хөнөөлийг хязгаарлах, түүх, байгаль, шинжлэх ухааны давтагдашгүй өвийг хойч үедээ дамжуулан үлдээж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах нь бидний үүрэг хариуцлага төдийгүй тогтвортой, урт удаан амьдралын үндэс юм.

Бизнесийн үйл ажиллагаа явуулах нь нийгэм болон хүрээлэн буй орчинтой харилцах харилцааг бий болгодог бөгөөд бизнесийн шийдвэр бүр байгаль орчин, нийгэмд шууд нөлөөлдөг. Юнител группийн хувьд тогтвортой байдалд хамтын түншлэлийг бэхжүүлж, байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөгөө нэмэгдүүлэх зорилгоор “Ногоон байгаасай” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг билээ. Уг хөтөлбөрөөрөө дамжуулан бид байгаль орчинд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагаануудыг санаачлан, тогтмол хэрэгжүүлдэг.



Зэрлэг амьтдыг ундаалах “Хөв цөөрөм” төсөл

Дэлхийн дулаарлаас үүдэн байгаль дахь усны нөөц, чанар доройтсоор байгаа нь зөвхөн хүн төрөлхтөн бус зэрлэг амьтдын амьдрах орчин доройтох, тоо толгой нь буурах эрсдэлийг бий болгоод байгаа билээ. Тиймээс бид “Хөв цөөрөм” байгуулах төслийг анх 2021 онд санаачилж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж жил бүр үйл ажиллагааныхаа цар хүрээгээ тэлсээр байна.

Хөв төсөл нь Юнител группийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж буй томоохон төслүүдийн нэг бөгөөд зэрлэг амьтдыг ундаалах, амьдрах орчныг нь сайжруулах замаар тэдний тоо толгойн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх үндсэн зорилготой юм. Хөв цөөрмийн ажиллах зарчим маш энгийн. Ус нэвтрүүлдэггүй мембран ашиглан байгалийн усыг газарт нэвчүүлэлгүй тогтоох замаар амьтад ундаалах нөхцөлийг бүрдүүлдэг гэж ойлгож болно. Түүгээр ч зогсохгүй хөв нь цөлжилт болон агаарын хуурайшилтаас сэргийлж, хөрсний чанарыг сайжруулснаар ургамал ургах таатай нөхцөлийг бүрдүүлдэг гэх мэт олон давуу талтай.

2024 онд бид Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн Бодлого зохицуулалтын газартай хамтран төслийнхөө цар хүрээг

улам өргөжүүлсэн. Юнител группийн зүгээс хөв хийх зааварчилгаа, арга зүйн зөвлөгөө, шаардлагатай материалуудаар хангаж, БОУАӨЯ-наас хөв байгуулах цэгүүдийн оновчтой сонголт, явцыг нь хариуцан ажилласан. Ингэснээр бид төслийнхөө хамрах хүрээг төвийн бүс төдийгүй алслагдсан газар нутгууд руу тэлэх боломжтой болсон.

Бид төслийнхөө үр нөлөөг хэмжихээр зарим хөв цөөрөм дээр камер байршуулсан ба камерт аргаль, янгир, үнэг, тас, бүргэд гэх мэт амьтны олон төрөл зүйл олноор ирж ундаалж байгаа нь бичигдсэн байна. Хөв цөөрмийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх судалгаанд Юнител группийн байгуулсан хөвүүд Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэг (ОУБХН)-ийн Улаан номд орсон 30 орчим төрөл зүйлийн (цоохор ирвэс, хар сүүлт зээр, монгол хулан, тахь, янгир, хавтгай, гэх мэт) үндны эх үүсвэрийг бүрдүүлсэн гэх үр дүн гарчээ.

Сонирхуулахад, Юнител группийн инженер техникийн баг алслагдсан сум суурин, багуудад сүлжээ нэвтрүүлэхээр хүний төвлөрөл байхгүй онгон зэлүүд байгальд очиж ажиллах үедээ зэрлэг амьтад усгүйдэх, харангадах аюул тулгарсан байгааг анзаарснаар хөв цөөрөм байгуулах санааг анх гаргаж байсан түүхтэй.





“Ногоон төгөл” мод тарих өдөр

Юнител групп 2021 оноос жил бүрийн хавар ажилтнуудынхаа дунд мод тарих өдрийг зохион байгуулдаг уламжлалтай билээ. Бид уг уламжлалаараа дамжуулан ажилтнуудынхаа нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлж, байгаль орчинд эерэг нөлөө авчрахад өөрсдийн бодит хувь нэмрээ оруулах боломжийг олгодог. Мод нь нүүрсхүчлийн хийг шингээж хүчилтөрөгч ялгаруулахаас гадна уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, агаарын чийгшлийг нэмэгдүүлэх, шороо тоосыг өөртөө шингээж агаар цэвэрлэж, хөрс хамгаалахад чухал нөлөөтэй.

Уг санаачилгыг Нийслэлийн Байгаль орчны газар (НБОГ)-аас дэмжиж, мод тарих газар болон цаашид арчилж хамгаалахад нь хамтарч ажиллахаар 2022 онд Хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.

Бид мод үржүүлгийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагатай хамтран модоо бэлтгэж, заавар зөвлөгөөнийх нь дагуу тарьсан. Бид модоо зөвхөн тариад орхих бус цаашдын арчилгаа, усалгааг тогтмол хийхэд ч мөн анхаардаг. Тиймээс Хайрхан хөгжлийн төвийн ажилтнууд моддын ургалтын явцыг шалгах, услах, шаардлагатай бордоогоор бордох зэрэг тогтмол арчилгааг хариуцахаар харилцан тохиролцсон юм.



2024 онд

63

ажилтан оролцсон

1,000

хайлаас

250

шинэс

50

гацуур

1,300

Нийт мод тарьсан

7,300

2021 оноос хойш тарьсан мод




Багахангай дахь “Шувууны үүр” төсөл

Манай орны уулын болон тал хээрийн бүс нутагт хөнөөлт мэрэгч амьтдын тархалт хэвийн хэмжээнээс хэтрээд байгаа билээ. Энэ нь ургамлын ургац муудах, тачир сийрэг ургацтай болж бэлчээрийн талхагдалд хүргэх эрсдэлийг бий болгож байгаа төдийгүй цаашилбал цөлжилтийн үндсэн шалтгаан болох аюултай. Иймд мэрэгчдийн тоо толгойг бууруулж, тэнцвэртэй түвшинд барих шаардлага үүсэж байна.

Олон улсын болон Монгол оронд хийсэн судалгааны тайлангаас үзэхэд үлийн цагаан оготнын тоо толгойг бууруулах биологийн оновчтой арга нь хээрийн махчин шувуудын үржлийг дэмжих юм.

■ Юнител групп 2022 онд НБОГ-тай хамтран Багахангай дүүргийн нутагт дэвсгэрт махчин шувууны үүр барих төслийг эхлүүлсэн. Тодруулбал, энэхүү төсөл нь махчин шувуудын амьдрах орчныг сайжруулах замаар тэдний тоо толгойг нэмэгдүүлж, улмаар тэдний идэш тэжээл болох мэрэгчдийн тоо толгойг бууруулж, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх юм.



2022 он

Багахангай дүүрэгт махчин шувуудад зориулсан

30 үүр байршуулсан

2023 он

Байршуулсан үүрнүүд дээр чанарын судалгаа хийхэд 25 үүрэнд

189 бодгаль бүртгэгдсэн

2024 он

Эдгээр нь үлийн цагаан оготнын нягтаршлыг 2022 онтой харьцуулахад

30-50% бууруулсан

Мониторинг болон нөлөөллийн судалгааг Монголын Шувуу судлалын нийгэмлэг гүйцэтгэсэн болно.



“Ногоон байгаасай” хөтөлбөрийн үр нөлөө

“Ногоон байгаасай” хөтөлбөр нь төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүн болон хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааны амжилттай жишээ юм. Хөтөлбөрөөрөө дамжуулан бид байгаль экологийн тогтвортой байдалд бодит нөлөө үзүүлж, бусдад үлгэрлэж, хариуцлагатай үйл ажиллагаанд уриалдаг.

Ирэх онуудад бид байгаль орчны чиглэлд хэрэгжүүлж буй төслүүдийнхээ үр нөлөөг судалгаа шинжилгээ дээр үндэслэн гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээгээ оновчтой гаргаж, эерэг нөлөөллөө тогтвортой нэмэгдүүлэхийг зорин ажиллах болно.





Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч

Дэлхийн гадаргуугийн хэм зохих түвшнээс хэтэрч, экологийн тэнцвэрт байдал алдагдаж байгаагийн гол хүчин зүйл нь хүн төрөлхтний явуулж буй бүхий л төрлийн үйл ажиллагаанаас ялгарах хүлэмжийн хий юм. Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлаас шалтгаалан сүүлийн жилүүдэд цаг уурын байдал тогтворгүйжиж, ган гачиг, зуд, ойн түймэр, үер зэрэг гамшигт үзэгдлүүдийн давтамж нэмэгдсээр байна. Тиймээс улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээг бодлогын түвшинд хэлэлцэж, бизнес эрхлэгчид үйл ажиллагааныхаа байгальд учруулах сөрөг нөлөөг бууруулахад анхаарч байна.

Юнител групп хэрэглэгчдэдээ хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан харилцаа холбооны тасралгүй, найдвартай үйлчилгээг үзүүлэхдээ байгаль орчинд учруулах нөлөөгөө үргэлж бууруулахыг зорьдог билээ. Харилцаа холбооны компанийн хувьд үйл ажиллагаандаа нүүрсний цахилгаан станцууд буюу Дулааны цахилгаан станцуудын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг их хэмжээгээр ашигладаг нь компанийн хүлэмжийн хийн ялгарлын ихээхэн хувийг бүрдүүлдэг. Тиймээс бид үйл ажиллагаанаасаа үүсэх хүлэмжийн хийг бууруулах зорилгоор харилцаа холбооны дэд бүтэцдээ шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй ажиллуулах, сэргээгдэх эх үүсвэрүүдийг ашиглан эрчим хүчний хэрэгцээгээ хангах боломжуудыг тогтмол эрэлхийлдэг билээ.

Эрчим хүчний хэрэглээ

Эрчим хүчний хэрэглээ ба хэмнэлт*	Нэгж	2022	2023	2024	Жил хоорондын өөрчлөлт
Нийт эрчим хүчний хэрэглээ		169,201	194,142	210,744	9%
Цахилгааны хэрэглээ (нэгдсэн сүлжээнээс ашигласан)		136,070	150,567	168,931	12%
Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ		8,705	14,032	14,309	2%
Шатахууны хэрэглээ	ГЖ	7,911	11,319	9,200	-19%
Дулааны хэрэглээ		16,515	18,224	18,304	0%
Нийт эрчим хүчний хэмнэлт		188	162	451	178%
Цахилгааны хэмнэлт		-	-	362	-
Дулааны хэмнэлт		-	-	89	-
Эрчим хүчний эрчмийн харьцаа					
Нэг петабайт датад ногдох эрчим хүчний хэрэглээ**	ГЖ/ПБ	138.2	147.5	150.5	2%
Нэг бүтэн цагийн ажилтанд ногдох эрчим хүчний хэрэглээ***	ГЖ/Бүтэн цагийн ажилтнууд	15.8	15.8	16.4	4%

* 2024 оны Тогтвортой байдлын тайланд орон нутаг дахь салбар төлөөлөгчийн газрууд болон үндсэн үйлчилгээний салбаруудын эрчим хүчний хэрэглээний мэдээлэл багтсан. Иймд өмнөх онуудын эрчим хүчний хэрэглээний тоо өмнөх тайланд дүрдсанаас ялгаатай болно. Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс цахилгаан дулааны мэдээлэл хомс байгууламжийн хэрэглээг тооцоолохдоо түүхэн өгөгдөлд суурилсан таамаглалыг ашигласан ба энэхүү таамаглалын аргачлал нь Хүлэмжийн хий (GHG)-н протоколын удирдамжтай нийцнэ.

** Дата төвийн серверүүд болон үүрэн холбооны сайтуудын нийт эрчим хүчний хэрэглээг сүлжээний нийт урсгалын хэмжээнд харьцуулсан.

*** Оффис болон агуулахын нийт эрчим хүчний хэрэглээг бүтэн цагийн ажилтны тоонд харьцуулсан болно.



Эрчим хүчний хэмнэлт

Харилцаа холбооны оператор компанийн хувьд үндсэн үйл ажиллагаа нь эрчим хүчнээс ихээхэн хамааралтай байдаг. Тиймээс бид Дата төв болон үүрэн бааз станцуудын цахилгаан эрчим хүчний хэрэглээг бууруулж, үйл ажиллагаанаасаа үүсэх хүлэмжийн хийн ялгарлаа багасгахыг зорьж байна.

Юнител групп Монгол Улсын Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу “үүрэг хүлээсэн хэрэглэгч”-ийн тоонд ордог. Тийм учраас бид Дата төвд гурван жил тутам хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар эрчим хүчний бүрэн аудит хийлгэдэг бөгөөд уг тайланд тусгагдсан эрчим хүч хэмнэлтийн зөвлөмжид үндэслэн хэмнэлтийн төлөвлөгөө гаргаж, түүнийгээ мөрдөн ажилладаг. Мөн аудитын үр дүн болон хэмнэлтийн төлөвлөгөөний гүйцэтгэлээ Эрчим хүчний зохицуулах хороонд тогтмол тайлагнадаг билээ.

Цахилгаан эрчим хүч хэмнэх хамгийн үр дүнтэй арга бол эрчим хүч ихээр зарцуулдаг хуучирсан тоног төхөөрөмжүүдийг ашигт үйлийн коэффициент өндөр сүүлийн үеийн төхөөрөмжүүдээр шинэчлэн солих юм. 2024 онд бид Дата төвийн сервер болон үүрэн холбооны станцууд дээрх хуучирсан цахилгаан хангамжийн төхөөрөмжүүдийг шинэчлэн сайжруулсан юм. Дата төв болон үүрэн холбооны станцуудын цахилгааны нийт хэрэглээний 20-30% нь хөргөлтийн төхөөрөмжүүдэд ноогддог. Иймд хөргөлтийн төхөөрөмжүүдийг үр дүнтэй, зөв горимоор ажиллуулах, оновчтой хөргөлтийн системийг сонгох нь цахилгаан эрчим хүчний хэмнэлт үүсгэх бас нэгэн арга зам болж байна. 2024 онд, бид Дата төв дээрх серверүүдийн хөргөлтийн төхөөрөмжүүдийн ажиллах тохиргоог оновчилсон бөгөөд үүрэн

холбооны станцууд дээрх зарим төхөөрөмжийг агаар сэлгэлтийн (free cooling) системээр сольсон юм. Мөн цахилгаанаас гадна Дата төв дээрх халаалтын ялтсан бойлеруудыг сольсон нь дулааны эрчим хүчний хэмнэлтийг бий болгож байна.

Эрчим хүчээ хэмнэх нь үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийг бууруулахаас гадна зардлыг ч мөн бууруулах ач холбогдолтой. Тиймээс бид ашиглаж буй тоног төхөөрөмж болон бусад шийдлүүдээ сонгохдоо байгальд ээлтэй байдал болон эрчим хүчний хэмнэлттэй байдлыг нь харгалзан үздэг.

Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ

Юнител групп алслагдсан бүс нутгуудад сүлжээний өргөтгөл хийхдээ нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашигладаг. Ингэснээр эрчим хүчний дутагдалтай бүсэд бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр өөрсдийн хэрэгцээгээ хангах боломжтой болж байгаа юм.

Эрчим хүчний дэд бүтцээс алслагдсан бүсэд бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг өөрийн бааз станцуудын цахилгаан хангамжид ашигласнаар тухайн бүс нутгийн иргэдийг харилцаа холбоогоор хангах боломжийг олгож байгаа юм.

Алслагдсан бүс нутгуудад нарны эрчим хүчээр ажилладаг станцууд байгуулахад цаг уурын эрс тэс уур амьсгалаас эхлээд олон сорилтууд тулгардаг ч бид үүнд хөрөнгө оруулж, үр дүнтэй шийдлүүдийг эрэлхийлсээр байна.



2024 онд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд үр дүн:

	2024 онд бий болгосон хэмнэлт	Ирэх онуудад нэг жилд бий болгох хэмнэлт
Дата төв	409 ГЖ	519 ГЖ
Үүрэн холбооны станцууд	42 ГЖ	127 ГЖ
	Нийт 451 ГЖ	646 ГЖ

2024 оны нийт эрчим хүчний хэмнэлтийн **68%** нь хөргөлтийн системийн сайжруулалтаас бий болсон

2024 онд



33 нарны эрчим хүчээр ажилладаг бааз станц шинээр суурилуулсан



Юнител группийн **6** бааз станц тутмын

1 сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг

Юнител групп бааз станцуудын цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээний **10%-ийг** сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангадаг.



Үйл ажиллагааны эрчим хүч хэмнэлт

Цахилгаан тээврийн хэрэгсэл рүү шилжих давуу талууд

Үйл ажиллагааны зардал болон байгаль орчинд учруулах нөлөөгөө бууруулах зорилгоор бид 2024 онд дотоод шаталтат хөдөлгүүр бүхий SUV ангиллын тээврийн хэрэгслийг цахилгаан тээврийн хэрэгслээр сольсон. Хэдийгээр дэд бүтцийн асуудлаас шалтгаалан цахилгаан тээврийн хэрэгсэл нь Монгол орны нөхцөл байдалд тохиромжгүй ч гэсэн бид нэг тээврийн хэрэгслийг цахилгаан тээврийн хэрэгслээр сольж шинэчилснээр ашиглалтын зардлыг хэмнэж, байгаль орчинд үзүүлэх нөлөөгөө бууруулахад бодитой хувь нэмэр оруулж байгаа юм.

Зардлын хэмнэлт

- Дотоод шаталтат хөдөлгүүр нь үйлдвэрлэсэн эрчим хүчнийхээ ихэнх хувийг дулаан хэлбэрээр алддаг тул цахилгаан тээврийн хэрэгслийн эрчим хүчний үр ашиг дотоод шаталтад хөдөлгүүртэй харьцуулахад өндөр. Тиймдээ ч цахилгаан тээврийн хэрэгсэл нь түлшний зардлыг бууруулахад чухал ач холбогдолтой байдаг.
- Цахилгаан тээврийн хэрэгсэл нь дотоод шаталтат хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад хөдөлгөөнт эд анги (хөдөлгүүр, түлш, тосны шахуурга гэх мэт) харьцангуй бага тул машины эд ангийн элэгдэл бага байдаг. Тэр ч утгаараа засвар үйлчилгээнд зарцуулах санхүүгийн болон бусад нөөцийг хэмнэхэд чухал ач холбогдолтой.

Ялгарлын бууралт

- Цахилгаан тээврийн хэрэгсэл нь өөрөө ямар нэг байдлаар хүлэмжийн хийн шууд ялгарлыг бий болгодоггүй гэдгээрээ байгальд хамгийн ээлтэй унааны нэг болдог. Гэвч нүүрс шатааж үүсдэг цахилгаан нь шууд бусаар хүлэмжийн хийн ялгарлыг тогтмол бий болгодог байна. Гэхдээ төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс цахилгаан ашиглаж буй тээврийн хэрэгсэл нь шатахуунаар ажилладаг тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад хүлэмжийн хий бага ялгаруулдаг.
- Эрчим хүчний хангамжийг 100% сэргээгдэх эх үүсвэрээр шийдэж чадвал хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тэг болгох боломжтой.

Зохицуулалтын давуу тал

- Монгол Улсын Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журмын дагуу дотоод шаталтат хөдөлгүүр бүхий автомашинуудын Улаанбаатар хотын төв хэсгээр явах эрхийг жилд хамгийн багадаа 52 хоногоор буюу 7 хоногт 1 өдөр хязгаарладаг. Харин цахилгаан тээврийн хэрэгслүүдэд энэхүү хязгаарлалт хамаардаггүй.

 **31%**

Тухайн тээврийн хэрэгсэлд ногдох эрчим хүчний зардал 31%-иар буурсан*

*Цахилгаан тээврийн хэрэгслийн эрчим хүчний зардлыг Toki апп-ийн цэнэглэгч станцын тарифаар бодсон болно.

 **65%**

Тухайн тээврийн хэрэгслийн ялгаруулах хүлэмжийн хий 65%-иар буурсан.

 **365 өдөр**

Жилд 365 хоног замын хөдөлгөөнд оролцох эрхтэй

Үйлчилгээний эрчим хүчний хэмнэлт


FTTB-ээс FTTH рүү шилжилт

Бид 2024 онд Юнивишнийн өргөн зурвасын үйлчилгээг Fiber-to-the-Building (FTTB)-ээс Fiber-to-the-Home (FTTH) технологи руу шилжүүлж харилцаа холбооны дэд бүтцийг шинэчлэх том алхмыг эхлүүлсэн. Тодруулбал, цахилгаанаар ажилладаг MDU түгээлтийн зангилаануудын хэрэглээг халж, хуучирсан зэс кабелийг оптик шилэн кабелиар сольсноор сүлжээний гүйцэтгэл, найдвартай байдлыг сайжруулан, хамрах хүрээг өргөтгөсөн юм. FTTB-ээс ялгаатай нь FTTH технологи нь илүү тогтвортой, өндөр хурдтай (1-50 Гбит/с) интернэтийн хүчин чадалтай бөгөөд MDU-ийн аливаа гэмтэл саатлаас болж үйлчилгээ тасалддаггүй. Тиймээс FTTH нь Юнивишнийн дэд бүтцийн ирээдүй болох Fiber-to-the-Room (FTTR) технологийг нэвтрүүлэх замын суурь нь болж байгаа гэж харж байна.

MDU төхөөрөмж нь барилга дотор өргөн зурвасын сүлжээг түгээх зориулалттай бөгөөд цахилгаан эрчим хүчээр ажилладаг. Иймд цахилгааны тасалдал тохиох бүрд үйлчилгээ тасалдаж, үйл ажиллагааны эрсдэл болоод зардлыг нэмэгдүүлдэг байна. MDU төхөөрөмжийг халж, шилэн холболтыг айл өрхүүдэд шууд хүргэснээр бид эрчим хүчний хэрэглээгээ бууруулахын зэрэгцээ засвар үйлчилгээний зардлыг багасгаж, гэмтэл саатал үүсэх тохиолдлыг боломжит хамгийн бага түвшинд барьж байна.

Бид 2024 онд уг төслийг туршилт байдлаар эхлүүлсэн бөгөөд 2025 он гэхэд үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, дараагийн 10 жилийн турш үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа юм. Ирэх гурван жилийн хугацаанд бид 70 мянган өрхийг шилэн холболт руу шилжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд урт хугацаандаа бүх FTTB-ээр холбогдсон барилгуудыг FTTH технологид шилжүүлж, хэрэглэгчдэдээ тогтвортой, чанартай үйлчилгээг үзүүлэхийг зорьж байна.

Fibre to the Home (FTTH)



2024 онд



2,029

Орон нутаг дахь FTTH рүү шилжсэн өрхийн тоо



112 MDU

төхөөрөмжийг хэрэглээнээс халсан



48.3 гж

2024 оны шилжилтийн үр дүнд ирэх онуудад хэмнэгдэх эрчим хүчний хэмжээ



Хүлэмжийн хийн ялгарлын тооллого

Хүлэмжийн хийн ялгарал ба бууруулалт*	Нэгж	2022	2023	2024	Жил хоорондын өөрчлөлт
Нийт хүлэмжийн хийн ялгарал (Хамрах хүрээ 1 ба 2)		30,649	34,157	38,053	11%
Хамрах хүрээ 1 ялгарал		744	1,070	1,133	6%
Суурин шаталт		373	639	512	-20%
Хөдөлгөөнт шаталт		214	201	171	-15%
Алдагдсан хийн ялгарал		157	230	450	95%
Хамрах хүрээ 2 ялгарал	тонн CO ₂ e	29,905	33,087	36,920	12%
Худалдан авсан цахилгаан		28,348	31,368	35,194	12%
Худалдан авсан дулаан		1,557	1,719	1,726	0%
Ялгарахаас сэргийлсэн хүлэмжийн хийн тоо хэмжээ		1,853	2,957	3,075	4%
Сэргээгдэх эрчим хүчээр		1,814	2,923	2,981	2%
Эрчим хүч хэмнэлтийн санаачилгуудаар		39	34	94	178%
Хүлэмжийн хийн ялгарлын эрчмийн харьцаа					
Нэг петабайт датад ногдох хүлэмжийн хийн ялгарал**	тонн CO ₂ e / ПБ	26.4	27.2	28.2	4%
Нэг бүтэн цагийн ажилтанд ногдох хүлэмжийн хийн ялгарал***	тонн CO ₂ e / Бүтэн цагийн ажилтнууд	2.0	1.9	2.1	12%

* Юнител группийн хүлэмжийн хийн тооллого нь CO₂, CH₄, N₂O ялгаруулалтыг тооцоолдог.

* 2024 оны Тогтвортой байдлын тайланд хөргөлтийн бодисоос ялгарах хүлэмжийн хийг Хамрах хүрээ 1-т багтаан тооцоолсон болно

* Ялгарлыг тооцоолох хүчин зүйлс болон дэлхийн дулаарлын потенциалыг Засгийн Газрын Уур амьсгалын өөрчлөлтийн хороо (IPCC)-ны удирдамж, IPCC-ийн 5 дугаар үнэлгээний тайлан, Монгол Улсын Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан CO₂ хэмжих, тайлагнах, баталгаажуулах (MRV) удирдамж зэрэг албан ёсны эх сурвалжийг ашиглан шинэчилсэн. Өмнөх онуудын Хамрах хүрээ 1 болон 2-т дурдсан ялгарлын хэмжээг эдгээр шинэчлэлд үндэслэн дахин тооцоолсон бөгөөд өмнөх тайлангуудад дурдсан хэмжээнээс ялгаатай байж болно.

* 2024 оны хүлэмжийн хийн тооллогод гуравдагч талын баталгаажуулалт хийгдээгүй болно.

** Дата төвийн серверүүд болон үүрэн холбооны сайтуудын нийт хүлэмжийн хийн ялгарлыг сүлжээний нийт урсгалын хэмжээнд харьцуулсан.

*** Оффис болон агуулахын нийт хүлэмжийн хийн ялгарлыг бүтэн цагийн ажилтны тоонд харьцуулсан.





ХАВСРАЛТ

1 БОНЗ-ын материаллаг асуудлууд ба тэдгээрийн тайлбар

2 Тайлагналын олон улсын санаачилга (GRI)-ын индекс

3 Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн индекс




Тайлангийн тухай

Санхүүгийн бус тайлагнал болох тухай

Санхүүгийн бус мэдээлэл нь тухайн мэдээллийн онцлог, тодорхойлох арга барилын хязгаарлагдмал байдлаас үүдэн хэмжилтийн эргэлзээг үүсгэж болно. Иймээс энэхүү тайланд тусгасан зарим мэдээлэл нь таамаглалд үндэслэн боловсруулагдлаа. Хэмжилтийн ялгаатай ч хүлээн зөвшөөрөгддөг арга барилуудыг ашигласны улмаас хэмжигдэхүүний үр дүнгүүд ялгаатай гарах боломжтой. Түүнчлэн нарийвчлалын арга барил ч өөр байдлаар илэрч болно.

Мэдээллийн үнэн зөв байдал

Энэхүү тайланд тусгасан мэдээллийг бэлдэх, болон үнэн зөв байдлыг Юнител группийн удирдлага хариуцна. Тайланд дурдсан мэдээллийг баталгаажуулалтын дотоод процедурын дагуу хянасан бөгөөд манай тогтвортой байдлын үйл ажиллагаа болон түүний гүйцэтгэлийг үнэн зөвөөр илэрхийлж байгаа гэдэгт итгэлтэй байна. Бид БОНЗ-ын тайлагналын хамрах хүрээний дагуу материаллаг асуудлуудаа тодорхойлон, өгөгдөл цуглуулах процессоо тогтмол сайжруулсаар байна. Тайланг бэлдэх үеийн байдлаар Юнител групп нь БОНЗ-ын индикатор, шинжилгээнд хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэдэггүй.





Юнител группийн БОНЗ-ын материаллаг асуудлууд болон тэдгээрийн тайлбар

Материаллаг асуудал	Тайлбар
Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарал	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, холбогдох эрсдэлийг үнэлж удирдах, энэ чиглэлд технологийн боломжийг ашиглах зэргээр бизнесийн үйл ажиллагаандаа уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлогыг тусгах
Эрчим хүчний хэмнэлт ба сэргээгдэх эрчим хүч	Эрчим хүчний хэрэглээний байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулахын тулд компанийн бүх үйл ажиллагаанд цахилгаан хэрэглээг бууруулах, хэмнэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр рүү шилжих зэрэг стратегийг баримтлах
Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг ба цахим хог хаягдлын зохицуулалт	<ul style="list-style-type: none"> Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үнэлгээг хийх, дахин боловсруулах, дахин ашиглах, буцаан татах зэрэг стратегийг ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах Хэрэглэгчдэд аливаа бүтээгдэхүүн үйлчилгээний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдлэг олгох
Аюултай болон хатуу хог хаягдал	Компанийн үйл ажиллагааны явцад бий болсон хог хаягдлыг зохицуулах (буруулах, дахин боловсруулах, дахин ашиглах, устгах)
Усны хэрэглээ	Компанийн үйл ажиллагааны улмаас усны нөөцөд үзүүлэх одоогийн болон ирээдүйн нөлөөг бууруулах стратеги, арга хэмжээг хэрэгжүүлэх
Цахим хуваагдал ба үнийн хүртээмжтэй байдал	<ul style="list-style-type: none"> ШИМТ (STEM) -д суурилсан үр чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, цахим болон хэвлэл мэдээллийн боловсролд хөрөнгө оруулах Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн хүртээмжтэй байдлыг дэмжсэн үйл ажиллагаа явуулах
Гамшгийн үеийн хариу арга хэмжээ	Гамшгийн бүх үед үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө ба үүнд сүлжээний бэлэн байдал, хариу арга хэмжээ, хандив тусламж, ажилтнуудын оролцоо, сайн дурын үйл ажиллагаа зэрэг багтана. Мөн анхны тусламж үзүүлэх, аврах багийнхны хүчин чармайлтыг дэмжих, гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх тухай ойлголт юм.
Үйлчилгээний хүртээмжтэй байдал	Тусгай хэрэгцээт болон өндөр настай хэрэглэгчдийн хэрэгцээнд тохирох хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох
Олон нийтийн оролцоо ба хандив	<ul style="list-style-type: none"> Компанийн үнэт зүйл, тэргүүлэх чиглэлтэй нийцэж буй сайн үйлсийг дэмжих, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах Хандивын аян, сайн дурын үйл ажиллагаанд ажилтнуудын оролцоог дэмжих
Бүтээгдэхүүний үйлчилгээний нөхцөл, зар сурталчилгааны ил тод байдал	Бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх хариуцлагатай, үнэн зөв мэдээллийг хүргэж, зар сурталчилгааны ил тод байдлыг хангах
Хариуцлагатай хэрэглээ ба бүтээгдэхүүний аюулгүй байдал	Хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээг өөрт болон гэр бүлийнхэндээ хамгийн тохиромжтой, аюулгүй байдлаар ашиглахад нь зориулж шаардлагатай мэдлэг мэдээллээр хангах
Нийлүүлэлтийн гинжин сүлжээ дэх хариуцлага, тогтвортой, олон талт байдал	Нийлүүлэгчид болон харилцагчдаас хөдөлмөрийн аюулгүй байдал, бизнесийн ёс зүй, нийгэм, байгаль орчны стандарт, хэм хэмжээг мөрдөж ажиллахыг шаардах

Хүний эрх	<ul style="list-style-type: none"> Хүний эрхийн магадлан шинжилгээ хийх Оролцогч талуудтай харилцах бүх үед хүний эрхийг хүндэтгэж хамгаалах
Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй, сайн сайхан байдал	Ажилтнуудын ажлын байран дээрх эрүүл, аюулгүй байдлыг хангах, биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн хөтөлбөрт хамруулах
Ажилтнуудын олон талт, тэгш байдал, оролцоо	Бие биеэсээ ялгаатай ажилтнуудыг төвлөрүүлэх, бүх ажилтныг сурч, өсөж хөгжих, тэгш боломжоор хангах, байгууллагын соёлд суралцуулах
Ажил горилогчийг татах, ажилтнуудын оролцоог нэмэх, ажилтныг хадгалах	Авьяаслаг, идэвх зүтгэлтэй ажилтнуудыг татах, хадгалж үлдэх стратегийг хэрэгжүүлэх (суралцах, өсөж хөгжих таатай боломжоор хангах, ажлын цагийн болон ажиллах уян хатан нөхцөлийг бий болгох, ажилтны сайн сайхан байдлыг дэмжих, ажлын байраар дамжуулан олон нийтийн үйл ажиллагаанд оролцох боломжийг бүрдүүлэх гэх мэт)
Сүлжээний чанар, найдвартай байдал	<ul style="list-style-type: none"> Сүлжээний найдвартай байдал, хурд, хамрах хүрээ, ерөнхий гүйцэтгэлийг хангахын тулд тогтмол хөрөнгө оруулалт хийн сайжруулах Урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдалд сүлжээний найдвартай байдлыг хангах, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах
Сүлжээ болон мэдээллийн аюулгүй байдал	Сүлжээний болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах, зөвшөөрөлгүй ашиглах болон халдлагаас урьдчилан сэргийлэх стратегийг хэрэгжүүлэх
Хувийн нууц	Хэрэглэгчийн хувийн мэдээлэлд хэн нэгэн хандах боломжийг хязгаарлах, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах бодлого хэрэгжүүлэх
Технологийн инновац	Хиймэл оюун (AI), юмсын интернэт (IoT), 5G, машин сургалт (ML) зэрэг технологийн дэвшлийг бүтээгдэхүүн, үйлчилгээндээ нэвтрүүлэх
Зохицуулалтын нийцэл	Нийцлийн сургалт, аудит зэргээр бизнесийн үйл ажиллагааг шударга байлгах процедуруудыг дагаж мөрдөх
Интернэтийн засаглал ба дижитал эрх чөлөө	Интернэтийн тэгш хүртээмжийг хангахад хөрөнгө оруулах, сайжруулах
Бизнесийн ёс зүй, ёс зүйтэй соёл	Залилан, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчил зэргийг бодлого, журам, сургалтаар удирдах, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх
Шударга өрсөлдөөн	Шударга, тэгш өрсөлдөөнийг хангах
Бизнесийн тогтвортой, тасралтгүй байдал	Нийлүүлэлтийн сүлжээний бат бөх, тогтвортой байдлыг хангах, технологийн хувьсал, нийгэм, засаглал, улс төр, байгаль орчны өөрчлөлт, сорилтуудад дасан зохицох чадвараа дээшлүүлэх
ТҮЗ-өөс БОНЗ-д тавих хяналт	ТҮЗ нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, боломж, нийлүүлэлтийн хариуцлагатай гинжин сүлжээ, хөдөлмөрийн харилцаа зэрэг БОНЗ-тай холбоотой чиг үүргийг хариуцаж, хяналт тавьдаг байх

Манай компанийн бизнесийн хувьд БОНЗ-ын ач холбогдолтой асуудлуудыг тодорхойлох, эрэмбэлэх зорилготой материаллаг байдлын үнэлгээг хийхдээ дээрх тайлбарыг ашигласан. [Материаллаг байдлын матрицаас](#) илүү дэлгэрэнгүйг үзнэ үү.



Тайлагналын олон улсын санаачилга (GRI)-ын индекс

Код #	Тайлагнах асуудлууд	2024 оны хариултууд
GRI 2: Ерөнхий тайлагнал 2021		
Байгууллага болон тайлагналын үйл ажиллагаа		
2-1	Байгууллагын мэдээлэл	Юнител групп нь Улаанбаатар хотод төвтэй, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм.
2-2	Байгууллагын тогтвортой байдлын тайлагналд хамрагдсан этгээдүүд	БОНЗ-ын хандлага Хавсралт
2-3	Тайлагналын хугацаа, давтамж болон холбогдох этгээд	Тайлангийн хамрах хугацаа: өөрөөр тусгаагүй бол 2024 оны 1-р сарын 1-ээс 12-р сарын 31. Давтамж: Юнител групп Тогтвортой байдлын тайлангаа жил бүр гаргаж байна. Олон нийтэд түгээсэн хугацаа: 2025 оны дөрөвдүгээр сар Холбогдох: sustainability@unitel.mn
2-4	Мэдээллийн тодруулга	Тодруулга байхгүй.
2-5	Хөндлөнгийн баталгаа	Юнител групп тогтвортой байдлын тайландаа хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэдэггүй.
Үйл ажиллагаа болон ажилтнууд		
2-6	Үйл ажиллагаа, үнэ цэнийн гинж болон бусад бизнесийн харилцаа холбоо	Хүн > Нийлүүлэгчийн тогтвортой байдал
2-7	Ажилтнууд	Хүн > Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал
2-8	Хөдөлмөрийн гэрээт бус ажил гүйцэтгэгчид	Хүн > Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал
Засаглал		
2-9	Засаглалын бүтэц болон бүрэлдэхүүн	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал

2-10	ТҮЗ-ийн гишүүдийн томилгоо болон сонгон шалгаруулалт	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал
2-11	ТҮЗ-ийн дарга	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал
2-12	Нөлөөллийг удирдахад байгууллагын удирдлагын гүйцэтгэх үүрэг	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал БОНЗ-ын хандлага > Тогтвортой байдлын засаглал
2-13	Нөлөөллийг удирдах хариуцлагын хуваарилалт	БОНЗ-ын хандлага > Тогтвортой байдлын засаглал
2-14	Тогтвортой байдлыг тайлагнахад ТҮЗ-ийн оролцоо	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал БОНЗ-ын хандлага > Тогтвортой байдлын засаглал
2-15	Ашиг сонирхлын зөрчил	Хүн > Бизнесийн ёс зүй
2-16	Нэн чухал асуудлын харилцаа холбоо	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал
2-17	ТҮЗ-ийн нэгдсэн мэдлэг	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал
2-18	ТҮЗ-ийн гүйцэтгэлийн үнэлгээ	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал
2-19	Цалин урамшууллын бодлого	N/A
2-20	Цалин урамшууллыг тогтоох процесс	N/A
2-21	Цалин урамшууллын харьцаа	N/A
Стратеги, бодлого, үйл ажиллагаа		
2-22	Удирдлагаас гаргасан мэдэгдэл	Гүйцэтгэх захирлын зурвас
2-23	Бодлогын амлалт	Гүйцэтгэх захирлын зурвас
2-24	Бодлогын амлалтын хэрэгжилт	Гүйцэтгэх захирлын зурвас
2-25	Сөрөг нөлөөг сааруулах процесс	Гүйцэтгэх захирлын зурвас
2-26	Зөвлөгөө авах, асуудал дэвшүүлэх механизм	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал
2-27	Хууль болон зохицуулалтын орчны нийцэл	Хүн > Бизнесийн ёс зүй
2-28	Гишүүнчлэл	N/A



Оролцогч талуудын оролцоо		
2-29	Оролцогч талуудын оролцоог хангах хандлага	БОНЗ-ын хандлага > Оролцогч талуудын оролцоо
2-30	Үйлдвэрчний эвлэл	Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулагддаг.
GRI 3: Материаллаг асуудлууд 2021		
3-1	Материаллаг асуудлуудыг тодорхойлох процесс	БОНЗ-ын хандлага > БОНЗ-ын материаллаг байдлын үнэлгээ
3-2	Материаллаг асуудлуудын жагсаалт	Хавсралт > Юнител группийн БОНЗ-ын материаллаг асуудлууд болон тэдгээрийн тайлбар
Материаллаг асуудал: ТҮЗ-өөс БОНЗ-д тавих хяналт		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал БОНЗ-ын хандлага > Тогтвортой байдлын засаглал
GRI 405: Олон талт болон тэгш боломж 2016		
405-1	Удирдлага болон ажилтнуудын олон талт байдал	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал
Материаллаг асуудал: Сүлжээний чанар, найдвартай байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Технологи > Сүлжээний чанар, найдвартай байдал
GRI 203: Эдийн засгийн шууд бус нөлөө 2016		
203-1	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон дэмжсэн үйл ажиллагаа	Технологи > Сүлжээний чанар, найдвартай байдал
203-2	Эдийн засгийн ач холбогдол бүхий шууд бус нөлөө	Технологи > Сүлжээний чанар, найдвартай байдал
Материаллаг асуудал: Сүлжээ болон мэдээллийн аюулгүй байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Технологи > Мэдээллийн аюулгүй байдал
GRI 203: Эдийн засгийн шууд бус нөлөө 2016		
203-2	Эдийн засгийн ач холбогдол бүхий шууд бус нөлөө	Технологи > Мэдээллийн аюулгүй байдал
Материаллаг асуудал: Цахим хуваагдал ба үнийн хүртээмжтэй байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Технологи > Дижитал шилжилт Хүн > Цахим хуваагдлыг бууруулах ажлууд
GRI 203: Эдийн засгийн шууд бус нөлөө 2016		
203-1	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон дэмжсэн үйл ажиллагаа	Технологи > Дижитал шилжилт
203-2	Эдийн засгийн ач холбогдол бүхий шууд бус нөлөө	Технологи > Дижитал шилжилт
GRI 413: Орон нутаг болон олон нийт 2016		
413-1	Орон нутгийн олон нийтийн оролцоот үйл ажиллагаа, нөлөөллийн үнэлгээ болон хөгжлийн хөтөлбөрүүд	Хүн > Цахим хуваагдлыг бууруулах ажлууд
413-2	Орон нутгийн олон нийтэд учруулж буй ач холбогдол бүхий бодит болон боломжит сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа	Хүн > Цахим хуваагдлыг бууруулах ажлууд
Материаллаг асуудал: Үйлчилгээний хүртээмжтэй байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Технологи > Дижитал шилжилт

GRI 203: Эдийн засгийн шууд бус нөлөө 2016		
203-1	Дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон дэмжсэн үйл ажиллагаа	Технологи > Дижитал шилжилт
203-2	Эдийн засгийн ач холбогдол бүхий шууд бус нөлөө	Технологи > Дижитал шилжилт
Материаллаг асуудал: Бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл, зар сурталчилгааны ил тод байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Технологи > Үйлчилгээний ил тод байдал
GRI 203: Эдийн засгийн шууд бус нөлөө 2016		
203-2	Эдийн засгийн ач холбогдол бүхий шууд бус нөлөө	Технологи > Үйлчилгээний ил тод байдал
Материаллаг асуудал: Олон нийтийн оролцоо ба хандив		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Хүн > Цахим хуваагдлыг бууруулах ажлууд Хүн > Нийгэмд тустай ажлууд Байгаль > Байгаль хамгаалал
GRI 304: Биологийн олон янз байдал 2016		
304-2	Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний биологийн олон янз байдалд үзүүлэх ач холбогдол бүхий нөлөө	Байгаль > Байгаль хамгаалал
304-4	Үйл ажиллагаа явуулж буй талбайд нутаглаж буй Улаан номонд орсон төрөл зүйл	Байгаль > Байгаль хамгаалал
GRI 413: Орон нутаг болон олон нийт 2016		
413-1	Орон нутгийн олон нийтийн оролцоот үйл ажиллагаа, нөлөөллийн үнэлгээ болон хөгжлийн хөтөлбөрүүд	Хүн > Цахим хуваагдлыг бууруулах ажлууд Хүн > Нийгэмд тустай ажлууд
413-2	Орон нутгийн олон нийтэд учруулж буй ач холбогдол бүхий бодит болон боломжит сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа	Хүн > Цахим хуваагдлыг бууруулах ажлууд Хүн > Нийгэмд тустай ажлууд Байгаль > Байгаль хамгаалал
Материаллаг асуудал: Ажил горилогчийг татах, ажилтнуудын оролцоог нэмэх, ажилтныг хадгалах		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Хүн > Байгууллагын соёл Хүн > Ажилтнуудын сайн сайхан байдал
GRI 202: Зах зээлийн оролцоо 2016		
202-1	Анхан түвшний ажилтны жендерээр ялгасан стандарт цалин урамшуулал болон хөдөлмөрийн доод хэмжээний харьцаа	Хүн > Ажилтнуудын сайн сайхан байдал
GRI 401: Ажил эрхлэлт 2016		
401-2	Бүтэн цагийн хөдөлмөрийн гэрээтэй ажилтнуудын урамшуулал	Хүн > Ажилтнуудын сайн сайхан байдал
GRI 404: Сургалт хөгжил, боловсрол 2016		
404-1	Ажилтнуудын жилд сургалтад хамрагдсан дундаж хугацаа	Хүн > Байгууллагын соёл
404-2	Ажилтнуудын чадварыг дээшлүүлэх, шилжин ажиллахад дэмжих хөтөлбөрүүд	Хүн > Байгууллагын соёл
404-3	Гүйцэтгэлийн болон карьер хөгжлийн үнэлгээ тогтмол авч буй ажилтнуудын хувь	Хүн > Байгууллагын соёл



Материаллаг асуудал: Ажилтнуудын олон талт, тэгш байдал, оролцоо		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Хүн > Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал
GRI 405: Олон талт болон тэгш боломж 2016		
405-1	Удирдлага болон ажилтнуудын олон талт байдал	БОНЗ-ын хандлага > Компанийн засаглал Хүн > Олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдал
Material topic: Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй, сайн сайхан байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
GRI 403: Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал 2018		
403-1	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны систем	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
403-2	Аюулыг тодорхойлох, эрсдэлийн үнэлгээ болон тохиолдлын судалгаа	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
403-3	Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
403-4	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай ажилтны оролцоо, зөвлөгөө, харилцаа холбоо	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
403-5	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай сургалт, зааварчилгаа	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
403-6	Ажилтны эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
403-7	Бизнесийн харилцаатай шууд холбоотой хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын нөлөөнөөс урьдчилан сэргийлэх болон бууруулах	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
403-8	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын системээр зохицуулагдаж буй ажилтнууд	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
403-9	Ажилтай холбоотой гэмтэл бэртэл	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
403-10	Ажилтай холбоотой эрүүл мэндийн хүндрэл	Хүн > Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа
Материаллаг асуудал: Бизнесийн ёс зүй, ёс зүйтэй соёл		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Хүн > Бизнесийн ёс зүй
GRI 205: Авлигын эсрэг үйл ажиллагаа 2016		
205-2	Авлигын эсрэг бодлого, үйл ажиллагааны тухай сургалт, мэдээлэл	Хүн > Бизнесийн ёс зүй
Материаллаг асуудал: Нийлүүлэлтийн гинжин сүлжээ дэх хариуцлага, тогтвортой, олон талт байдал		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Хүн > Нийлүүлэгчийн тогтвортой байдал
GRI 204: Худалдан авалтын үйл ажиллагаа 2016		
204-1	Дотоод нийлүүлэгчдээс авсан зарцуулалтын хувь	Хүн > Нийлүүлэгчийн тогтвортой байдал
GRI 308: Нийлүүлэгчийн байгаль орчны үнэлгээ 2016		
308-1	Байгаль орчны шалгуураар үнэлэгдсэн шинэ ханган нийлүүлэгчид	Хүн > Нийлүүлэгчийн тогтвортой байдал

308-2	Нийлүүлэлтийн сүлжээн дэх байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө, авсан арга хэмжээ	Хүн > Нийлүүлэгчийн тогтвортой байдал
GRI 414: Нийлүүлэгчийн нийгмийн үнэлгээ 2016		
414-1	Нийгмийн шалгуураар үнэлэгдсэн шинэ ханган нийлүүлэгчид	Хүн > Нийлүүлэгчийн тогтвортой байдал
Материаллаг асуудал: Бүтээгдэхүүний амьдралын мөчлөг ба цахим хог хаягдлын зохицуулалт		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Байгаль > Электрон хог хаягдлын менежмент
GRI 306: Хог хаягдал 2020		
306-1	Ялгаруулсан хог хаягдал болон түүний ач холбогдол бүхий нөлөө	Байгаль > Электрон хог хаягдлын менежмент
306-2	Хог хаягдлын ач холбогдол бүхий нөлөөний удирдлага	Байгаль > Электрон хог хаягдлын менежмент
306-3	Ялгаруулсан хог хаягдал	Байгаль > Электрон хог хаягдлын менежмент
306-4	Зорилго, зориулалтыг нь өөрчлөн ашигласан хог хаягдал	Байгаль > Электрон хог хаягдлын менежмент
GRI 203: Эдийн засгийн шууд бүс нөлөө 2016		
203-2	Эдийн засгийн ач холбогдол бүхий шууд бүс нөлөө	Байгаль > Электрон хог хаягдлын менежмент
Материаллаг асуудал: Үүр амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарал + Эрчим хүчний хэмнэлт ба сэргээгдэх эрчим хүч		
3-3	Материаллаг асуудлуудын удирдлага	Байгаль > Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч
GRI 302: Эрчим хүч 2016		
302-1	Байгууллагын эрчим хүчний хэрэглээ	Байгаль > Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч
302-3	Эрчим хүчний эрчим	Байгаль > Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч
302-4	Эрчим хүчний хэрэглээг бууралт	Байгаль > Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч
GRI 305: Хүлэмжийн хийн ялгарал 2016		
305-1	Компанийн шууд (Хамрах хүрээ 1) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал	Байгаль > Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч
305-2	Эрчим хүчний шууд бүс (Хамрах хүрээ 2) хүлэмжийн хийн ялгарал	Байгаль > Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч
305-4	Хүлэмжийн хийн ялгарлын эрчим	Байгаль > Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч
305-5	Хүлэмжийн хийн ялгарлын бууралт	Байгаль > Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч
GRI 201: Эдийн засгийн гүйцэтгэл 2016		
201-2	Санхүүгийн үр дагавар болон бусад эрсдэл болон боломжууд	Байгаль > Эрчим хүчний хэмнэлт болон сэргээгдэх эрчим хүч



Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (SASB)-ийн индекс

Бизнесийн байгууллагууд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС буюу IFRS) болон Тогтвортой байдлын нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөл (ТБНБСЗ буюу SASB)-ийн стандартуудыг дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-д ээлтэй хөрөнгө оруулалт хийж, шийдвэр гаргах боломжтой. Түүнчлэн компаниуд тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн талаар тодорхой ойлголттой байснаар өөрсдийн үйл ажиллагаа төдийгүй улс орны нийгэм, эдийн засагт үнэ цэнтэй хувь нэмэр оруулах юм.

Бидний хувьд энэхүү тайланг бэлтгэхдээ ТБНБСЗ: Харилцаа холбоо (SASB: Telecommunications) стандартыг мөрдөж, тайлагналын сэдэв болон нягтлан бодох бүртгэлийн метрикүүдээ тодорхойлсон. Хүснэгтэд тоон болон чанарын мэдээллүүдийг тусгасан бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар оруулсан болно. Уг үзүүлэлтүүд нь 2024 оны 12-р сарын 31-нийг дуусталх хугацааг хамарна.

Тайланд тусгасан мэдээллүүдийг материаллаг байдал эсвэл санхүүгийн нөлөөг тодорхойлох зорилгоор ашиглахыг хориглоно.

SASB үйл ажиллагааны метрикүүд

Сэдэв	SASB Код	Хэмжих нэгж	2024 оны хариулт
Үүрэн сүлжээ холбогдсон хэрэглэгчийн тоо	TC-TL-000.A	Number (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Үүрэн бүс сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн тоо	TC-TL-000.B	Number (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Өргөн зурвасын сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн тоо	TC-TL-000.C	Number (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Сүлжээний урсгалын эзлэхүүн	TC-TL-000.D	Petabytes (PB)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл

SASB нягтлан бодох бүртгэлийн метрикүүд

Сэдэв	SASB Код	Шаардлагатай метрик	Хэмжих нэгж	2024 оны хариулт
Үйл ажиллагааны байгаль орчинд үлдээж буй үл мөр	TC-TL-130a.1	(1) Нийт эрчим хүчний зарцуулалт	Гигажоул (ГЖ)	210,744
		(2) Нэгдсэн сүлжээний цахилгаан эрчим хүчний эзлэх хувь	Хувь (%)	80.2
		(3) Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	Хувь (%)	6.8
Мэдээллийн нууцлал	TC-TL-220a.1	Зан төлөвийн сурталчилгаа ба хэрэглэгчийн нууцлалтай холбоотой бодлого, үйл ажиллагаа	Тайлбар бичвэр	Юнител групп нь 2021 оны Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах талаарх дотоод бодлого, журмаа шинэчлэн баталсан. Энэ хүрээнд бид хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах шаардлагатай тохиолдолд хуулийн дагуу урьдчилан зөвшөөрөл авдаг. Юнител группийн хувьд бизнесийн үйл ажиллагаандаа хэрэглэгчдийн хувийн мэдээллийг хүндэтгэх, хамгаалахаас гадна хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, задруулахтай холбоотой холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөн ажилладаг.



Мэдээллийн нууцлал	ТС-TL-220a.2	Хоёрдогч зорилгоор мэдээллийг нь ашигласан хэрэглэгчдийн тоо	Тоо (#)	100 хувь буюу үйл ажиллагааны тайланд тусгасан нийт хэрэглэгч Юнител групп нь зөвшөөрлийн маягтад дурдсанчлан бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулах эсвэл зорилтот хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээгээ санал болгохын тулд хэрэглэгчийн зан төлөвийн шинжилгээ хийж, шаардлагатай мэдээллийг ашигладаг.
	ТС-TL-220a.3	Хэрэглэгчийн нууцлалтай холбоотой шүүх үйл ажиллагааны үр дүнд учирсан мөнгөн хохирол	сая төгрөгөөр	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
	ТС-TL-220a.4	(1) Хууль сахиулах байгууллагаас хэрэглэгчийн мэдээллийг авах тухай ирүүлсэн хүсэлтийн тоо	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(2) Хууль сахиулах байгууллагын хүсэлтэд хамрагдсан хэрэглэгчийн тоо	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(3) Хүсэлтийн дагуу мэдээллийг өгсөн хувь	Хувь (%)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Мэдээллийн аюулгүй байдал	ТС-TL-230a.1	(1) Мэдээллийн халдлагын тоо	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(2) Хувийн мэдээллийн эзлэх хувь	Хувь (%)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(3) Өртсөн хэрэглэгчдийн тоо	Тоо (#)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
	ТС-TL-230a.2	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлүүдийг таних, шийдвэрлэх	Тайлбар бичвэр	Бид мэдээллийн технологийн системийнхээ аюулгүй байдлыг хангахын тулд аливаа эрсдэлийг илрүүлэх арга хэмжээг байнга авдаг. Мөн одоо байгаа болон шинээр хэрэгжиж буй системийг үнэлэхийн тулд дотоод нэвтрэлтийн туршилтыг тогтмол хийдэг. Ингэснээр хэрэглэгчийн аюулгүй байдлыг бүрэн хангах ба гуравдагч байгууллагатай хамтран эрсдэлийн зөвлөх үйлчилгээг авч ажиллаж байна. Юнител групп нь ISO 27001 гэрчилгээ авсан ба дотооддоо бид NIST-ийн тогтолцоог баримтлан ажиллаж байна. Үүнээс гадна, бид одоогоор COBIT болон ITIL-ийг жишиг болгон хэрэгжүүлж буй.
Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент	ТС-TL-440a.1	(1) Бүтээгдэхүүн эргүүлэн татах хөтөлбөрийн хүрээнд татсан материалын тоо хэмжээ	Тонн (тн)	5.51

Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн менежмент	ТС-TL-440a.1	(2) Дахин ашиглахаар сэргээсэн материалын хувь	Хувь (%)	0
		(3) Дахин боловсруулахаар сэргээсэн материалын хувь		5.51
		Сэргээсэн материалын (4) Ландфилд оруулсан хувь		0
Өрсөлдөөн ба нээлттэй интернэт	ТС-TL-520a.1	Өрсөлдөөний эсрэг зан үйлийн зохицуулалттай холбоотой шүүх үйл ажиллагааны үр дүнд учирсан мөнгөн хохирлын нийт хэмжээ	сая төгрөг	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
				ТС-TL-520a.2
		(2) Бусад контентыг татаж авах сурталчилсан дундаж хурд	Мегабит/секунд (Mbps)	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
	ТС-TL-520a.3	Дараахтай холбоотой эрсдэл ба боломжуудыг хэлэлцэх <ul style="list-style-type: none"> net neutrality paid peering zero rating 	Тайлбар бичвэр	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
Системийн эрсдэлийн удирдлага	ТС-TL-550a.1	(1) Системийн дундаж тасалдлын давтамж	Саатал	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
		(2) үйлчилгээний тасалдлын дундаж хугацаа	Цаг	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл
	ТС-TL-550a.2	Үйлчилгээ тасалдах үед саадгүй үйлчилгээ үзүүлэх системүүдийн тухай	Тайлбар бичвэр	Нийтэд ил тод тайлагнахгүй мэдээлэл



Connect with Unitel LLC
UnitelGroup.mn/sustainability
sustainability@unitel.mn